




Save the Children

НАСАНД ХҮРЭГЧДИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН



**НАСАНД ХҮРЭГЧДИЙН
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ
МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 улсад хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага юм. Монгол Улсад 1994 онд салбараа нээсэн ба Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Боловсрол, Хүүхдийн ядуурлыг бууруулах, Хүмүүнлэг, Эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн амьдралд эрчимтэй, тогтвортой өөрчлөлт хийхийн төлөө ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн аргачлал, удирдамжийн дагуу
судалгааг гэрээлэн гүйцэтгэсэн: “Эм Эм Си Жи” ХХК

Хянан тохиолдуулсан: Энхбатын Цолмон
Энхболдын Жаргал
Судалгааны зөвлөх: Загирын Тогтохмаа

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол Улс дахь хөтөлбөрийн газар | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол Улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 | Цахим шуудан: mongolia.secretary@savethechildren.org | Судалгааны тайланг цахим хэлбэрээр www.savethechildren.mn вэб хуудаснаас авах боломжтой.

Улаанбаатар хот, Монгол Улс, 2023 он

АГУУЛГА

Өмнөх үг	9
Судалгааны хураангуй үр дүн.	10
Нэг. Удиртгал	14
Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоо	14
Судалгааны сэдэв сонгосон үндэслэл	16
Урьдчилсан фокус бүлгийн ярилцлага	18
Хоёр. Судалгааны арга зүй.	20
Судалгааны зорилго, зорилтууд	20
Судлах асуудлуудын хүрээ, тэдгээрийн хамаарал	20
Судалгааны дизайн	21
Судалгааны арга хэрэгслүүд.	21
Судалгааны хүн ам, түүвэр.	23
Судалгааны мэдээлэл цуглуулах бэлтгэл ажил	26
Судалгааны мэдээлэл цуглуулсан явц	26
Судалгааны ёс зүйн асуудлууд	27
Мэдээллийн чанарын хяналт	27
Гурав. Судалгааны үр дүн	28
Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж.	28
Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага	31
Хүүхдээсээ зохисгүй зүйл хүлээх хандлага	31
Хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх хандлага	32
Хүүхдэдээ үүргээ шилжүүлэх хандлага	33
Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг үл хүлээн зөвшөөрөх хандлага	34
Насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, дадал	36
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг	36
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх хандлага	39
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх дадал.	42
Хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх дадал хоорондын хамаарал	49
Хүүхэдтэй зүй бус харьцдаг хүмүүс.	50
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл тулгамдсан асуудлын нэг болох нь.	51
Хүүхэд хүчирхийлэлд өртдөг орчин	52
Хүүхэд хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй хүчин зүйл	53
Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах арга зам	55
Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал	56
Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг	56
Нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага, дадал	60
Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх мэдлэг, хандлага, дадал	63
Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхэд тулгарч буй саад бэрхшээл.	66
Өөрийгөө хамгаалах талаар хүүхдэдээ өгдөг мэдээлэл.	67

Хүүхэд хамгаалалд насанд хүрэгчдийн оролцоо	71
Хүүхэд хамгаалалд аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоо	72
Дөрөв. Судалгааны дүгнэлт, санал зөвлөмж	74
Ном зүй	79
Хавсралт	81
Хавсралт 1. Өмнөх судалгааны тойм.	81
Хавсралт 2. Насанд хүрэгчдээс авсан асуулга	91
Хавсралт 3. Насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагын удирдамж.	106
Хавсралт 4. Хорооны нийгмийн ажилтантай хийсэн фокус бүлгийн ярилцлагын удирдамж	109
Хавсралт 5. Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын удирдамж	112
Хавсралт 6. Хэсгийн байцаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын удирдамж	115
Хавсралт 7. Сургуулийн нийгмийн ажилтан, багштай хийсэн ганцаарчилсан ярилцлагын удирдамж	118
Хавсралт 8. Хүүхдээс зохисгүй зүйл хүлээх хандлагатай санал нийлж буй байдал (хувь)	121
Хавсралт 9. Хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх хандлагатай санал нийлж буй байдал (хувь)	123
Хавсралт 10. Хүүхдэдээ үүргээ шилжүүлэх хандлагатай санал нийлж буй байдал (хувь)	125
Хавсралт 11. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг үл хүлээн зөвшөөрөх хандлагатай санал нийлж буй байдал (хувь).	127
Хавсралт 12. Бие махбодын хүчирхийллийн талаарх мэдлэг (хувь)	129
Хавсралт 13. Бэлгийн хүчирхийллийн талаарх мэдлэг (хувь)	130
Хавсралт 14. Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх мэдлэг (хувь).	131
Хавсралт 15. Үл хайхрах хүчирхийллийн талаарх мэдлэг (хувь).	132
Хавсралт 16. Бие махбодын хүчирхийллийн талаарх хандлага (дундаж)	133
Хавсралт 17. Бэлгийн хүчирхийллийн талаарх хандлага (дундаж)	134
Хавсралт 18. Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх хандлага (дундаж)	135
Хавсралт 19. Үл хайхрах хүчирхийллийн талаарх хандлага (дундаж)	136
Хавсралт 20. Хүүхдийн эсрэг бие махбодын шийтгэл хэрэглэх дадал (хувь)	138
Хавсралт 21. Хүүхдийн эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх дадал (хувь)	139
Хавсралт 22. Хүүхдийн эсрэг үл хайхрах хүчирхийлэл үйлдэх дадал (хувь).	140
Хавсралт 23. Хүүхэд хамгааллын талаарх бодит мэдлэг	141
Хавсралт 24. Нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага (хувь).	144
Хавсралт 25. Нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлагад хийсэн хамаарлын шинжилгээний үр дүн	145
Хавсралт 26. Хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэрхэн хамгаалах, хэнд мэдээлэх талаарх үнэн ба худал бодомжууд (хувь)	146
Хавсралт 27. Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл хаана, хэнд мэдээлэх ёстойг мэдэх тухай	149
Хавсралт 28. Хүчирхийллийг мэдээлэхэд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээ	150
Хавсралт 29. Хүүхэд хүчирхийлэлд өртсөнийг мэдсэн ч мэдээлээгүй байдалд хийсэн хүчин зүйлийн шинжилгээ	150

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГБХТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГЯ	Ганцаарчилсан ярилцлага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МХД	Мэдлэг, хандлага, дадал
НД	Налайх дүүрэг
НГБХЗХГ	Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУ	Олон улс
ОУБ	Олон улсын байгууллага
ОУЭ	Олон улсын эвсэл
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ТББ	Төрийн бус байгууллага
УБ	Улаанбаатар
ХУД	Хан-Уул дүүрэг
ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
ХИС	Хүүхдийг Ивээх Сан
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ЧД	Чингэлтэй дүүрэг

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.	Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсийн харьцаа	28
График 2.	Хүүхдээс зохисгүй зүйл хүлээх хандлагыг тодруулах бодомжуудтай санал нийлж буй байдал	31
График 3.	Хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх хандлагуудтай санал нийлж буй байдал	32
График 4.	Хүүхдэдээ үүргээ шилжүүлэх хандлагуудтай санал нийлж буй байдал	33
График 5.	Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг үл хүлээн зөвшөөрөх хандлага	34
График 6.	Насанд хүрэгчдийн хүчирхийллийн хэлбэрүүдийн талаарх мэдлэг	36
График 7.	Бие махбодын хүчирхийллийн талаарх мэдлэг	37
График 8.	Бэлгийн хүчирхийллийн талаарх мэдлэг	37
График 9.	Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх мэдлэг	38
График 10.	Үл хайхрах хүчирхийллийн талаарх мэдлэг	39
График 11.	Хүчирхийлэл үйлдэх дадал	42
График 12.	Хүчирхийллийн бус арга хэрэглэх дадал	48
График 13.	Хүүхэдтэй зүй бус харьцдаг хүмүүс (хувь)	50
График 14.	Хүүхдэд тулгарч асуудал (хувь)	51
График 15.	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдийг хамгаалах хамгийн сайн арга зам (хувь)	55
График 16.	Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг (бодит, өөрийн үнэлгээ)	56
График 17.	Хүүхдийг хэн хамгаалах ёстой талаарх насанд хүрэгчдийн санаа бодол	60
График 18.	Нийгмийн орчинд хүүхэд хамгаалах хандлага, дадал (хувь)	61
График 19.	Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл хаана, хэнд мэдээлэх ёстойг мэдэх байдал	64
График 20.	Сүүлийн нэг жилд хүүхэд хүчирхийлэлд өртөж буйг мэдээд ямар нэгэн арга хэмжээ авсан байдал	64

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд тодорхойлсон хүүхэд хамгааллын тогтолцоо, орчин	15
Зураг 2.	Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн оролцогч талуудын харилцан хамаарал	16
Зураг 3.	Судлах асуудлын хүрээ, хамаарал	20
Зураг 4.	Судалгааны мэдээлэл цуглуулах бэлтгэл ажлууд	26
Зураг 5.	Судалгаанд оролцогчид (дүүргээр)	28
Зураг 6.	Судалгаанд оролцогчдын сууцны төрөл	28
Зураг 7.	Хүүхдүүдийн хүчирхийлэлд өртөж буй орчин, хүчирхийллийн хэлбэрүүдээр	52
Зураг 8.	Нийтийн тээврийн унаанд хүүхдүүд хүчирхийлэлд өртөж буй байдал	53
Зураг 9.	Насанд хүрэгчдийнхээр хүүхэд хамгаалал гэж...	59
Зураг 10.	Хүчирхийллийг мэдээлэхэд гарах саад бэрхшээл	66
Зураг 11.	Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдийнхээр хүүхдэд өгөх ёстой мэдээлэл зөвлөгөө	69
Зураг 12.	Насанд хүрэгчид хүүхдийг хамгаалахад хэрхэн оролцож болох тухай тэдний өөрсдийнх нь санаа	72

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Урьдчилсан фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл	18
Хүснэгт 2.	Судалгааны дизайн	21
Хүснэгт 3.	Судалгааны түүврийн хэмжээ (судалгааны аргуудаар)	23
Хүснэгт 4.	УБ хотын 18-аас дээш насны хүн амын тоо болон судалгаанд оролцогчдын тоо	24
Хүснэгт 5.	Насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага	25
Хүснэгт 6.	Ганцаарчилсан ярилцлагад оролцсон мэргэжилтнүүд	25
Хүснэгт 7.	Судалгаанд оролцогчдын гэр бүлийн хэв шинж	29
Хүснэгт 8.	Судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхлэлтийн байдал	30
Хүснэгт 9.	Судалгаанд оролцогчдын хувийн болон өрхийн орлого	30
Хүснэгт 10.	Бие махбодын хүчирхийллийн талаарх хандлага	40
Хүснэгт 11.	Бэлгийн хүчирхийллийн талаарх хандлага	40
Хүснэгт 12.	Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх хандлага	41
Хүснэгт 13.	Үл хайхрах хүчирхийллийн талаарх хандлага	41
Хүснэгт 14.	Сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхдийн эсрэг үзүүлсэн бие махбодын шийтгэл (хувь)	43
Хүснэгт 15.	Хүүхдийн эсрэг бие махбодын түгээмэл шийтгэл (хүүхдийн нас, хүйс, хувь)	43
Хүснэгт 16.	Хүүхдээ зодож шийтгэж болохгүйг мэддэг ч үйлддэгийн шалтгаан	44
Хүснэгт 17.	Сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхдэдээ үзүүлсэн сэтгэл санааны хүчирхийлэл (хувь)	46
Хүснэгт 18.	Хүүхдийн эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх дадал (хувь)	46
Хүснэгт 19.	Сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхдэдээ үзүүлсэн үл хайхрах хүчирхийлэл (хувь)	47
Хүснэгт 20.	Хүүхдийн эсрэг үл хайхрах хүчирхийлэл үйлдэх дадал (хувь)	47
Хүснэгт 21.	Хүчирхийллийн бус арга хэрэглэх дадал (хувь)	49
Хүснэгт 22.	Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд нөлөөлж буй хүчин зүйл	54
Хүснэгт 23.	Хүүхэд хамгааллын мэдлэг (хувь)	57
Хүснэгт 24.	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних байдал	58
Хүснэгт 25.	Насанд хүрэгчид хүүхэд хамгааллыг ойлгож буй байдал	59
Хүснэгт 26.	Нийгмийн орчинд хүүхэд хамгаалах хандлага, дадал (хувь)	61
Хүснэгт 27.	Хүчирхийллийг мэдээлэхтэй холбоотой мэдлэг	63
Хүснэгт 28.	Хүүхэд хүчирхийллийг хэнд мэдээлэх талаарх мэдлэг, хандлага, дадал (хувь) . .	65
Хүснэгт 29.	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхэд тулгарч буй саад бэрхшээл (хувь) . .	66
Хүснэгт 30.	Хүүхдэдээ өөрийгөө хамгаалах талаар өгдөг насанд хүрэгчдийн мэдээлэл зөвлөгөө	68
Хүснэгт 31.	Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах талаарх мэдээлэл авдаг сувгууд	70

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл	Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ (Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016).
Бие махбодын хүчирхийлэл	Хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг бие махбодын хүчирхийлэл гэнэ (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016).
Бэлгийн хүчирхийлэл	Эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016).
Сэтгэл санааны хүчирхийлэл	Хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016).
Үл хайхрах хүчирхийлэл	Хүүхэд, түүний бие махбод, сэтгэл санааны хувьд аюулгүй байх, хөгжих эрхийг санаатай хийгээд санамсаргүйгээр хангаагүй, баталгаатай хамгаалж чадаагүй нөхцөл (ХИС-гийн Хүүхэд хамгааллын бодлого).
Хүүхэд хамгаалал	Хүүхэд хамгаалал нь нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ (Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016).
Мэдлэг, хандлага, дадлын судалгаа	Тодорхой бүлгийн хүн ам тодорхой нэг асуудлаар ямар мэдлэгтэй, юу бодож мэдэрдэг, ямар үйлдэл гаргадаг талаарх мэдээлэл (ХИС-гийн ОУ-ын эвсэл, 2021).
Мэдлэг	Тодорхой сэдвийн талаарх хүүхдийн болон насанд хүрэгчдийн ойлголт, мэдлэгийн түвшин (ХИС-гийн ОУ-ын эвсэл, 2021).
Хандлага	Тодорхой сэдэв, асуудлын талаар хүүхэд, насанд хүрэгчдийн үзэл бодол, тэрхүү үзэл бодолд нь нөлөөлж буй мэдлэг, итгэл үнэмшил (ХИС-гийн ОУ-ын эвсэл, 2021).
Дадал	Тодорхой сэдэв, асуудлын талаарх мэдлэг, хандлагаа үйлдэл болгон хэрэгжүүлэх арга зам (ХИС-гийн ОУ-ын эвсэл, 2021).
Статистик ач холбогдол	Тохиолдлоор гараагүй байх магадлалтай үр дүн. Хэрэв тэг таамаглал зөв бол магадлалын боломж нь 0.05–аас бага байх босгыг статистикийн ач холбогдолтой гэж үздэг. Үүнийг хэмжихэд ашигладаг “р” тоог статистикийн шинжилгээгээр гаргана (ХИС-гийн ОУ-ын эвсэл, 2021).

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан хүүхэд хамгааллыг сайжруулахын тулд хүүхэд, асран хамгаалагч, бусад насанд хүрэгчид болон төрийн байгууллагын мэдлэг, хандлага, дадал, зан үйлийг өөрчлөхөд голлон анхаарч ажилладаг. Бидний үйл ажиллагааны ихэнх хэсэг нь нийгмийн хэм хэмжээнд нөлөөлөх, бүх хэлбэрийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, зүй бус харьцаа, мөлжлөгөөс хүүхдийг хамгаалахын тулд хүчирхийллийг нийгмээрээ үл тэвчих хандлагыг бий болгож, хүний эрхийн соёлыг хөгжүүлж, нийгэмд өөрчлөлт авчрахад чиглэдэг билээ.

Зорьсон үр дүндээ хүрэхийн тулд хөтөлбөрийнхөө хүүхдийн амьдралд үзүүлж буй үр нөлөө, дэвшлийг хэмжиж ажиллах ёстой байдаг. Бид хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад цуглуулсан мэдээллийн чанарыг сайжруулах үүднээс хүүхэд хамгааллын асуудлаар мэдлэг, хандлага, дадлын судалгааг хийсэн бөгөөд энэ нь манай улсын хүүхэд хамгааллын салбарын судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын чанарыг бэхжүүлж, баримт нотолгоонд суурилсан хүүхэд хамгаалалд нэг алхам өөрчлөлт оруулна гэж итгэж байна.

“Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал” хэмээх энэхүү судалгаа нь Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгааллын хөтөлбөрөөс НҮБ-ын Итгэлцлийн Сангийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлж буй “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн хүрээнд хийсэн судалгаануудын нэг юм. Уг судалгааг Хүүхдийг Ивээх Сангийн Олон Улсын Эвслээс 2012 онд боловсруулсан “Мэдлэг, хандлага, дадлын асуулгын судалгааг хүүхэд хамгааллын салбарт хэрэглэх нь” хэмээх алхамчилсан зөвлөмжийн дагуу манай мэргэжил, арга зүйн удирдлага дор “Эм Эм Си Жи” ХХК гүйцэтгэлээ.

Судалгаанд олон талын оролцоог хангах зорилгоос гадна судалгааны сэдэв хүрээг тодорхойлох, судалгааны протокол боловсруулах, тайлан гаргахад санал зөвлөмж өгөх, судалгааны үр дүнг түгээхэд хамтран ажиллахын тулд “Судалгааны зөвлөх хороо” байгуулж, бүрэлдэхүүнд нь Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, Нийслэлийн Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, Хүүхдийг Ивээх Сангийн төлөөллийг багтаасан билээ. Уг зөвлөх хорооны гишүүд 2022 оны 11 дүгээр сарын 23-нд уулзаж судалгааны сэдвийг хэлэлцэн шийдвэрлэсэн бол мөн оны 12 дугаар сарын 19-ний өдөр дахин уулзаж судалгааны протокол (судалгааны зорилтууд, арга зүй, арга хэрэгсэл)-ыг хэлэлцэн, санал зөвлөмж өгсөн. Судалгааны урьдчилсан үр дүнг хэлэлцэх уулзалтыг 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хийж, уулзалтаас гарсан асуулт, санал зөвлөмжийг тусган судалгааны тайланг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр эцэслэсэн болно.

Тус судалгаанд оролцсон бүх талд гүн талархал илэрхийлж байна.

Энхбатын Цолмон
ХИС-гийн Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрүүдийн менежер

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ҮР ДҮН

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодруулах зорилготой уг судалгааг 1) насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлагыг илрүүлэх; 2) насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх; 3) насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодруулах гэсэн зорилтын хүрээнд хийв.

Энэхүү судалгаанд тоон болон чанарын аргыг хослуулсан холимог дизайн бүхий арга зүйг хэрэглэж, Улаанбаатар хотын есөн дүүргийн зорилтот хүн амаас мэдээлэл цуглуулсан болно. Тодруулбал, 18-аас дээш насны 1,202 насанд хүрэгчээс асуулгын аргаар тоон мэдээлэл цуглуулсан. Харин фокус бүлгийн ярилцлагыг 32 насанд хүрэгчийг хамруулан найман ялгаатай бүлгээр хийснээс гадна найман хорооны нийгмийн ажилтнаас мөн уг аргаар мэдээлэл цуглуулав. Түүнчлэн, ерөнхий боловсролын сургуулийн багш, цэцэрлэгийн эрхлэгч, хэсгийн байцаагч, хүүхэд хамгааллын дунд түвшний байгууллагын мэргэжилтнээс бүрдсэн 15 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн. Нийтдээ 55 хүнээс чанарын мэдээлэл цуглуулсан. Судалгааны гол үр дүнг хураангуйлан танилцуулъя.

Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага

- Насанд хүрэгчдийн дунд хүүхдээсээ зохисгүй зүйл хүлээх хандлага түгээмэл байна. Энэ нь судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлт, амьдардаг байршил, сууцны төрөл гэх мэтээс үл хамааран бүх оролцогчийн хувьд адил байна. Ялангуяа “хүүхдийг дуулгавартай, эцэг эхийнхээ үгийг дагадаг болгож хүмүүжүүлэх хэрэгтэй”, “Одоогийн хүүхдүүд бүх юм нь бэлэн, жаргалтай өсөж байна” гэсэн хандлага судалгаанд оролцогчдын дунд түгээмэл байна.
- Насанд хүрэгчдийн дунд хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх хандлага түгээмэл байна. Тухайлбал, “эцэг эх нь хүүхэдтэйгээ ярилцвал тэдний гомдлыг л сонсоно” гэх хандлагатай судалгаанд оролцогчдын 49 хувь нь санал нийлж байгаа бол “хүүхэд анхаарал татахын тулд л уйлдаг” гэдэгтэй 44 хувь нь санал нийлж байна. Харин “эрэгтэй хүүхэд уйлах нь сул доройн шинж” гэх хандлагыг судалгаанд оролцогчид нийтээрээ хүлээн зөвшөөрөхгүй байх талтай боловч үүнийг дэмжиж буй цөөн хүний дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.
- Насанд хүрэгчдийн дунд өөрсдийн үүргээ хүүхдүүдэдээ шилжүүлэх хандлага түгээмэл байгаа бөгөөд энэ нь тэдний нас, хүйс, боловсрол, амьдардаг байршил гэх мэтээс үл хамааран ижил байна. “Хүүхдүүд гэртээ эмх цэгцтэй, томоотой байвал эцэг эх нь тайван байна”, “айлын том хүүхдүүд дүү нараа асрах ёстой”, “эцэг эх нь ядарсан байгааг хүүхдүүд нь мэддэг байх ёстой” гэх хандлагатай судалгаанд оролцогчдын тэн хагасаас дээш хувь нь санал нийлж байна. Эцэг эх нь хүүхдүүдээсээ дүү нараа асрахыг байнга шаарддагаас тухайн хүүхдүүдийн суралцах, найз нөхөдтэйгөө хамт байх, өөртөө зарцуулах бусад цаг багасдаг гэдэг нь энэ судалгааны хүрээнд хүүхдүүдтэй хийсэн урьдчилсан фокус бүлгийн ярилцлагаас харагдсан. Тэгэхээр насанд хүрэгчдийн хувьд хүүхдэдээ ямар үүргээ, хэр хэмжээгээр шилжүүлж байгаагаа ухамсартайгаар бодож эргэцүүлэх, хүүхдүүдтэйгээ ярилцаж, тэдэнд ямар байгааг нь асууж мэдэх, асуудал байвал шийдэх талаас нь анхаарах шаардлагатай.
- Насанд хүрэгчдийн хувьд хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг нь хүлээн зөвшөөрч, дэмжих эерэг хандлагатай байна. Гэвч судалгаанд оролцогчдын тэн хагас нь “хүүхдэд үзэл бодлоо илэрхийлэх боломж олгож байна гээд эцэг, эхийнхээ өөдөөс тайлбар тавихыг нь зөвшөөрөх ёсгүй” гэсэн хандлагыг хүлээн зөвшөөрч байгаа нь анхаарал

татаж байна. Энэ нь насанд хүрэгчдийн дунд хүүхдээ сонсохгүй байх, хүүхдийн тайлбарыг “давхарлаа, олон юм ярилаа, илүү үгтэй” гэж ойлгох хандлагатай байгааг илтгэх талтай. Өөрөөр хэлбэл, “тайлбар тавилаа” гэх хандлагаар насанд хүрэгчид хүүхдээ сонсдоггүй, хүүхэдтэйгээ ярилцдаггүй байна.

Насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, дадал

- Насанд хүрэгчдийн хувьд 10 хүн тутмын 5-6 нь сэтгэл санаа, бие махбод, бэлгийн хүчирхийллийн талаар хангалттай мэдлэгтэй байгаа хэдий ч 10 хүн тутмын 7 нь үл хайхрах хүчирхийллийн талаар хангалттай мэдлэггүй байна. Анхаарал татсан нэг үр дүн бол бэлгийн хүчирхийллийн талаар огт мэдлэггүй насанд хүрэгчид бусад төрлийн хүчирхийллийн талаар мэдлэггүй насанд хүрэгчдээс их байна. Нарийвчлан үзвэл, бага боловсролтой, ажил эрхэлдэггүй, алслагдсан дүүрэг, гэр хороололд амьдардаг эрэгтэйчүүд бэлгийн хүчирхийллийн талаар мэдлэггүй байна.
- Насанд хүрэгчдийн 40 орчим хувь нь бие махбодын хүчирхийллийг дэмжих хандлагатай байна. Бие махбодын хүчирхийллийг дэмжих хандлагатай хүмүүс голдуу “багадаа аав ээждээ зодуулж өссөн, тэглээ гээд буруудсан зүйл алга” гэх үзэл бодлыг дэмжиж байна.
- Бэлгийн хүчирхийллийг насанд хүрэгчдийн олонх буюу 65 хувь нь эрс эсэргүүцэх хандлагатай боловч үлдсэн хувийнх нь хандлага сул байна. Ялангуяа 18-31 насныхны 44 хувь нь “охид өмсөж буй хувцас, хийж буй үйлдлээсээ болоод бэлгийн хүчирхийлэлд өртдөг” гэх хандлагатай санал нийлж байгааг анхаарах хэрэгтэй.
- Насанд хүрэгчдийн 67 хувь нь сэтгэл санааны хүчирхийллийг үл дэмжих эерэг хандлагатай байна. Гэвч 51-ээс дээш насны, эмэгтэй, боловсролын түвшин багатай хүмүүс сэтгэл санааны хүчирхийллийг эрс эсэргүүцэх хандлага сул байна.
- Судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь үл хайхрах хүчирхийллийг эрс эсэргүүцэх эерэг хандлагатай байна. Нэн ялангуяа насанд хүрэгчдийн 90 орчим хувь нь хүүхдийн дэргэд архи хэрэглэх нь үл хайхрах хүчирхийлэл гэж бүрэн хүлээн зөвшөөрөх хандлагатай байна. Өмнөх үр дүнтэй холбон үзвэл, насанд хүрэгчид үл хайхрах хүчирхийллийн талаар мэдлэг багатай боловч хандлага нь эерэг байна. Иймд тэдний мэдлэгийг дээшлүүлбэл хандлага нь улам эерэг болж, улмаар дадал нэмэгдэх, бэхжихэд нөлөөлнө.
- Насанд хүрэгчдийн 73-87 хувь нь хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл хэзээ ч үйлдэж байгаагүй гэж хариулжээ. Харин өнгөрсөн нэг жилд хүүхдэд бие махбодын шийтгэл хүлээлгэсэн эцэг эх, асран хамгаалагчдын хувьд 1-2 удаа хүүхдийг өшиглөх, толгой руу нь цохих үйлдэл гаргасан гэжээ. Нэн ялангуяа бага насны, эрэгтэй хүүхдүүд бие махбодын шийтгэл амсах нь элбэг байна. Хүүхдийг зодож шийтгэх нь буруу гэдгийг мэддэг боловч уг үйлдлийг хийдгийн гол шалтгаан нь насанд хүрэгчдийн хувьд үүнийг хүмүүжлийн арга мөн гэж хүлээн зөвшөөрдөгтэй холбоотой байна. Өмнө дурдсанчлан, насанд хүрэгчдийн 40 хувь бие махбодын хүчирхийллийг хүлээн зөвшөөрөх хандлагатай буюу “аав, ээждээ зодууллаа гээд буруудаагүй” гэх хандлагыг дэмжих талтай байсан бөгөөд энэ нь тэдний дадалтай хамаатай байна.
- Насанд хүрэгчдийн 44-87 хувь нь хүүхдийг хэзээ ч сэтгэл санааны хувьд хүчирхийлэх үйлдэл гаргаж байгаагүй гэжээ. Харин өнгөрсөн нэг жилийн хугацаанд ийм үйлдэл гаргасан хүмүүсийн хувьд хүүхдийг загнах, хочлох, харьцуулах хэлбэрээр хэрэглэсэн байна.
- Судалгаанд оролцогчдын 65-91 хувь нь хүүхдийг хэзээ ч үл хайхарч байгаагүй гэсэн бол 5-6 хувь нь өнгөрсөн жил ийм үйлдэл гаргаагүй гэжээ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд 1-2 удаа “хараа хяналт тавиагүйгээс хүүхдээ бэртээсэн” гэж нийт эцэг эх, асран хамгаалагчийн 14 хувь мэдүүлжээ. Мөн “хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэсэн” гэж насанд хүрэгчдийн 13 хувь нь тус тус хариулсан байна. Гэхдээ олон удаагийн давтамжтай үйлдэх нь бага байна. Хэдийгээр хүүхдийн хажууд “гэртээ архи, тамхи хэрэглэх нь байх л зүйл” гэх хандлагыг насанд хүрэгчдийн 90 орчим хувь нь хүчтэй эсэргүүцэх хандлагатай байсан ч энэхүү үйлдлийг гаргадаг нь харагдаж байна.
- Түүнчлэн, хүчирхийллийн бус арга хэрэглэх насанд хүрэгчдийн дадлыг тандахад, 22-38 нь

байнга ийм арга хэрэглэдэг гэжээ. Хүчирхийллийн бус аргуудыг огт хэрэглэж байгаагүй гэж хариулсан хүмүүс 3-8 хувийг эзэлж байна.

- Насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийллийн мэдлэг, хандлагын түвшин ойролцоо байна. Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага сайтай боловч дадал нь сул буюу хүүхдэдээ сэтгэл санааны хүчирхийлэл үзүүлэх талтай байна. Үл хайхрах хүчирхийллийн талаарх мэдлэг сул мөртлөө хандлага эерэг байна. Хүүхдийн эсрэг бие махбодын, сэтгэл санааны, үл хайхрах хүчирхийлэл үйлдэх дадал нь хоорондоо хүчтэй хамааралтай бөгөөд энэ нь аль нэг хэлбэрийн хүчирхийллийг үйлддэг бол нөгөө хэлбэрүүдийн хүчирхийллийг ч мөн үйлддэг гэсэн үг. Тиймээс аль нэг сөрөг дадлыг бууруулахад бусад сөрөг дадал үйлдэгдэх нь дагаад багасах талтай тул үүнийг шийдвэр гаргагчид болон хэрэгжүүлэгчид анхаарах хэрэгтэй.

Насанд хүрэгчдийн хүүхдийн хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал

- Насанд хүрэгчдийн 10 хүн тутмын 7 нь өөрийгөө хүүхэд хамгааллын талаар хангалттай мэдлэгтэй гэж үздэг бол бодит байдалд 10 хүний 4 нь л хангалттай мэдлэгтэй байна. Үүнээс судалгаанд оролцогчдын өөрсдийн үнэлгээ болон бодит мэдлэгийн түвшин нэлээд зөрүүтэй байгааг харж болно. Насанд хүрэгчдийн мэдлэгийн зөрүү нь насны бүлэг, боловсрол, ажил эрхлэлт, амьдардаг байршил, сууц, гэрлэлтийн байдал, өөрийн болон бусдын хүүхэдтэй амьдардаг эсэхээр ялгаатай байна.
- Насанд хүрэгчдийн 10 хүн тутмын 9 нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдвэл мэдээлэх үүргийг бүх хүн хүлээнэ гэж мэддэг ч 10 хүн тутмын 4-6 нь хэнд, хэрхэн хандах талаар үнэн зөв мэдлэггүй байна. Гэвч насанд хүрэгчдийн өөрсдийнх нь үзэж байгаагаар 10 хүн тутмын 9 нь хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана, хэнд хандахыг мэднэ гэж хариулсан байна. Үүнээс тэдний өөрсдийн үнэлгээ, бодит мэдлэг зөрүүтэй байгаа нь харагдаж байгаа бөгөөд тэдний мэдлэгийг залруулах шаардлага байна. Тодруулбал, хүүхдийн эсрэг хүчирхийллийг зөвхөн 108 дугаарт эсвэл нийгмийн ажилтан болон багшаар дамжуулан мэдээлэх ёстой гэсэн буруу ойлголтыг залруулах хэрэгтэй.
- Насанд хүрэгчдийн 10 хүн тутмын 8-9 нь гудамж талбай гэх мэт нийгмийн орчинд бусдын хүүхэд ямар нэг зүй бус үйлдэл, хүчирхийлэлд өртөж байвал хамгаалах арга хэмжээ авах эерэг хандлагатай боловч яг тийм үйлдэлтэй таараад, хамгаалах арга хэмжээ авч байсан дадал нь харьцангуй сул байна. Энэ нь насанд хүрэгчдийн хувьд үл хайхрах хүчирхийллийн талаарх мэдлэг хангалтгүй байгаагаас тийм үйлдлийг анзаарахгүй байх, анзаарлаа ч хамгаалах ямар нэг арга хэмжээ авах дадал сул буйг илтгэж байна.
- Хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана, хэнд хандахаа мэднэ гэж хариулсан оролцогчдоос хаана, хэнд мэдээлэх вэ гэж нээлттэйгээр асуухад 10 хүн тутмын 8 нь хүүхдийн тусламжийн 108 дугаарт хандана гэж хариулсан бол 10 хүн тутмын 6 нь цагдаад хандана гэжээ. Харин ирээдүйд хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл 10 хүн тутмын 7 нь хүүхдийн тусламжийн 108 дугаарт, 10 хүн тутмын 6 нь цагдаад мэдэгдэнэ гэжээ. Үүнээс хүүхдийн эсрэг хүчирхийллийг хэнд мэдээлэх талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага нь ойролцоо байна. Харин сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхэд хүчирхийлэлд өртсөнийг мэдээд, мэдээлэл өгсөн 10 хүн тутмын 5 нь хүүхдийн тусламжийн 108 дугаарт, 10 хүн тутмын 3 нь цагдаад хандсан байна. Үүнээс үзвэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг хэн нэгэнд мэдээлсэн дадал нь мэдлэг, хандлагатай харьцуулбал сул байна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхэд тулгарч болох бэрхшээлүүдийг насанд хүрэгчдээс тандахад, тэдний дунд “бусдын хувийн асуудалд оролцох нь буруу”, “хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлбэл тухайн хүүхдэд улам муу зүйл болох вий гэсэн айдас”, “мэдээлбэл цагдаагаар явах гэх мэт бөөн чирэгдэл болох байх гэсэн болгоомжлол”, “хүүхдийн эсрэг хүчирхийлэл биш байвал яана гэсэн болгоомжлол” судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 5-6-д нь байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх мэдлэгийн талаарх

асуултуудаас үзэхэд, “хүчирхийллийн талаар өгсөн мэдээлэл батлагдаагүй эсвэл буруу байвал мэдээлэл өгсөн хүн буруутан болно” гэж насанд хүрэгчдийн 55 хувь нь буруу ойлгож байсан. Үүнээс насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхтэй холбоотой мэдлэггүй байдал нь тэдэнд хүчирхийллийг мэдээлэхэд саад болж байгааг харж болно. Эдгээр тоон үр дүн нь чанарын судалгааны дүнгээр мөн баталгаажиг байгаа бөгөөд цаашид эдгээр саад бэрхшээл бодит байдалд байгаа бол арилгах эсвэл байхгүй ч гэсэн насанд хүрэгчид ингэж боддог бол тэрхүү ташаа ойлголтыг залруулах чиглэлээр ажиллах шаардлагатай.

- Бусдыг ялгаварлахгүй байх, үе тэнгийнхнээ дээрэлхэхгүй байх, бусдыг хүндэлж хайрлах тухай мэдээлэл зөвлөгөөг насанд хүрэгчид хүүхдэдээ өгөх ёстой гэж хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд үзэж байхад эцэг эх, асран хамгаалагчдын хувьд эдгээр мэдээллийг хүүхдэдээ өгдөггүй байх талтай байна. Энэ нь ялгаварлан гадуурхалт, үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийн талаар эцэг эхчүүд төдийлөн мэдээлэлгүй учраас өгдөггүй байж болно. Урьдчилсан фокус бүлгийн ярилцлагаар үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийн асуудал тэдэнд тулгардаг талаар хүүхдүүд мэдээлсэн, гэвч хүүхдүүдийн мэдээллийн гол эх сурвалж болсон эцэг эх, асран хамгаалагч нь энэ талаар мэдээлэл өгдөггүй нь анхаарал татаж байна. Иймд эцэг эхчүүдэд энэ талын мэдээлэл өгөх чиглэлээр ажиллах хэрэгтэй.
- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ өгдөг хүүхэд хамгааллын мэдээллээ хаанаас авдаг талаар тодруулахад, 10 хүн тутмын 5-6 нь фейсбүүк болон телевизийг нэрлэжээ. Тэгэхээр хүүхэд хамгааллын талаар олон нийтэд мэдээлэл түгээхдээ дээрх сувгуудыг анхаарах хэрэгтэй байж болно. Гэвч эцэг эх, асран хамгаалагчдын мэдээлэл авч буй фейсбүүк, юутүб, инстаграм нь мэргэжлийн байгууллагынх эсэх нь мэдэгдэхгүй байна. Фейсбүүк зэрэг социал медиад буруу, ташаа мэдээлэл байх талтай тул ямар социал медиа хаягаас үнэн зөв мэдээлэл авах талаар насанд хүрэгчдэд мөн ойлгуулах шаардлагатай.
- Эцэг эх асран хамгаалагчид хүүхдэдээ өөрийгөө хамгаалах талаарх мэдээлэл зөвлөгөө өгөхдөө 23 хувь нь “танихгүй хүнтэй ярьж болохгүй” гэж хүүхдэдээ зөвлөдөг байна. Энэ нь нэг талаар хүүхдэд хэрэгтэй мэдээлэл зөвлөгөө байж болох ч нөгөө талаар хүүхэд хүчирхийлэл, зүй бус үйлдэлд өртөх болон өртсөн үед бусад хүнээс тусламж хүсэхгүй байх эрсдэл үүсгэж болзошгүй. Түүнчлэн, эрэгтэйчүүд хүүхдүүдэдээ анхаарал болгоомжтой байх, ямар ч зүйл тохиолдсон өөрийгөө хамгаалаад гардаг байх, шөнө оройн цагаар гадуур явахгүй байх зэргийг зөвлөдөг бол эмэгтэйчүүд хүүхдүүддээ танихгүй хүнтэй ярихгүй байх, ямар ч асуудал тулгарсан аав, ээждээ хэлэхийг анхааруулдаг байна.
- Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал нь өөр хоорондоо харилцан холбоотой байна. Жишээ нь, насанд хүрэгчдийн нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага нь хэр сайн байна, төдий хэмжээгээр дадал сайн, мөн хүүхэд хамгааллын талаар хангалттай сайн мэдлэгтэй хүмүүс нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага сайтай байгаа нь тогтоогдсон. Нөгөө талаас насанд хүрэгчдийн хүчирхийллийн зарим хэлбэрийн талаарх мэдлэг сул байгаагаас түүнийг хүчирхийлэл гэж танихгүй байх, ийм болохоор хандлага тааруу, улмаар хамгаалах ямар нэг үйлдэл хийх нь сул байгааг харуулж байна.
- Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдсэн тохиолдолд хаана, хэнд мэдээлэх талаар мэдлэгтэй хүмүүс мөн нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага сайтай байна.
- Сүүлийн нэг жилийн хугацаанд хүчирхийлэлд хүүхэд өртөж байгаатай таарч холбогдох хүмүүст мэдээлсэн оролцогчдыг нарийвчлан харвал, ажил эрхэлдэг, гэр хороололд амьдардаг хүмүүсийн хувьд бусдаас илүүтэй мэдээлэх үйлдэл хийж байна. Түүнчлэн, хүчирхийллийг хаана, хэнд мэдээлэхээ мэддэг, мэдээлэх олон сувгууд нэрлэж чадаж байгаа хүмүүс эсрэг бүлгийнхээ хүмүүсээс 6.9 дахин илүүгээр хүчирхийллийг мэдээлэх хандлага, дадалтай байна.

> МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 60 орчим хууль тогтоомжид хүүхдийн эрх, хамгааллын асуудлыг шууд болон шууд бус байдлаар зохицуулсан байдаг. Эдгээрээс эрүүгийн, захиргааны, хөдөлмөрийн, гэр бүлийн, боловсролын, эрүүл мэндийн, нийгмийн халамжийн түүнчлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд 10 гаруй хуульд хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх агуулга бүхий хэм хэмжээ тусгагдсан байна. 2016 онд Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай, 2015 онд шинэчилсэн Эрүүгийн хууль, 2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж батлагдсанаар хууль болон тэдгээрийг дагаж гарсан журмуудаар хүүхдийн эрхийг хангахад төр, иргэн, хуулийн этгээдийн оролцоо болон хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг гэх мэт хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байна (Хууль сахиулахын их сургууль, 2019).

Хүүхэд хамгааллын тухай Монгол Улсын хуульд зааснаар хүүхэд хамгаалал нь нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрддэг. Түүнчлэн, мөн хуулийн хоёрдугаар бүлэгт нийгмийн дараах харилцаа хүрэн дэх хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байдаг. Үүнд:

- Гэр бүл дэх хүүхэд хамгаалал (5 дугаар зүйл);
- Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал (6 дугаар зүйл);
- Эрүүл мэндийн үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал (7 дугаар зүйл);
- Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал (8 дугаар зүйл);
- Олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал (9 дүгээр зүйл);
- Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгаалал (91 дүгээр зүйл).

Хүүхэд хамгааллын тухай гуравдугаар бүлэгт хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ буюу эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих хариу үйлчилгээний төрөл хэлбэр, зохицуулалт, тэдгээрт оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлсон байдаг. Харин дөрөвдүгээр бүлэгт хүүхэд хамтын ажиллагаанд оролцогч талууд буюу төрийн байгууллагууд, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, тэдгээр дэх хүүхдийн эрхийн ажилтан, нийгмийн ажилтны эрх, үүргийг тусгайлан заасан байдаг. Эдгээр нь Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлж байна (Зураг 1).



Зураг 1. Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд тодорхойлсон хүүхэд хамгааллын тогтолцоо, орчин

Хүүхэд хамгааллын тухай хуулийн хоёрдугаар зүйлийн 2.4-д зааснаар хүүхэд хамгааллын тогтолцоо нь Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан оролцогч талуудаас авч хэрэгжүүлэх бодлого, хамтын ажиллагаа, цогц үйлчилгээ, статистик мэдээлэл, санхүү төсөв, мэргэшсэн хүний нөөц зэргээс бүрдэнэ. Иймд хүүхэд хамгааллын тогтолцоог авч үзэхдээ Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан оролцогч талуудын эрх, үүргийг авч үзэх шаардлагатай.

Хүүхдийн эрхийн тухай Монгол Улсын хууль (2016)-ийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Уг хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д “Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заасан байдаг.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүргийг, 3 дугаар бүлэгт төр, иргэн, хуулийн этгээдийн үүрэг оролцоог тус тус тодорхойлж өгсөн байдаг. Уг хуульд хүүхдийн эрхийг хангахад дараах оролцогч талууд үүрэг хүлээгч болж байна. Үүнд:

- Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг (10 дугаар зүйл);
- Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх (11 дүгээр зүйл);
- Засгийн газрын үүрэг, оролцоо (12 дугаар зүйл);
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг, оролцоо (13 дугаар зүйл);

- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг, оролцоо (14 дүгээр зүйл);
- Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын үүрэг, оролцоо (15 дугаар зүйл);
- Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл (16 дугаар зүйл);
- Бүх шатны Засаг даргын үүрэг, оролцоо (17 дугаар зүйл);
- Иргэн, хуулийн этгээдийн үүрэг, оролцоо (18 дугаар зүйл).

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)”-ийг батлан хэрэгжүүлжээ. Хөтөлбөрийн зорилго нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд оршиж байсан. Хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт дэвшүүлсний дотор 2.2.1-д “хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ”, 2.2.4-д “нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаална” гэжээ.

Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд үүрэг хүлээгчид, эрх агуулагчдын мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох нь чухал. Өөрөөр хэлбэл, эрх агуулагчид нь эрхээ, үүрэг хүлээгчид нь үүргээ мэдэж байна уу, хэрхэн хандаж байна, эрхээ шаардаж, үүргээ биелүүлж чадаж байна уу гэдгийг тодорхойлно гэсэн үг (Зураг 2).



Зураг 2. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн оролцогч талуудын харилцан хамаарал

> СУДАЛГААНЫ СЭДЭВ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ

Энэ удаагийн хүүхэд хамгааллын МХД-ын судалгааны сэдэв, хүрээг тодорхойлохдоо: 1) өмнө хийгдсэн судалгаануудтай сэдэв, хүрээний хувьд давхцуулахгүй байх; 2) судалгаа шинжилгээ, үнэлгээний дутагдалтай байдлыг нөхөх; 3) тулгамдаж буй тодорхой асуудалд чиглэсэн байх гэсэн ерөнхий зарчим баримталсан болно. Энэ хүрээнд хүүхэд хамгааллын МХД-ын судалгаатай ижил болон төстэй өмнө нь хийгдсэн судалгаанууд, тэдгээрийн зорилго, арга зүй, гарсан үр дүнд шинжилгээ хийсэн. Уг шинжилгээний гол зорилго нь хүүхэд хамгааллын чиглэлээр судлагдаагүй, гүнзгийрүүлэн эсвэл үргэлжлүүлэн судлах шаардлагатай асуудлуудыг тодруулахад чиглэсэн юм. Энэ дүн шинжилгээнд сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад хийгдсэн хүүхэд хамгааллын сэдэвчилсэн дараах судалгаануудыг багтаасан болно:

- 1) “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь судалгаа (Хүүхдийг Ивээх Сан, 2021);
- 2) Кейс менежментэд (зайнаас) хийсэн чанарын үнэлгээ (Хүүхдийг Ивээх Сан, 2021).;
- 3) 14-23 насны залуусын чанарын судалгааны тайлан (Мобиком корпорац, 2020);
- 4) Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал (Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, 2020);
- 5) Коронавируст цар тахлын үр нөлөөний үнэлгээ (Хүүхдийг Ивээх Сан, 2020);
- 6) Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт (Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам, 2019);
- 7) Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал (Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, Сургалт судалгаа мэдээллийн төв, 2018);
- 8) Замын хөдөлгөөн дэх хүүхдийн аюулгүй байдал, осол гэмтлийн нөхцөл байдал (НҮБ-ын Хүүхдийн сан, 2018);
- 9) Хүчирхийллийн нүцгэн үнэн: Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа (Үндэсний Статистикийн Хороо, 2017);
- 10) Өсвөр үеийнхний дуу хоолой – 2 (Хүүхдийг Ивээх Сан, 2017);
- 11) Хүүхдийн эрх ба хамгаалал (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Гүүд Нэйборс ОУБ, 2016);
- 12) Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа (Нийслэлийн Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, 2014).

Дээр дурдсан судалгаа тус бүрийн зорилго, арга зүй, үр дүн, судлаачдын дүгнэлтийг багтаасан “Судалгааны тойм”-ыг Хавсралт 1-ээс үзнэ үү.

Эдгээр сэдэвчилсэн судалгаанд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гүнзгийрүүлэн судлах шаардлагатай асуудлуудыг дор дурдсанаар санал болгосон:

- Эцэг эх, асран хамгаалагчийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал;
- Эцэг эх, асран хамгаалагч ба хүүхэд хоорондын харилцаа, хандлага;
- Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаарх мэдлэг, хандлага, дадал;
- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн насны онцлогт тохирсон хүмүүжлийн арга хэрэглэх байдал;
- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдээ хооронд нь харьцуулах, ялгаварлан гадуурхах хандлага;
- Эцэг эх ба хүүхэд хоорондын зөрчил гарах шалтгаан, нөхцөл;
- Эцэг эх, асран хамгаалагчдын цахим орчин дахь хүүхэд хамгааллын мэдлэг, хандлага, дадал;
- Эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдээ зам тээврийн хөдөлгөөнд оролцуулах талаарх мэдлэг, хандлага, дадал;
- Дүүтэй хүүхдүүдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл;
- Ирээдүйд аав, ээж болох залуучуудын хүүхэд хамгааллын мэдлэг, хандлага, дадал;
- Сургуулийн орчин дахь хүүхдийн ялгаварлан гадуурхалт.

Дээр дурдсан гүнзгийрүүлэн судлах шаардлагатай асуудлуудыг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан Судалгааны зөвлөх хороонд 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр танилцуулж, хэлэлцүүлсэн. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үндэсний хууль тогтоомжийн зарим заалтын хэрэгжилтийг үнэлэх, хүүхэд хамгааллын салбарт суурь мэдээллийн сан үүсгэх, өмнө нь энэ чиглэлээр хийгдсэн судалгаануудын дутагдалтай байдлыг нөхөх, улмаар дээр дурдсан гүнзгийрүүлэн судлах шаардлагатай асуудлууд голдуу насанд хүрэгчид ба

хүүхэд хоорондын харилцаа, хамгаалалтай холбогдож байгаа тул **насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг** тодорхойлоход энэ удаагийн судалгааг чиглүүлэх нь зүйтэй гэж **уг хорооны гишүүд үзсэн билээ**. Насанд хүрэгчид гэдэг нь 18-аас дээш насны хүмүүс бөгөөд үүнд эцэг эх, асран хамгаалагчид буюу хүүхэдтэй хүмүүс, гэр бүл болоогүй, хүүхэдгүй залуус, ахмад настны бүхий л төлөөлөл багтаж байгаа болно.

> УРЬДЧИЛСАН ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА

“Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал” гэсэн сэдвийн хүрээнд 1) чухам ямар асуудлуудыг нарийвчлан судлах ёстойг тодруулах, 2) хүүхэд хамгаалалтай холбоотой эмзэг сэдэв, асуудлуудыг оролцогч бүлгүүдтэй ярилцахад анхаарах зүйлийг мэдэх, 3) хүүхдүүдийн оролцоог хангах зорилгын хүрээнд урьдчилсан фокус бүлгийн ярилцлагыг 2022 оны 12 дугаар сарын 02–03–ны өдрүүдэд хийсэн. Уг ярилцлагад нас, хүйс, амьдардаг сууцны шалгуурт үндэслэн зургаан насанд хүрэгч, найман хүүхдийг тус тусад нь хамруулсан болно (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Урьдчилсан фокус бүлгийн ярилцлагад оролцогчдын мэдээлэл

Урьдчилсан ФБЯ-д оролцогчдын бүлэг	Нас	Хүйс	Сууцны төрөл	Оролцогчдын тоо
Хүүхдүүд	12-15	<ul style="list-style-type: none"> Эрэгтэй (2) Эмэгтэй (2) 	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 	4
	16-18	<ul style="list-style-type: none"> Эрэгтэй (2) Эмэгтэй (2) 	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 	4
Насанд хүрэгчид (Хүүхэдтэй, хүүхэдгүй)	25-55	<ul style="list-style-type: none"> Эрэгтэй (3) Эмэгтэй (3) 	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (3) Орон сууц (3) 	6

Урьдчилсан фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулахдаа хүүхдүүд, насанд хүрэгчдээр өөрсдөөр нь хүүхдийн эрх хамгийн их зөрчигддөг орчин, нөхцөл, хүчирхийллийн хэлбэрүүд, хүүхдэд тулгамддаг асуудлууд зэргийг зураглуулан бичүүлсэн. Хийсэн зүйлээ бодох хугацааг оролцогчдод өгсний дараа бичсэн зүйлийнх нь талаар яриулах нь асуудлыг нарийвчлан ойлгоход тусалсан.

Урьдчилсан фокус бүлгийн ярилцлагаас гарсан гол үр дүнг дор дурдъя:

- Насанд хүрэгчдээс “хүүхэд хамгаалал гэж юу вэ” гэж асуухад хүүхдүүд гэр бүлдээ тав тухтай байх, аав ээж нь хүүхдүүдэдээ анхаарал, халамж тавих, хүүхдээ зөв хүмүүжүүлэх зэрэг хүрээнд ойлгож байсан юм. Үүнээс хүүхэд хамгааллын асуудлыг голдуу гэр бүлийн орчинд авч үзэх хандлагатай байна гэж дүгнэсэн бөгөөд **нийгмийн бусад орчинд (жишээ нь гудамж талбай гэх мэт) хүүхдийг хамгаалах талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадал ямар байгааг тодруулан судлах шаардлагатай гэж үзсэн.**
- Насанд хүрэгчид хүчирхийллийн хэлбэрүүдээс бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийллийн тохиолдлуудыг сайн нэрлэж байсан боловч үл хайхрах болон бэлгийн хүчирхийллийн талаар ярих хандлага бага байсан. **Энэ хандлага судалгааны нийт хүн амын дунд ижил эсвэл өөр байгаа эсэхийг тодруулах шаардлагатай гэж үзсэн.** Учир нь үл хайхрах хүчирхийлэл түгээмэл байдаг ч насанд хүрэгчдийн хувьд түүнийг хүчирхийлэл гэж хүлээн зөвшөөрч, ойлгож байгаа эсэхийг мэдэх, ингэснээр тэдэнд тохирсон нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд судалгааны үр дүн чухал юм. Түүнчлэн, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуултууд, нэн ялангуяа хүүхдийн

эсрэг хүчирхийллийн дадлыг тодруулахдаа бэлгийн хүчирхийлэл үйлддэг эсэхтэй холбоотой асуултуудыг оруулах шаардлагагүй гэж үзсэн.

- Насанд хүрэгчид хүүхдээ буруу зүйл хийхэд нь ихэнхдээ загнах, зандрах, цохих, бүсээр ороолгоно гэж айлгах, хүүхдийнхээ өөдөөс чанга дуугаар хашхирах зэрэг хүүхэд хүмүүжлийн буруу арга барил ашиглах хандлагатай байсан. Харин хүүхэдтэйгээ ярилцах, тэднийг сонсох, урамшуулах зэрэг хүмүүжлийн эерэг аргыг тэр бүр хэрэглэхгүй байгаа нь ажиглагдсан. Одоогийн хүүхдүүд хэт бэлэнчлэх сэтгэлгээтэй, хөдөлмөрийн үнэ цэн мэдэхгүй, өөдөөс байнга эрх, үүрэг ярьдаг гэх хандлага насанд хүрэгчдийн дунд түгээмэл байсан тул **хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага, дадлыг гүнзгийрүүлэн судлах, эдгээр хандлага, дадал нийт судалгаанд оролцогчдын хувьд ижил эсвэл өөр байгаа эсэхийг тодруулах шаардлагатай гэж үзсэн.**
- Гэр бүлийн орчинд аав, ээж нь хүүхдээ өөрийнхөө хүслээр байлгах гэж зүтгэх, хувийн орон зайг нь хүндлэхгүй байх, дүү нараа асрахыг шаардах, бусдын хүүхэдтэй харьцуулах, гэртээ хорих, найз нөхөдтэй нь уулзуулахгүй байх, хүүхдийнхээ хажууд архи, тамхи хэрэглэх гэх мэт асуудал гардаг талаар ярилцлагад оролцсон хүүхдүүд ярьсан. Эдгээр асуудлыг судалгааны арга хэрэгсэл (асуулга болон ярилцлагын асуултууд)-д багтаан, **насанд хүрэгчид үүнийг асуудал гэж хардаг эсэх, ямар мэдлэг, хандлага, дадалтай байдгийг тодруулах шаардлагатай гэж үзсэн.**

Энэхүү урьдчилсан фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс дүгнэж үзвэл “Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал” судалгаанд хүүхдийн хүмүүжил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхэд хамгаалал гэсэн гурван бүлэг асуудлыг хөндөх шаардлагатай нь харагдсан болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

> СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэхүү судалгаа нь насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодруулах зорилготой. Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьсан:

- (i) Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлагыг илрүүлэх;
- (ii) Насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх;
- (iii) Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодруулах.

> СУДЛАХ АСУУДЛУУДЫН ХҮРЭЭ, ТЭДГЭЭРИЙН ХАМААРАЛ

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх зорилготой энэхүү судалгааг хүүхдийн хүмүүжил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхэд хамгаалал гэсэн гурван ухагдахууны хүрээнд авч үзсэн болно (Зураг 3).



Зураг 3. Судлах асуудлын хүрээ, хамаарал

Энэ гурван ухагдахуун хоорондоо харилцан хамааралтай. Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага болон хүүхдээ хүмүүжүүлэх дадал салшгүй холбоотой. Хүүхдийн хүмүүжлийн талаарх эцэг эхчүүдийн хандлага нь тэдний зан үйл буюу дадалд нөлөөлөөд зогсохгүй эцэг эхийн хүүхдээ хүмүүжүүлэх дадал нь эргээд тэдний хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага, итгэл үнэмшлийг төлөвшүүлдэг (Жексон нар, 1999; Грусек & Данулуик, 2014). Жишээ нь, хүүхэд эцэг эхийнхээ үгэнд ордог, дуулгавартай хүн болж хүмүүжих ёстой гэж үздэг эцэг эхчүүд хүүхэд нь үгэнд орохгүй бол бие махбодын эсвэл сэтгэл санааны шийтгэл хэрэглэж

болно. Эргээд хүүхдэдээ бие махбодын шийтгэл амсуулдаг буюу хүчирхийллийн шинжтэй аргуудыг хэрэглэх дадалтай хүмүүс хүүхдийг хатуу гараар өсгөх ёстой, хааяа хааяа зодож байхад буруудахгүй гэсэн хүмүүжлийн хандлагатай болно гэсэн үг. Түүнчлэн, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, тэдгээрийг ялган ойлгож буй байдал, хүчирхийлэл хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага нь хүчирхийллийн эсвэл хүчирхийллийн бус арга хэрэглэж буй дадалд нөлөөлж байж болно. Мөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, тэдгээрийг ялган ойлгож буй байдал, хүчирхийлэл хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага нь хүүхдийн хүмүүжлийн талаарх үзэл бодол, хандлагатай хамаатай байж болно. Цаашилбал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, тэдгээрийг ялган ойлгож буй байдал, хүчирхийлэл хэмээн хүлээн зөвшөөрөх насанд хүрэгчдийн хандлага нь хүүхдийг хамгаалах, тодруулбал хүүхэд хүчирхийлэлд өртсөнийг мэдсэн эсвэл мэдэх тохиолдолд мэдээлэх үүргээ биелүүлсэн эсвэл биелүүлэх эсэхэд нөлөөлж болно. Хүүхдийн хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал нь эргээд хүүхдийн хүмүүжлийн талаарх эцэг эхчүүд, насанд хүрэгчдийн ойлголт, хандлагад өөрчлөлт авчирч болно. Жишээ нь, хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг нь мэдэх, түүнийг мэдээлэх нь эргээд эцэг эх, насанд хүрэгч өөрөө хүүхдийн хүмүүжлийн талаар ямар бодол саналтай явдгаа эргэцүүлэн бодох, өөрчлөх, сайжруулах нөхцөл болж болно.

Энэхүү судалгаагаар насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тус тусад нь тодруулснаас гадна энэхүү гурван ухагдахууны хоорондын харилцан хамаарал дээр дурдсан судалгааны үр дүн болон бидний таамагтай адил эсэхийг мөн шалгаж үзсэн билээ.

> СУДАЛГААНЫ ДИЗАЙН

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан хэрэглэх холимог арга зүй бүхий судалгааны дизайныг сонгосон (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Судалгааны дизайн

Холимог арга зүй			
Арга	Асуулга	Фокус бүлгийн ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага
Зорилтот бүлэг	Насанд хүрэгчид (18-аас дээш насныхан)	<ul style="list-style-type: none"> Насанд хүрэгчид Нийгмийн ажилтнууд 	<ul style="list-style-type: none"> Багш Цагдаа Мэргэжилтнүүд
Дүн шинжилгээ	Статистикийн дүн шинжилгээ	Чанарын дүн шинжилгээ	
Үр дүн	Харьцуулахуй, нэгтгэн дүгнэхүй		

> СУДАЛГААНЫ АРГА ХЭРЭГСЛҮҮД

Тоон судалгааны хувьд асуулгын аргаар насанд хүрэгчдээс мэдээлэл цуглуулсан бол чанарын судалгааны хүрээнд насанд хүрэгчдээс гадна хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулав. Ийнхүү ялгаатай аргаар цуглуулсан мэдээлэлд статистикийн болон чанарын шинжилгээ хийж, харьцуулах, нэгтгэн дүгнэх аргаар үр дүнг гаргалаа.

Асуулга

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодруулах асуулгыг боловсруулахдаа дараах бүлэг асуултуудыг өмнөх судалгаанууд болон Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмуудаас авч ашигласан болно:

- *Хүүхдийн хүмүүжлийн талаарх насанд хүрэгчдийн хандлагыг тодруулах асуултууд:* “Насанд хүрэгч болон өсвөр насныхны хүүхдийн хүмүүжлийн талаарх үнэлгээ (The Adult-Adolescent Parent Inventory (AAPI-2))” хэмээх арга хэрэгсэл нь янз бүрийн насны хүүхэдтэй эцэг эхчүүд төдийгүй ирээдүйд эцэг эх болох хүмүүсийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага, итгэл үнэмшлийг хэмжих зориулалт бүхий асуулга юм (Баволек & Киине, 1984). Энэхүү арга хэрэгсэл нь тохирц, хүчин төгөлдөр байдлын хувьд найдвартай болохыг олон судалгаагаар баталгаажуулсан байдаг (Коннерс нар., 2006).
- *Хүүхдээ хүмүүжүүлэх дадал буюу хүчирхийллийн аргуудыг хэрэглэдэг эсэхийг тодруулах асуултууд:* Хүүхдээ хүмүүжүүлэх дадал буюу хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн болон хүчирхийллийн бус арга хэрэглэдэг эсэхийг тодруулах зорилготой бүлэг асуултыг “Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн төлөөх олон улсын нийгэмлэг”-ээс боловсруулсан “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх хэрэгсэл (The ISPCAN Child abuse screening tool)-ээс авсан. Үндсэн хэрэгсэлд бие махбод, сэтгэл санаа, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуултууд багтсан бөгөөд Монголын хам орчны онцлог болон хүүхэд, насанд хүрэгчидтэй хийсэн урьдчилсан фокус бүлгийн ярилцлагаар илэрсэн үр дүнд үндэслэн түгээмэл ажиглагдах хүчирхийллийн асуултуудыг сонгон оруулсан болно. Энэхүү арга хэрэгслийг ялгаатай орнуудын хам орчинд хэрэглэж, түүний тохирц, хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулсан байдаг (Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн төлөөх олон улсын нийгэмлэг, 2015; Золотор нар., 2006). Уг арга хэрэгслийг 130 эцэг эх, 140 хүүхдийг хамруулан 2014 онд Монголд хийсэн “Хүүхдийн хүчирхийлэлд өртсөн байдлын судалгаа”-нд мөн хэрэглэж байжээ.
- *Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодруулах асуултууд:* Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг тодруулах асуултуудыг хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад холбогдох бодлого, журамд үндэслэн боловсруулсан. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх хандлага, дадал, түүнд учирч болох бэрхшээлүүдийг өмнө хийгдсэн судалгаа (ЛиКроу & Миллиган ЛиКроу, 2020) болон Монголын хам орчны онцлог, урьдчилан хийсэн фокус бүлгийн ярилцлагын үр дүнд суурилан боловсруулсан. Нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага, дадлын бүлэг асуултуудыг Монголын хам орчны онцлог, урьдчилан хийсэн фокус бүлгийн ярилцлагын үр дүнд суурилан боловсруулсан.

Ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын асуултууд

Насанд хүрэгчид болон хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын асуултуудыг боловсруулахдаа асуулгад хэрэглэсэн асуултуудаас гадна тэдгээр асуултын гүнзгийрүүлсэн хувилбарууд, Монголын хам орчны онцлог, хүүхэд хамгаалалтай холбоотой хууль тогтоомж, бодлого, дүрэм журмаас санаа авсан болно.

Асуулга, ярилцлагын асуултуудыг шалгаж, сайжруулсан байдал

Тоон болон чанарын мэдээлэл цуглуулах асуултуудыг боловсруулахдаа дараах хэд хэдэн үе шатаар хянаж шалгасан:

- 1) Хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг мэргэшсэн нийгмийн ажилтнууд болон бусад мэргэжилтнүүдээс санал авч сайжруулсан.
- 2) Судалгааны зөвлөх хорооны гишүүдээс санал авч сайжруулсан.

- 3) Судалгааны мэдээлэл цуглуулагчдыг сургах явцад асуултуудын ойлгомжтой байдлын талаар тэднээс санал авч, сайжруулсан.
- 4) Судалгаанд хамруулахаар төлөвлөсөн зорилтот бүлгийг төлөөлөхүйц насанд хүрэгчдээс судалгааны мэдээлэл цуглуулалт эхлэхээс өмнө туршилт судалгаа авч асуулгыг сайжруулсан.

Судалгааны асуулга, ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын асуултуудыг хавсралт 2-7-оос үзнэ үү.

> СУДАЛГААНЫ ХҮН АМ, ТҮҮВЭР

Судалгааны үндсэн хүн ам нь насанд хүрэгчид буюу 18-аас дээш насны хүмүүс юм. Мөн хүүхэд хамгааллын чиглэлээр анхан болон дунд шатанд ажиллаж буй мэргэжилтнүүд болох хорооны нийгмийн ажилтан, цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч зэрэг хүмүүсийг энэхүү судалгаанд хамруулсан болно. Эдгээр мэргэжилтнээс насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг хэрхэн үнэлж дүгнэж байгаа, хүүхэд хамгаалалд насанд хүрэгчдийн оролцоо хэр байгаа, хэрхэн сайжруулах талаарх санал бодлыг нь сонссон болно.

Тоон судалгаанд Улаанбаатар хотын есөн дүүргийн 1,202 насанд хүрэгчийг хамруулсан бол чанарын судалгаанд 55 хүнийг оролцуулав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Судалгааны түүврийн хэмжээ (судалгааны аргуудаар)

Судалгааны хүн ам		Асуулга	Фокус бүлгийн ярилцлага	Ганцаарчилсан ярилцлага
Насанд хүрэгчид		1,202	32	-
Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд	Хорооны нийгмийн ажилтан	-	8	-
	Бусад	-	-	15
Нийт		1,202	40	15
			55	

Тоон болон чанарын судалгаанд оролцогчдын түүвэр болон тэднийг хэрхэн сонгосон шалгуурыг тус бүрд нь танилцуулъя.

Тоон судалгааны түүвэр

Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээс үзвэл 2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 3,312,275 хүн ам оршин сууж байсны 1,539,252 буюу 46.5 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байжээ. Улаанбаатар хотын хүн амын 565,540 буюу 36.7 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд байгаа бол 973,712 буюу 63.3 хувь нь 18-аас дээш насныхан бөгөөд эдгээр насанд хүрэгчид нь уг судалгааны зорилтот хүн ам юм. Уг статистик тоог үндэслэж доорх томъёоллоор судалгаанд хамрагдах нэгжийн тоог 95 хувийн итгэх магадлал, 2.8 хувийн алдааны түвшинд судалгааны түүврийн хэмжээг тооцов.

$$N = \frac{Z^2 P(1 - P)}{E^2} \quad N = \frac{(1.96)^2 \times (0.6)(1 - 0.6)}{(0.028)^2} = 1,224$$

Энд: n – түүврийн хэмжээ, z– хүсэж буй итгэлтэй түвшин дэх z утга, p – тухайн үзэгдлийн илрэх магадлал, e – боломжит нарийвчлалын түвшин

$$N = 1,224 \approx 1,202$$

Судалгаанд хамрагдах 1,202 насанд хүрэгчийг сонгохдоо насны бүлэг, хүйс, дүүргээр нарийвчлан авч үзсэн (Хүснэгт 4).

Хүснэгт 4. УБ хотын 18-аас дээш насны хүн амын тоо болон судалгаанд оролцогчдын тоо

Шалгуур үзүүлэлт		Хүн амын тоо	Эзлэх хувь	Судалгаанд оролцогчийн тоо
Насны бүлэг	18-22	88,182	9.1	109
	23-26	74,876	7.7	92
	27-30	94,275	9.7	116
	31-35	153,805	15.8	191
	36-40	123,400	12.7	153
	41-45	102,962	10.6	127
	46-50	88,990	9.1	110
	51-55	73,271	7.5	90
	56-60	63,283	6.5	78
	61-65	47,313	4.9	58
	66 ба түүнээс дээш	63,355	6.5	78
Нийт дүн		973,712	100.0	1,202
Хүйс	Эрэгтэй	467,382	48.0	577
	Эмэгтэй	506,330	52.0	625
	Нийт дүн	973,712	100.0	1,202
Дүүрэг	Багануур, Багахангай	21,843	2.2	28
	Баянгол	149,496	15.4	184
	Баянзүрх	243,013	25.0	299
	Налайх	24,394	2.5	30
	Сонгинохайрхан	215,348	22.1	265
	Сүхбаатар	93,929	9.6	116
	Хан-Уул	128,581	13.2	159
	Чингэлтэй	97,108	10.0	121
	Нийт дүн	973,712	100.0	1,202

Дүүрэг тус бүрийн хүн ам хамгийн их оршин суудаг хороо, байршлуудад судалгааны мэдээлэл цуглуулагчдын явах замын зургийг гаргаж, талбарт суурилсан түүврийн хүрээг ашиглан системчилсэн түүврийн аргаар судалгаанд хамрагдах цэгүүдийг тодорхойлсон. Тухайлбал, гэр хороололд байршлын нягтаршил судалгаанд хамрагдах нэгжийн тоонд үндэслэн эхлэлийн цэгээс эхлэн 5–15 хаалга алгасан тухайн хашаа, хаалган дахь насанд хүрсэн иргэдээс Киш-Гридийн аргаар нэг хүнийг сонгон судалгаанд хамруулсан.

Чанарын судалгааны түүвэр

Фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан 32 насанд хүрэгчийг сонгохдоо тэдний амьдардаг сууц, нас, хүйс, хүүхэдтэй эсэхэд үндэслэсэн. Дээрх шалгуурт тулгуурлан тус бүр дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй найман удаагийн фокус бүлгийн ярилцлагыг хийсэн болно (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлага

Байршил	Нас	Хүйс	Сууцны төрөл	Хүүхэдтэй эсэх	Оролцогчдын тоо
Төвийн 6 дүүрэг (Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул)	18-25	Эмэгтэй	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 	Хүүхэдгүй	4
		Эрэгтэй	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 		4
	26-с дээш	Эмэгтэй	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 	2 ба түүнээс дээш хүүхэдтэй	4
		Эрэгтэй	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 		4
Алслагдсан 3 дүүрэг (Багануур, Багахангай, Налайх)	18-25	Эмэгтэй	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 	Хүүхэдгүй	4
		Эрэгтэй	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 		4
	26-с дээш	Эмэгтэй	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 	2 ба түүнээс дээш хүүхэдтэй	4
		Эрэгтэй	<ul style="list-style-type: none"> Гэр хороолол (2) Орон сууц (2) 		4

Түүнчлэн фокус бүлгийн ярилцлагад хороо буюу нэгжийн түвшинд ажилладаг найман нийгмийн ажилтныг оролцуулсан бөгөөд эдгээр нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээ хийж, хариу үйлчилгээ үзүүлдэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүрэгтэй хүмүүс билээ. Тэднийг сонгохдоо тухайн хороонд тулгамдаж буй асуудлаа хамгийн сайн мэддэг, насанд хүрэгчид, хүүхдүүдтэй ойр ажилладаг зэргийг харгалзан үзсэн.

Мөн судалгаанд хамрагдсан бүсэд буй хүүхэд хамгааллын чиглэлээр анхан болон дунд шатанд ажилладаг мэргэжилтнүүдийг сонгон ганцаарчилсан ярилцлага хийсэн болно (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Ганцаарчилсан ярилцлагад оролцсон мэргэжилтнүүд

№	Ганцаарчилсан ярилцлагын оролцогчид	Оролцогчдын тоо
1	ЕБС-ийн багш	2
2	Цэцэрлэгийн эрхлэгч	2
3	ЕБС-ийн нийгмийн ажилтан	3
4	Хэсгийн байцаагч	2
5	Дунд шатны мэргэжилтэн (Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, НЗДТГ-ын Нийгмийн Бодлогын Хэлтэс)	6
Нийт		15

> СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ

Судалгааны мэдээлэл цуглуулах бэлтгэлийг хангах зорилгоор мэдээлэл цуглуулагчдад зориулсан гарын авлага, сургалтын материал бэлтгэх, сургалт хийх, судалгааны мэдээлэл оруулах программыг бэлтгэх, туршилт судалгаа хийх, мэдээлэл цуглуулах төлөвлөгөө гаргах, судалгаанд оролцогчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ (Зураг 4).



Зураг 4. Судалгааны мэдээлэл цуглуулах бэлтгэл ажлууд

> СУДАЛГААНЫ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН ЯВЦ

Судалгааны мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 18-ны өдрийн хооронд цуглуулсан. Мэдээлэл цуглуулах явц өвлийн ид хүйтний үетэй давхацсан учраас мэдээлэл цуглуулах ажил төлөвлөснөөс хоёр долоо хоногоор хойшилсон. Тоон мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 02 дугаар сарын 06-ны өдрийн хооронд цуглуулсан бол чанарын мэдээллийг мөн оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 02 дугаар 18-ны өдрийн хооронд цуглуулав.

Судалгаанд тус бүр 15 хүнээс бүрдсэн гурван багийн нийт 45 хүн мэдээлэл цуглуулагчаар ажилласан. Эдгээр мэдээлэл цуглуулагчийг 1) судалгааны мэдээлэл цуглуулагчаар хамгийн багадаа хоёр жил ажилласан туршлагатай; 2) харилцааны ур чадвар, хувийн зохион байгуулалт сайтай; 3) компьютерын хэрэглээний программууд, судалгааны программуудыг ашиглаж чаддаг; 4) нууц хадгалах чадвартай; 5) гэмт хэрэгт холбогдоогүй гэсэн шалгуурын үндсэн дээр сонгож, сургалтад хамруулан бэлтгэсэн болно. Мэдээлэл цуглуулагчдад зориулсан сургалтын үеэр ХИС-гаас “Хүүхэд хамгааллын бодлого, журам”-ыг танилцуулан, мэдээлэл цуглуулах явцад хүүхдийн эсрэг аливаа хүчирхийллийг мэдсэн эсвэл сэжигтэй тохиолдол гарвал хэнд, хэрхэн хандах тухай мэдээлэл өгсөн.

Тоон мэдээлэл цуглуулахдаа таблетад суурилсан нүүр тулсан ярилцлагын арга ашиглав. Энэхүү аргачлалыг “Computer Assisted Personal Interview (CAPI)” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь “Windows” болон “Android” үйлдлийн системд суурилсан мэргэжлийн мэдээлэл цуглуулах арга юм.

Таблетаар мэдээлэл цуглуулах нь цаасан асуулгаар мэдээлэл цуглуулах аргатай харьцуулахад хэд хэдэн давуу талтай:

- Судалгааны асуулгыг шивэх процессыг автоматчилдаг учраас шивэлтийн алдааг бууруулдаг.
- Логик шалгалт бүхий мэдээлэл оруулах программын дагуу ярилцлага явагдсанаар алдаагүй мэдээлэл цуглуулах, ярилцлагын хугацааг богиносгох боломжийг бүрдүүлдэг.
- “3G/4G” интернэт ашиглан цуглуулсан мэдээллийг тухай бүрд нь хяналтын хэсэг рүү илгээснээр цугларсан мэдээллийг тэр дор нь шалгах, засварлах, нэгтгэх, үр дүнг гаргах боломжтой болдог.
- Ярилцлагын аудио бичлэгийг хийх, фото зураг авч баримтжуулах, үүрэн холбооны сүлжээ нэвтэрсэн ямар ч газарт мэдээлэл цуглуулагчийн байршлыг тодруулах зэрэг мэдээлэл цуглуулах явцыг хянах, баталгаажуулах боломжтой.
- Мэдээлэл цуглуулагчийн аюулгүй байдлыг хангах хэрэгсэл болдог.

Судалгааны мэдээлэл оруулах программыг асуулгын эцсийн хувилбараар “CSPro 7.7” программ дээр бэлтгэсэн. Энэ программ нь “Android” болон “iOS” үйлдлийн системтэй таблет дээр ажиллахаас гадна суурин болон зөөврийн компьютерт суулгаж, мэдээлэл цуглуулах ажлыг удирдах, зохион байгуулах боломж олгодог. Түүнчлэн, онлайн болон оффлайн орчинд ажиллан аудио бичлэг хураах, “GPS” байршлыг тодорхойлох, нэгэн зэрэг хэдэн ч таблетаас нэвтрэх боломжтойгоороо онцлог. Мөн судалгааны мэдээлэл оруулах программд орсон өөрчлөлтийг мэдээлэл цуглуулагчдад тэр дор нь харуулах боломжтойгоороо давуу талтай.

Насанд хүрэгчдээс нүүр тулсан ярилцлагын аргаар тоон мэдээлэл цуглуулах хугацаа нь дунджаар 30-40 минут байсан бол ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага дунджаар нэг цаг үргэлжилсэн болно. Тоон болон чанарын мэдээллийн аль алиныг цуглуулахдаа хөндлөнгийн хүн байхгүй, зөвхөн мэдээлэл цуглуулагч болон судалгаанд оролцогч байхаар орчин бүрдүүлж ажиллалаа.

> СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН АСУУДЛУУД

Судалгаанд оролцогчтой харилцах, мэдээлэл цуглуулахад судалгааны олон улсын ёс зүйн “ES-OMAR” стандарт, зах зээл, санаа бодол, нийгмийн судалгааны олон улсын “ISO 20252:2019” стандартыг мөрдсөн. Эдгээрээс гадна ХИС-гийн “Хүүхэд хамгааллын бодлого, журам”, “Хүүхдийн оролцооны стандарт”-ыг мөрдөн ажиллав.

Дээрх стандартууд, бодлого журмын дагуу судалгаанд оролцогчдоос мэдээлэл цуглуулахаас өмнө дараах мэдээллийг өгч, зөвшөөрөл авсан. Үүнд: 1) судалгааны ажлын зорилго; 2) судалгаанд оролцох хугацаа; 3) оролцогчдын өгсөн мэдээллийг нууцлах тухай, түүнийг баталгаажуулах мэдэгдэл; 4) судалгаанд оролцогчдод олгох урамшуулал; 7) захиалагч байгууллагын нэрийн өмнөөс урилга явуулж байгаа тухай мэдээлэл зэргийг танилцуулсан.

> МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРЫН ХЯНАЛТ

Тоон судалгааны мэдээлэл цуглуулах үйл явцын туршид мэдээллийн чанарын хяналт, шалгалтуудыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ. Ингэхдээ “ISO 20252:2019” стандартын дагуу хяналтыг судалгаанд оролцогчтой утсаар холбогдох, ярилцлагын аудио бичлэгийг сонсох, цуглуулсан дата мэдээллийн логик уялдаа холбоог шалгах замаар хийсэн. **Стандартын 5.4.2.3** болон 5.4.3 дахь заалтын дагуу хянан баталгаажуулалтын түвшин 5–20%-тай байх ёстой. Энэ судалгааны хувьд утсаар эргэн холбогдох шалгалтыг 53%, аудио бичлэг сонсох шалгалтыг 30%, логик уялдаа холбооны шалгалтыг 100% хийсэн болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

> СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ ШИНЖ

Судалгаанд 18-аас дээш насны 1,202 насанд хүрэгч хамрагдсан бөгөөд үүний 53 хувь нь эмэгтэй, 47 хувь нь эрэгтэй байна. Тэдний 3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй (тулгуур эрхтэн, сонсгол, тархи болон харвалтаас үүдэлтэй гэмтэл) иргэд байна. Насны бүлгийн хувьд 31-40 насныхан 30 хувийг эзэлж байна (График 1).





График 1. Судалгаанд оролцогчдын насны бүлэг, хүйсийн харьцаа




Зураг 5. Судалгаанд оролцогчид (дүүргээр)

Улаанбаатар хотын есөн дүүргийн насанд хүрэгчдийг судалгаанд оролцуулахдаа дүүрэг тус бүрийн хүн амын тооноос хамааруулан ялгаатай түүвэрлэлт хийсэн билээ. Энэхүү судалгаанд хамгийн их хүн амтай дүүрэг болох Баянзүрх, Сонгинохайрхан дүүргээс 623 иргэн оролцсон ба энэ нь судалгаанд оролцогчдын 52 хувийг эзэлж байна. Харин УБ хотоос алслагдсан 3 дүүрэг болох (Багануур, Багахангай, Налайх)-аас судалгаанд оролцогчид 4 хувь нь байна (Зураг 5).

Судалгаанд оролцогчдын 51 хувь нь орон сууцанд амьдардаг бол 27 хувь нь сууц нь тусдаа байшинд амьдардаг аж (Зураг 6).

51% 
ОРОН СУУЦАНД
АМЬДАРДАГ

27% 
СУУЦ НЬ ТУСДАА
БАЙШИНД

14% 
МОНГОЛ ГЭРТ

Зураг 6. Судалгаанд оролцогчдын сууцны төрөл

Судалгаанд оролцогчдын гэр бүлийн байдал, ам бүл

Судалгаанд оролцогчдын 48 хувь нь гэрлэлтээ албан ёсоор батлуулсан бол 25 хувь нь огт гэрлэж, эсвэл бусадтай хамтран амьдарч байгаагүй насанд хүрэгчид байна. Гэр бүлийн бүтцийн хувьд 74 хувь нь зөвхөн эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэдтэйгээ амьдардаг буюу дан гэр бүлд амьдарч байгаа бол 15 хувь нь садан төрлийн болон садан төрлийн биш бусад хүмүүстэй хамт амьдардаг ажээ (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Судалгаанд оролцогчдын гэр бүлийн хэв шинж

Үзүүлэлтүүд	Тоо	Хувь
Судалгаанд оролцогчдын гэрлэлтийн байдал		
Гэрлэлтээ албан ёсоор батлуулсан	585	48
Гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй ч хамтран амьдарч байгаа	223	19
Өмнө нь гэрлэж байсан	58	5
Өмнө нь хамтран амьдрагчтай байсан	36	3
Огт гэрлэж, хамтран амьдарч байгаагүй	300	25
Гэр бүлийн бүтэц		
Дан гэр бүл (эхнэр, нөхөр, хүүхэд)	888	78
Өрөөсгөл гэр бүл (эхнэр эсвэл нөхөр толгойлсон)	80	7
Өргөжсөн буюу нийлмэл гэр бүл (эхнэр, нөхөр, хүүхэд, эмээ, өвөө, авга, нагац зэрэг төрөл төрөгсөд хамт)	180	15
Ам бүлийн тоо		
1	54	4
2-3	368	31
4-5	564	47
5-6	194	16
7+	22	2
Өрхөд 18-аас доош насны хүүхэд байгаа эсэх		
Тийм	835	69
Үгүй	367	31
Өрхөд байгаа 18-аас доош насны хүүхдийн тоо	1,710	-
Өрхөд байгаа 18-аас доош насны хүүхдийн хүйс		
Эрэгтэй	870	51
Эмэгтэй	840	49
Өрхөд байгаа 18-аас доош насны хүүхдийн насны бүлэг		
0-5	567	33
6-9	419	25
10-14	495	29
15-18	229	13

Дээрх хүснэгтээс харахад, судалгаанд оролцогчдын 47 хувь нь 4–5 ам бүлтэй байна. Тэдний 69 хувь нь 18-аас доош насны хүүхэдтэй хамт амьдардаг бол 31 хувь нь 18-аас доош насны хүүхэд амьдардаггүй өрх байна. Нэг өрхөд дунджаар 18-аас доош насны 2 хүүхэд амьдардаг аж. Тэдний 51 хувь нь эрэгтэй, 49 хувь нь эмэгтэй хүүхдүүд байна. Эдгээр хүүхдийн дийлэнх нь 0–5 болон 10–14 насныхан байгаа бол 15-18 насны хүүхэдтэй судалгаанд оролцогч хамгийн бага хувийг эзэлж байна.

Боловсрол, ажил эрхлэлт, орлого

Судалгаанд оролцогчдын 40 хувь нь дээд, 42 хувь нь бүрэн дунд боловсролтой. Ажил эрхлэлтийн хувьд 30 хувь нь хувийн байгууллага, 22 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 20 хувь нь төрийн байгууллагад ажилладаг иргэд хамрагджээ (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Судалгаанд оролцогчдын боловсрол, ажил эрхлэлтийн байдал

Сонгосон үзүүлэлт	Эрэгтэй		Эмэгтэй		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Боловсрол						
Дээд боловсрол	207	37	280	44	487	40
Тусгай дунд боловсрол	44	8	67	10	111	9
Бүрэн дунд боловсрол	253	45	258	40	511	42
Суурь боловсрол	44	8	26	4	70	6
Бага боловсрол	8	1	5	1	13	1
Боловсрол эзэмшээгүй	4	1	4	1	8	1
Татгалзсан	2	-	0	-	2	0
Ажил эрхлэлт						
Төрийн байгууллага	110	20	129	20	239	20
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	136	24	134	21	270	22
Хувийн байгууллага	197	35	168	26	365	30
Тэтгэвэрт	26	5	67	10	93	8
Ажил эрхэлдэггүй	43	8	93	15	136	11
Оюутан	50	9	49	8	99	8
Нийт	562	47	640	53	1,202	100

Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 38 хувь нь 420,001-1,000,000 төгрөгийн хувийн болон өрхийн орлоготой байна. Өрхийн орлогыг дунджаар харуулбал **1,274,085** төгрөг байгаа бол судалгаанд оролцогчдын хувийн орлого дунджаар 885,877 төгрөг байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Судалгаанд оролцогчдын хувийн болон өрхийн орлого

Орлого	Хувийн сарын дундаж орлого		Өрхийн сарын дундаж орлого	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Орлогогүй	20	2	11	2
1-420,000 төгрөг	263	22	29	22
420,001-1,000,000 төгрөг	447	38	251	38
1,000,001-1,500,000 төгрөг	248	21	287	21
1,500,001-2,000,000 төгрөг	95	8	188	8
2,000,001-2,500,000 төгрөг	50	4	132	4
2,500,001-3,000,000 төгрөг	25	2	115	2
3,000,001-3,500,000 төгрөг	15	1	61	1
3,500,001-4,000,000 төгрөг	5	0	23	0
4,000,001-4,500,000 төгрөг	4	0	18	0
4,500,001-5,000,000 төгрөг	2	0	32	0
5,000,001 төгрөг болон түүнээс дээш	6	1	40	1

> НАСАНД ХҮРЭГЧДИЙН ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖЛИЙН ТАЛААРХ ХАНДЛАГА

Зорилт 1: Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлагыг илрүүлэх

Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага нь хүүхдээ хүмүүжүүлэх дадал буюу хүчирхийллийн эсвэл хүчирхийллийн бус арга хэрэглэж буй дадалтай холбоотой гэж судлаачид үздэг. Улмаар насанд хүрэгчид хүүхдийн хүмүүжлийн талаар ямар хандлагатай байх нь хүүхдийг хамгаалах эсэх асуудалтай холбогдоно. Иймээс хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхэд хамгааллын асуудлын суурь болгон насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлагыг судлах нь зайлшгүй.

Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлагыг тодруулахдаа 1) хүүхдээсээ зохисгүй зүйл хүлээх хандлага; 2) хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх хандлага; 3) хүүхдэдээ үүргээ шилжүүлэх хандлага; 4) хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг үл хүлээн зөвшөөрөх хандлага гэсэн дөрвөн агуулгаар мэдээлэл цуглуулсан.

Хүүхдээсээ зохисгүй зүйл хүлээх хандлага

Насанд хүрэгчдийн дунд хүүхдээсээ зохисгүй зүйл хүлээх хандлага түгээмэл байна. Энэ нь судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлт, амьдардаг байршил, сууцны төрөл гэх мэтээс үл хамааран бүх оролцогчийн хувьд адил байна (Хавсралт 8). Судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 6 нь “хүүхдийг дуулгавартай, эцэг эхийнхээ үгийг дагадаг болгож хүмүүжүүлэх хэрэгтэй” гэдэгтэй санал нийлж байгаа бол “одоогийн хүүхдүүд бүх юм нь бэлэн, жаргалтай өсөж байна” гэдэгтэй 10 хүн тутмын 5 нь санал нийлж байна. Мөн “хүүхдүүд томчуудын үгэнд ордог, дуулгавартай байх ёстой”, “хүүхдэд нүүр өгвөл улам давардаг” зэрэг хэвшмэл ойлголтуудтай 10 хүн тутмын 3-4 нь санал нийлж байна (График 2).




График 2. Хүүхдээс зохисгүй зүйл хүлээх хандлагыг тодруулах бодомжуудтай санал нийлж буй байдал

“Хүүхдийг дуулгавартай, эцэг эхийнхээ үгийг дагадаг болгож хүмүүжүүлэх хэрэгтэй” гэх хандлага бүх насныхны хувьд өндөр буюу 57-оос дээш хувьтай байна. Ялангуяа 61-ээс дээш насныхны 72 хувь нь дээрх хандлагыг хүлээн зөвшөөрч байна. Түүнчлэн, энэхүү хандлагыг эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүд их дэмжиж байна. Бусад дүүрэгтэй харьцуулахад, СХД-ээс судалгаанд оролцогчид энэ хандлагыг илүүтэй дэмжсэн. Мөн өрхөд 18-аас доош насны өөрийн болон бусдын хүүхэд амьдардаг, хотын захын гэр хороололд амьдардаг, бүрэн дундаас доош боловсролтой иргэд уг бодомжтой санал нийлэх нь түгээмэл аж.

“Одоогийн хүүхдүүд бүх юм нь бэлэн, жаргалтай өсөж байна” гэдэгтэй судалгаанд оролцогчдын тал хувь нь санал нийлж байна. Ялангуяа 31-ээс дээш насныхан 45-аас дээш хувьтай санал нийлж байгаа ба оролцогчдын боловсролын түвшин багасах тусам энэхүү хандлагыг дэмжих хувь нэмэгдэж байна. Мөн гэр хороололд амьдардаг насанд хүрэгчид болон УБ хотын алслагдсан гурван дүүрэг болон ЧД, СХД-ээс судалгаанд оролцогчид уг хандлагыг дэмжиж байна (Хавсралт 8).

Насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас авч үзвэл, тэдний хувьд бага байхдаа томчуудын хэлсэн болгоныг зөв гэж боддог байсан бол одоогийн хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчаасаа түрүүлээд янз бүрийн сувгаас мэдээлэл аван, томчуудын хэлсэн үгийг өөр өөрийн өнцгөөс хүлээж авдаг болсон. Үүнээс үүдэн хүүхдүүд, насанд хүрэгчдийн дунд үл ойлголцолгардаг байна. Мөн хүүхдүүдэд бүх зүйлийг нь бэлдэн өгч байхад хичээл номоохийхгүй, хэт бэлэнчлэх сэтгэлгээтэй, хөдөлмөрийн үнэ цэнийг мэдэхгүй, утсаа оролдохоороо хэлсэн үг сонсохгүй, сошиалаас үзсэн зүйлээ даган дуурайдаг, зөрүүд, ахмад хүнийг хүндэлж мэдэхгүй болсон гэх мэт зүйлийг насанд хүрэгчид дурдаж байсан. Үүнээс харахад, насанд хүрэгчид орчин үеийн нийгмийн онцлогийг ойлголгүй, өөрсдийн өсөж төрсөн үетэйгээ харьцуулах байдлаар хүүхэдтэйгээ харилцах, үүнээс үүдэн хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчтайгаа нээлттэй ярилцан, өөрийгөө ойлгуулах хүсэлгүй болоход нөлөөлж байна. Иймээс насанд хүрэгчдэд нийгмийн хөгжил дэвшил, даяарчлал, сошиал медиа хөгжсөнтэй холбоотойгоор нийгэм өөрчлөгдөж байгаа тул үе хоорондын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, өөрсдийн өссөн үеийг одоо үетэй харьцуулах нь өрөөсгөл гэдгийг ойлгуулах нь чухал байна.

Хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх хандлага

Насанд хүрэгчдийн дунд хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх хандлага түгээмэл байна. Тухайлбал, “эцэг эх нь хүүхэдтэйгээ ярилцвал тэдний гомдлыг л сонсоно” гэдэгтэй оролцогчдын 49 хувь нь санал нийлж байгаа бол “хүүхэд анхаарал татахын тулд л уйлдаг” гэдэгтэй 44 хувь нь санал нийлж байна (График 3).




График 3. Хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх хандлагуудтай санал нийлж буй байдал

График 3-аас харвал, “хүүхдийг үргэлж магтах нь түүний өөртөө итгэх итгэлийг бэхжүүлэх сайн арга” гэдэгтэй судалгаанд оролцогчдын 67 хувь санал нийлж байгаа нь хүүхдийг магтах урамшуулах талаар буруу ойлголттой байгаа гэсэн үг юм. Нэн ялангуяа 23-40 насныхан энэ хандлагыг хүлээн зөвшөөрөх нь түгээмэл байна (Хавсралт 9). Зарим судлаач (Двейк, 2014)-ийн үзэж байгаагаар эцэг эхээсээ үргэлж магтаал сонсдог хүүхдүүд насанд хүрээд ажил олгогчдоосоо байнгын магтаал хүлээх, магтаал сонсохоо болихоор өөртөө итгэхээ болих хандлага илэрдэг аж. Тиймээс хүүхдийг үргэлж биш харин сайн үйлдэл гаргасан (жишээ нь хувцсаа эвхэж

тавих, гэрийн даалгавраа хэлүүлэхгүйгээр хийх гэх мэт) үед тэр дор нь тухайн үйлдлийг нь магтан урамшуулах нь хүүхдэд зөв зан үйл төлөвшүүлэхэд тустай гэж үздэг (Двейк, 2014; Каздин, n.d.). Үүнээс насанд хүрэгчдэд, нэн ялангуяа 23-40 насныханд хүүхдээ хэзээ, хэрхэн магтах аргыг сайтар таниулж ойлгуулах хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

“Хүүхэд анхаарал татахын тулд л үйлдэг” гэх хандлага голчлон 61-ээс дээш насны, хотын захын гэр хороололд амьдардаг насанд хүрэгчдийн дунд ажиглагдаж байна. “Эцэг эх нь хүүхдүүдтэйгээ ярилцвал тэдний гомдлыг л сонсоно гэсэн үг” гэдэгтэй гэрлэсэн, өөрийн болон бусдын хүүхэдтэй амьдардаг, 41-ээс дээш насны, гэр хороололд амьдардаг эрэгтэйчүүд илүү санал нийлж байна (Хавсралт 9).

“Эрэгтэй хүүхэд уйлах нь сул доройн шинж” гэх хандлагыг судалгаанд оролцогчид нийтээрээ хүлээн зөвшөөрөхгүй байх талтай бөгөөд энэ нь жендэрийн зарим хэвшмэл ойлголт арилж байгааг илтгэж байна. Харин энэ хандлагыг дэмжиж байгаа цөөн насанд хүрэгчийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа нь анхаарал татаж байна (Хавсралт 9). Тиймээс эрэгтэй хүмүүсийн дунд энэ хэвшмэл хандлагыг бууруулах чиглэлээр ажиллах хэрэгцээ зайлшгүй байна.

Эцэг, эх, асран хамгаалагчид хөвгүүдэдээ охидыг битгий дээрэлхээрэй, эмэгтэй хүүхдийг хамгаалж байгаарай гэж захидаг хэр нь охидодоо хөвгүүдэд битгий гар хүрээрэй, битгий дээрэлхээрэй гэж захидаггүй. Сүүлийн үед охид хөвгүүдийг цохидог, зоддог, хэл амаар доромжилдог болсон. Энэ нь эрэгтэй хүүхдүүдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад тулгамдаж буй асуудал болоод байна. Тиймээс хүүхдүүдэдээ багаас нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш байх ёстой гэдгийг эцэг, эх, асран хамгаалагчид зааж зөвлөдөг байх хэрэгтэй.

Насанд хүрэгчдийн фокус бүлгийн ярилцлагаас

Нийгмээрээ эрэгтэй хүн үйлж болохгүй, айл гэр авч явах ёстой гэх хандлагаар хүүхдээ хүмүүжүүлж байна. Түүнээс болоод эрэгтэй хүүхдүүд бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэлд их өртөж байгаа харагддаг. Энэ мэтчилэн хүйсээр ялгаварлах жендэрийн буруу хэвшмэл ойлголтыг арилгах нь чухал байна.

Мэргэжилтэнтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

Хүүхдэдээ үүргээ шилжүүлэх хандлага

Насанд хүрэгчдийн дунд өөрсдийн үүргээ хүүхдүүдэдээ шилжүүлэх хандлага түгээмэл байгаа нь асуусан дөрвөн бодомжид тэдний тэн хагас болон түүнээс дээш хувь нь санал нийлж байгаагаас харагдаж байна (График 4).




График 4. Хүүхдэдээ үүргээ шилжүүлэх хандлагуудтай санал нийлж буй байдал

График 4-өөс харахад, “хүүхдүүд гэртээ эмх цэгцтэй, томоотой байвал эцэг, эх нь тайван байна”, “айлын том хүүхдүүд дүү нараа асрах ёстой”, “эцэг эх нь ядарсан байгааг хүүхдүүд нь мэддэг байх ёстой” гэдэгтэй судалгаанд оролцогчдын тэн хагасаас дээш хувь нь санал нийлж байна. Харин “хүүхдүүд эцэг эхийн хэрэгцээг бодолцож байх ёстой” гэж оролцогчдын тал хувь нь үзжээ. Насны бүлгийн хувьд авч үзвэл, судалгаанд оролцогчдын нас дээшлэх тусам дээрх хандлагуудыг хүлээн зөвшөөрөх талтай. Хүйсийн хувьд, эрэгтэйчүүд иймэрхүү хандлагыг илэрхийлэх нь түгээмэл байна. Насанд хүрэгчдийн боловсролын түвшин доошлох тусам энэ хандлагыг хүчтэй илэрхийлэх талтай. Хотын захын болон хотын төвийн ойролцоо хороодод, түүнчлэн гэр хороололд амьдарч буй насанд хүрэгчид бусадтай харьцуулахад эдгээр хандлагыг дэмжих нь өндөр байна (Хавсралт 10). Гэхдээ дээр дурдсан ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолгүй бөгөөд энэ нь насанд хүрэгчдийн дунд хүүхдэдээ үүргээ шилжүүлэх хандлага тэдний нас, хүйс, боловсрол, амьдардаг байршил гэх мэтээс үл хамааран ижил байна гэсэн үг. Эцэг эх нь хүүхдүүдээс дүү нараа асрахыг байнга шаарддагаас тухайн хүүхдүүдийн суралцах, найз нөхөдтэйгөө хамт байх, өөртөө зарцуулах бусад цаг багасдаг гэдгийг энэ судалгааны хүрээнд хүүхдүүдтэй хийсэн урьдчилсан фокус бүлгийн ярилцлагаас харагдсан. Тэгэхээр насанд хүрэгчдийн хувьд хүүхдэдээ ямар үүргээ, хэр хэмжээгээр шилжүүлж байгаагаа ухамсартайгаар бодож эргэцүүлэх, хүүхдүүдтэйгээ ярилцаж, тэдэнд ямар байгааг нь асууж мэдэх, асуудал байвал шийдэх талаас нь анхаарах шаардлага үүсэж байна.

Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг үл хүлээн зөвшөөрөх хандлага

Насанд хүрэгчдийн хувьд хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг үл хүлээн зөвшөөрөх хандлага харьцангуй багатай байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг хүлээн зөвшөөрч, дэмжих эерэг хандлагатай гэсэн үг (График 5).




График 5. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг үл хүлээн зөвшөөрөх хандлага

Гэвч судалгаанд оролцогчдын тэн хагас нь “хүүхдэд үзэл бодлоо илэрхийлэх боломж олгож байна гээд эцэг, эхийнхээ өөдөөс тайлбар тавихыг нь зөвшөөрөх ёсгүй” гэсэн хандлагыг илэрхийлж байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь насанд хүрэгчдийн дунд хүүхдээ сонсохгүй байх, хүүхдийн тайлбарыг “давхарлаа, олон үг ярилаа, илүү үгтэй” гэж ойлгох хандлагатай байгааг илтгэх талтай. Өөрөөр хэлбэл, “тайлбар тавилаа” гэх хандлагаар насанд хүрэгчид хүүхдээ сонсдоггүй, хүүхэдтэйгээ ярилцдаггүй байх нь. Улмаар өмнөх үр дүнтэй холбож үзвэл, хүүхдүүдээ сонсдоггүй, ярилцдаггүйгээс хүүхдүүдэдээ үүргээ хэт шилжүүлээд байгаагаа анзаардаггүй, мэдэрдэггүй байх талтай. Зарим хүн ам зүйн үзүүлэлтээр задалж үзвэл, “хүүхдэд үзэл бодлоо илэрхийлэх боломж олгож байна гээд эцэг, эхийнхээ өөдөөс тайлбар

тавихыг нь зөвшөөрөх буруу” гэх хандлагатай 40-өөс доош насны, орон сууцад амьдардаг, дээд боловсролтой насанд хүрэгчид бусдаас илүү санал нийлж байна (Хавсралт 11). Тэгэхээр ирээдүйн болон ид насны эцэг эх, асран хамгаалагчдын энэ хандлагыг өөрчлөх чиглэлээр ажиллах нь тун чухал. Гэхдээ энэ ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолгүй бөгөөд энэ нь уг хандлагатай санал нийлж буй насанд хүрэгчид нас, хүйс, боловсрол, амьдардаг байршил, сууц зэргээс үл хамааран ижил байна гэсэн үг. Түүнчлэн, “хүүхдийн саналыг сонсох шаардлагагүй”, “эцэг эхчүүд асуудлыг хүүхдүүдтэйгээ хэлэлцэж шийдвэл эрх мэдлээ алдаж байна гэсэн үг” гэсэн хандлагатай санал нийлж буй цөөхөн насанд хүрэгчийн хувьд эрэгтэйчүүд дийлэнх нь байхаас гадна судалгаанд оролцогчийн нас нэмэгдэх тусам ийм хандлагатай байх талтай байна (Хавсралт 11).

Дээрх дөрвөн хандлагыг нэгтгэн үзвэл, хүүхдийн хүмүүжлийн талаар насанд хүрэгчид сөрөг хандлагатай байх нь түгээмэл байна. Нэн ялангуяа, хүүхдээсээ зохисгүй зүйл хүлээх, хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх, хүүхдэдээ үүргээ шилжүүлэх хандлага тэдний дунд тун өндөр байна. Ийм хандлагууд боловсролын түвшин бага, хотын зах, гэр хороололд амьдардаг, ахимаг насны хүмүүсийн дунд түгээмэл байна. Насанд хүрэгчдийн хувьд хэдийгээр хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг нь хүлээн зөвшөөрөх эерэг хандлагатай боловч “тайлбар тавилаа” гэх хандлагаар хүүхдээ сонсдоггүй, ярилцдаггүй байх талтай байна. Үүнээс эцэг эхчүүд, насанд хүрэгчдэд хүүхдээ сонсох, ярилцах талаар сануулан нөлөөлөх, хэрхэн сонсож, ярилцах аргачлалуудыг заах хэрэгцээ байгаа нь харагдаж байна. Энд онцлон тэмдэглэх зүйл бол хүүхдийн хүмүүжлийн талаар эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс илүү сөрөг хандлагатай байх талтай бөгөөд жендэрийн хэвшмэл үүргийн дагуу эрэгтэйчүүд хүүхэд өсгөн хүмүүжүүлэх ажилд оролцохгүй байх хандлагатай тул энэ талын мэдлэг мэдээллийг сонирхон хүлээж авдаггүйгээс үүдсэн байж болно.

Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага нь хүүхдээ хүмүүжүүлэх дадалтай шууд холбоотой (Жексон нар, 1999; Грусек & Данулуик, 2014) тул тэдний хүүхдийн хүмүүжлийн талаарх сөрөг хандлагуудыг өөрчлөхөд чиглэсэн ажил хийх нь нэн чухал байна. Энэхүү сөрөг хандлагыг арилгахгүй бол хүүхдийн эсрэг хүчирхийлэл, нэн ялангуяа бие махбодын, сэтгэл санааны хүчирхийлэл буурахгүй.

> НАСАНД ХҮРЭГЧДИЙН ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ

Зорилт 2: Насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүний хэлбэрүүдийг ялган таньж байгаа байдал, тэдгээрийг хүчирхийлэл, зүй бус харьцаа гэж хүлээн зөвшөөрч буй байдлыг тодруулах замаар насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх шаардлагатай.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх насанд хүрэгчдийн мэдлэгийг тодруулахын тулд “тийм, үгүй” ба “зөв, буруу” гэсэн хариултын хувилбартай 18 асуулт ашигласан. Эдгээр асуултад бүгдэд нь зөв хариулсан бол хүчирхийллийн талаар хангалттай мэдлэгтэй, 1-2-т буруу хариулсан бол хангалтгүй мэдлэгтэй, бүгдэд нь буруу хариулсан бол огт мэдлэггүй гэж тодорхойлон, дүн шинжилгээ хийлээ.

Судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 6 нь бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн талаар хангалттай мэдлэгтэй байгаа бол 10 хүн тутмын 5 нь сэтгэл санааны хүчирхийллийг таньж чадаж байна. Харин үл хайхрах хүчирхийллийн талаар судалгаанд хамрагдсан насанд хүрэгчдийн 71 хувь нь хангалттай мэдлэггүй байна (График 6).




График 6. Насанд хүрэгчдийн хүчирхийллийн хэлбэрүүдийн талаарх мэдлэг

Түүнчлэн, хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар огт мэдлэггүй байгаа нийт 202 оролцогчийн 139 нь бэлгийн хүчирхийллийн талаар огт мэдлэггүй байна. Бэлгийн хүчирхийллийн талаар мэдлэггүй насанд хүрэгчдийг хүн ам зүйн үзүүлэлтээр харьцуулан харахад 23-40 насны, эрэгтэй, боловсролын түвшин бага, гэр хороололд нийтийн байр, бусдын хашаа байшин түрээслэгч, монгол гэрт амьдардаг оролцогчид байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг хэн ч үйлдэж болох боловч статистикаас харахад хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн ихэнх нь эрэгтэй хүмүүс байдаг. Гэтэл эрэгтэй хүмүүсийн хувьд бэлгийн хүчирхийллийн талаарх хангалттай мэдээлэлгүй байгаа нь эргээд хүчирхийллийг таньж мэдэж, ойлгохгүйгээс хүчирхийллийн шинжтэй үйлдлүүд хийж байж болзошгүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Нөгөө талаас жендэрийн хэвшмэл үүргээс хамааран эрэгтэйчүүд хүүхэд хүмүүжүүлэх, хамгаалах ажилд төдийлөн анхаардаггүй тул энэ талын мэдээлэл авах хэрэгцээ ч гардаггүй байх талтай. Насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэгийг хүчирхийллийн дөрвөн хэлбэрээр нарийвчлан танилцуулъя.

1) Бие махбодын хүчирхийллийн талаарх мэдлэг

Бие махбодын хүчирхийллийн талаар насанд хүрэгчдийн дийлэнх нь хангалттай сайн мэдлэгтэй боловч үүнийг хүчирхийлэл гэж мэдэхгүй хүмүүс байсаар байна (График 7).



График 7. Бие махбодын хүчирхийллийн талаарх мэдлэг

График 7-оос харвал, “хүүхдийг алдаа гаргасных нь төлөө хашраах зорилгоор гарыг нь өргүүлэн шийтгэх нь зөв” гэж судалгаанд оролцогчдын 21 хувь нь хариулсан. Үүнийг насны бүлгээр харахад ялгаа төдийлөн ажиглагдахгүй байна. Байршлын хувьд хотын төвийн 6 дүүргээс судалгаанд хамрагдсан оролцогчдын мэдлэг алслагдсан дүүргийнхнээс хангалтгүй байна. “Хүүхдийг хүмүүжүүлэх зорилгоор зодож шийтгэж болно” гэж 17 хувь нь хариулсан ба БГД, СБД-ийн оролцогчид бусад дүүргийнхнээс мэдлэг тааруу байгаа нь харагдлаа. Харин амьдарч буй хороогоор ялгаа ажиглагдсангүй. Насны бүлгийн хувьд 41-ээс дээш насны, тэтгэвэрт гарсан эсвэл ажил эрхэлдэггүй эмэгтэйчүүдийн бие махбодын хүчирхийллийн талаарх мэдлэг хангалтгүй байна. “Даалгавраа хийсэнгүй гэж багш нь сурагчид гар хүрэх эрхтэй” гэх асуултад насанд хүрэгчдийн 11 хувь нь зөв гэж хариулжээ. Ялангуяа бага боловсролтой болон боловсрол эзэмшээгүй иргэд үүнийг зөв гэж үзэж байна. Мөн 51-60 насны, ажил эрхэлдэггүй эмэгтэйчүүд энэ талаар мэдлэг тааруу нь харагдаж байна (Хавсралт 12).

2) Бэлгийн хүчирхийллийн талаарх мэдлэг

Бэлгийн хүчирхийллийн талаарх насанд хүрэгчдийн мэдлэгийг тодруулах зорилготой асуултуудыг нарийвчлан харвал, “хүүхдийн хажууд +18 хэсэгтэй, агуулгатай кино, жүжиг, клип үзэх нь хүчирхийлэл биш” гэж 24 хувь нь хариулсан бол “хүүхдийг бэлгийн хүчирхийлэлтэй жүжиг, клип, кинонд тоглуулах нь хүчирхийлэл биш” гэж 21 хувь нь хариулжээ (График 8).




График 8. Бэлгийн хүчирхийллийн талаарх мэдлэг

Бэлгийн хүчирхийллийн талаар хэн сайн мэдлэгтэй байгааг харвал эмэгтэйчүүдийн 70 хувь нь, эрэгтэйчүүдийн 64 хувь нь хангалттай мэдлэгтэй байна. Түүнчлэн 18-22 насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү бэлгийн хүчирхийллийн талаар мэдлэгтэй байгаа бол гэр хороололд амьдардаг насанд хүрэгчидтэй харьцуулахад орон сууцанд амьдардаг хүмүүс бэлгийн хүчирхийллийг илүү таньж чадаж байна (Хавсралт 13).

Бэлгийн хүчирхийллийн талаар огт мэдлэггүй хүмүүс бусад төрлийн хүчирхийллийн талаар мэдлэггүй хүмүүсээс их байгааг өмнө дурдсан. Бэлгийн хүчирхийллийн талаар огт мэдлэггүй хүмүүс амьдардаг сууцны төрлөөр нэлээд ялгаатай байгаа ба бусдын хашаа, байшин түрээслэгч болон нийтийн байр, монгол гэрт амьдардаг хүмүүс бэлгийн хүчирхийллийн талаар мэдлэггүй байна. Түүнчлэн, бага боловсролтой, ажил эрхэлдэггүй, УБ хотын алслагдсан 3 дүүрэг болон гэр хороололд амьдардаг насанд хүрэгчид бэлгийн хүчирхийллийн талаар мэдлэг багатай байна (Хавсралт 13).

3) Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх мэдлэг

Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх насанд хүрэгчдийн мэдлэгийг тодруулах асуултуудыг нарийвчлан харвал “хүүхэд өөрөө хүсээгүй боловч түүний ирээдүйн төлөө дургүй секц, дугуйланд явуулах нь буруу” гэж 10 хүн тутмын 9 нь зөв хариулсан байна (График 9).



График 9. Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх мэдлэг

Харин “хүүхдээ даалгавраа хийж чадахгүй байх үед нь тэнэг, мангар гэж зэмлэхгүй байх нь чухал” гэх асуултад 26 хувь нь буруу хариулжээ. Мөн “хүүхдийг хичээлгэхийн тулд бусад хүүхэдтэй харьцуулж шахах нь хүчирхийлэл мөн” гэж 23 хувь нь буруу хариулсан байна. Эдгээр хүний дийлэнх нь хотын захын гэр хороололд амьдардаг, боловсрол багатай, 30-аас дээш насныхан байна (Хавсралт 14).

4) Үл хайхрах хүчирхийллийн талаарх мэдлэг

Үл хайхрах хүчирхийллийн талаарх насанд хүрэгчдийн мэдлэгийг тодруулах зорилготой асуусан асуултуудыг нарийвчлан харвал, “эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдэд хэрэгтэй бүх зүйлийг нь бэлдэж өгдөг ч завгүй учраас хүүхэдтэйгээ ярилцаж, хамт цагийг өнгөрөөхгүй байж болно” гэж 35 хувь нь хариулжээ (График 10).




График 10. Үл хайхрах хүчирхийллийн талаарх мэдлэг

Үл хайхрах хүчирхийллийн талаар хэн сайн мэдлэгтэй байгааг харвал эмэгтэйчүүдийн 30 хувь нь, эрэгтэйчүүдийн 25 хувь нь хангалттай мэдлэгтэй байна. Насны бүлгийн хувьд 18-30 насныхан бусад насны бүлгийн хүмүүстэй харьцуулахад үл хайхрах хүчирхийллийг илүү таньж байна (Хавсралт 15).

Мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага болон насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас үзвэл эцэг эх, асран хамгаалагчид нийгмийн стресс, завгүй амьдралын хэв маягаас үүдэн хүүхэдтэйгээ ярилцахгүй, цагийг хамт өнгөрөөж чадахгүй байна. Үүнээс улбаалан хүүхэдтэйгээ ойлголцохгүй байх, стрессээ хүүхдэдээ гаргах, хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн шинжтэй хүмүүжлийн арга хэрэглэх талтай байна. Иймээс эцэг эх, асран хамгаалагчдад ажил, амьдралын хэв маягаа тэнцвэртэй байлган хүүхдэдээ цаг гаргаж, юу хүсэж байгааг нь сонсож, ярилцдаг байх нь чухал гэдгийг ойлгуулах хэрэгтэй.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх хандлага

Судалгаанд оролцсон насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх хандлагыг тодруулахдаа хүчирхийллийн төрөл бүрээр өгсөн бодомжуудтай санал нийлж байгаа эсэхийг нь 0-10 оноогоор үнэлүүлэн тодорхойлов.

1) Бие махбодын хүчирхийллийн талаарх хандлага

Судалгаанд оролцогчдын бие махбодын хүчирхийллийн талаарх хандлага дунджаар 3.97 оноотой бөгөөд энэ нь насанд хүрэгчдийн 60 орчим хувь нь бие махбодын хүчирхийллийг үл дэмжих эерэг хандлагатай гэсэн үг (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Бие махбодын хүчирхийллийн талаарх хандлага

Бодомж	Дундаж оноо
Бид нар ч гэсэн аав ээждээ зодуулж өссөн, тэглээ гээд буруудсан зүйл алга.	4.57
Бие махбодын шийтгэлийг уурандаа санамсаргүй үйлддэг.	3.66
Хүүхдэд хааяа нэг алганы амт үзүүлэх нь тэдний хүмүүжилд сайнаар нөлөөлнө.	3.68
Дундаж	3.97

Тэмдэглэл: 0-10 оноо; 0-огт санал нийлэхгүй, 10 санал бүрэн нийлж байна.

Дээрх хүснэгтээс нарийвчлан харвал, “бид нар ч гэсэн аав ээждээ зодуулж өссөн, тэглээ гээд буруудсан зүйл алга” гэх хандлага насанд хүрэгчдийн 46 орчим хувьд нь байна. Насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас үзэхэд “зодуулж өссөн”, “зодуулж байж л ойлгодог”, “гурван удаа ороолговол хүүхдийн гай нь гардаг” гэх мэт хандлага мэдэгдэж байсан юм.

Иймэрхүү хандлага хотын төвөөс алслагдсан гэр хороололд амьдардаг, 41-ээс дээш насны, боловсролын түвшин багатай, сууцны хувьд бусдын хашаа, байшин түрээслэгч эсвэл монгол гэрт амьдардаг хүмүүсийн дунд түгээмэл ажиглагдаж байна (Хавсралт 16). Энэхүү дүнгээс харахад, тухайн хүний багадаа амссан хүмүүжлийн туршлага нь эргээд өөрийн хүүхдээ хүмүүжүүлэх хандлагын суурь болж байгаа тул нэн ялангуяа ирээдүйн эцэг эх болох хүмүүсийн энэ талын хандлагыг зайлшгүй өөрчлөх шаардлага байна.

...Хүүхдээ зодож байгаа ахимаг насныхныханд та ингэж болохгүй хүүхэдтэйгээ ярилц, дуугаа намсгаад, зөөлөн хэлээд үз гэхээр угаасаа ойлгохгүй. Манай хүүхэд зодуулж байж ойлгодог гэдэг. Мөн “миний үед хүүхдийг зоддог байсан”, “зодуулж байж л хүүхэд ойлгодог”, “3 удаа ороолговол хүүхдийн гарз гардаг” гэх мэт уламжлалт үг хэллэгүүд хэлээд байдаг.

Насанд хүрэгчдийн фокус бүлгийн ярилцлагаас

2) Бэлгийн хүчирхийллийн талаарх хандлага

Судалгаанд оролцогчдын 65 орчим хувь нь бэлгийн хүчирхийллийг эрс эсэргүүцэх эерэг хандлагатай байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Бэлгийн хүчирхийллийн талаарх хандлага

Бодомж	Дундаж оноо
Хүүхдийн хажууд +18 кино үзэх нь хүчирхийлэл.	6.14
Охид өмсөж буй хувцас, хийж буй үйлдлээсээ болоод бэлгийн хүчирхийлэлд өртдөг.	6.35
Хүүхдийг хүсээгүй байхад биед нь хүрэх, үнэсэх нь хүчирхийлэл.	6.98

Тэмдэглэл: 0-10 оноо; 0-огт санал нийлэхгүй, 10 санал бүрэн нийлж байна. Хоёр дахь бодомжийг эсрэгээр уншина. Бодомж нь эерэг, сөрөг аль аль утгаар томъёологдсон тул дундаж гарахгүй.

Дээрх хүснэгтээс нарийвчлан харвал, “хүүхдийн хажууд +18 кино үзэх хүчирхийлэл”, “хүүхдийг хүсээгүй байхад биед нь хүрэх, үнэсэх нь хүчирхийлэл” гэх хандлагыг олонх нь дэмжиж байгаа ч нийт оролцогчийн 37-39 хувь нь тэдгээр бодомжийг илт эсэргүүцэх хандлага нь сул байна. Харин “охид өмсөж буй хувцас, хийж буй үйлдлээсээ болоод бэлгийн хүчирхийлэлд өртдөг” гэх хандлагыг судалгаанд оролцогчдын 69 хувь нь эсэргүүцэж байгаа ч 31 орчим хувийнх нь хандлага сул байна. Насны бүлгээр авч үзвэл 31-ээс дээш насныхан дээрх хандлагыг хүлээн

зөвшөөрөхгүй байх нь дунджаар 62 хувьтай байгаа бол 18-30 насныхны хувьд 56 орчим хувьтай байна. Өөрөөр хэлбэл, 44 хувь нь энэ хандлагыг хүчтэй эсэргүүцэхгүй байна гэсэн үг. Түүнчлэн, эрэгтэйчүүд, боловсрол багатай, алслагдсан дүүргийн насанд хүрэгчид энэ хандлагыг хүчтэй эсэргүүцэхгүй байна (Хавсралт 17). Тиймээс хэдий олонх нь бэлгийн хүчирхийллийг үл зөвшөөрөх эерэг хандлагатай байгаа боловч дээр дурдсан онцлох бүлгүүдэд чиглэсэн хандлага өөрчлөх арга хэмжээ авах шаардлагатай.

3) Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх хандлага

Судалгаанд оролцогчдын 67 орчим хувь нь сэтгэл санааны хүчирхийллийг хүчтэй эсэргүүцэх эерэг хандлагатай (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Сэтгэл санааны хүчирхийллийн талаарх хандлага

Бодомж	Дундаж оноо
Хүүхдийн саналыг асууж, хамтын шийдэл гаргахгүйгээр түүний ирээдүйн төлөө дургүй секц, дугуйланд явуулах нь хүчирхийлэл.	6.51
Буруу зүйл хийсэн хүүхдийг загнахаас өөр аргагүй.	5.58
Уйлж байгаа хүүхдээ болиулахын тулд “Би явлаа шүү”, “Ганцааранг нь үлдээнэ” гэж сүрдүүлж дуугүй болгоно.	2.82

Тэмдэглэл: 0-10 оноо; 0-огт санал нийлэхгүй, 10 санал бүрэн нийлж байна. Хоёр, гурав дахь бодомжийг эсрэгээр уншина. Бодомж нь утга эерэг, сөрөг аль аль утгаар томъёологдсон тул дундаж гарахгүй.

Хүснэгтээс үзвэл, “уйлж байгаа хүүхдээ болиулахын тулд “би явлаа шүү”, “ганцаараа үлдээрэй гэж сүрдүүлж дуугүй болгоно” гэх хандлагыг судалгаанд оролцогчдын 78 хувь нь дэмжихгүй буюу эерэг хандлагатай байна гэсэн үг. Харин “хүүхдийн саналыг асууж, хамтын шийдэл гаргахгүйгээр түүний ирээдүйн төлөө дургүй секц, дугуйланд явуулах нь хүчирхийлэл” гэх хандлагыг нийт оролцогчийн 65 хувь хүчтэй илэрхийлж байгаа ч 35 хувийнх нь хандлага төдийлөн хүчтэй биш байна. Мөн “буруу зүйл хийсэн хүүхдийг загнахаас өөр аргагүй” гэх хандлагыг 45 хувь нь хүчтэй эсэргүүцэж чадахгүй буюу хандлага тааруу байна. Сэтгэл санааны хүчирхийллийг хүчтэй эсэргүүцэхгүй буюу хандлага султай хүмүүсийн дунд 51-ээс дээш насны, эмэгтэй, боловсролын түвшин багатай хүн зонхилж байна (Хавсралт 18).

4) Үл хайхрах хүчирхийллийн талаарх хандлага

Үл хайхрах хүчирхийллийн талаарх насанд хүрэгчдийн хандлагын дундаж 2.08 бөгөөд энэ нь насанд хүрэгчдийн 80 орчим хувь нь энэ төрлийн хүчирхийллийг эрс эсэргүүцэх эерэг хандлагатай гэсэн үг (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Үл хайхрах хүчирхийллийн талаарх хандлага

Бодомж	Дундаж оноо
Гэртээ хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэх нь байх л зүйл.	0.94
Хүүхэд хөнгөн өвдсөн тохиолдолд эмчид үзүүлэхгүйгээр өөрсдөө мэдээд эм өгнө.	2.85
Хүүхэд харах хүн байдаггүй учраас хүүхдүүдээ гэрт нь түгжээд ажилдаа явахаас өөр аргагүй.	2.46
Дундаж	2.08

Тэмдэглэл: 0-10 оноо; 0-огт санал нийлэхгүй, 10 санал бүрэн нийлж байна.

Дээрх хүснэгтээс харвал, “гэртээ хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэх нь байх л зүйл” гэх хандлагыг насанд хүрэгчдийн 90 хувь нь хүчтэй эсэргүүцэж байгаа нь сайн үр дүн юм. Хэдий архидалтын асуудал нийгэмд их байгаа ч насанд хүрэгчдийн хувьд хүүхдийнхээ дэргэд архи хэрэглэж болохгүй гэх хандлага түгээмэл байгаа нь сайшаалтай. Хүн ам зүйн үзүүлэлтээр нарийвчилбал, эрэгтэй, хотын захад, гэр хороололд амьдардаг, боловсрол багатай хүмүүсийн хандлага бусдынхаас ялимгүй сул байна (Хавсралт 19).

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх дадал

Судалгаанд оролцсон 1,202 насанд хүрэгчийн 835 нь өрхөд 18-аас доош насны хүүхэд байдаг гэж мэдүүлсэн. Эдгээр оролцогчийн хувьд хүүхдэд ямар нэг хэлбэрээр хүчирхийллийн шинжтэй үйлдэл гаргасан эсэхийг энэ судалгаагаар мөн хөндсөн болно.

Насанд хүрэгчид хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн шинжтэй аргуудыг ашигласаар байна (График 11).



График 11. Хүчирхийлэл үйлдэх дадал

График 11-ээс харахад, насанд хүрэгчдийн хувьд сэтгэл санааны болон үл хайхрах хүчирхийллийг үйлдэх дадал бие махбодынхоос харьцангуй өндөр байна. Хүчирхийллийн төрөл бүрээр насанд хүрэгчдийн дадлыг дэлгэрүүлэн тайлбарлая.

1) Бие махбодын хүчирхийлэл үйлдэх дадал

Хүүхдэд бие махбодын шийтгэл хэзээ ч үзүүлж байгаагүй гэж насанд хүрэгчдийн 73-87 хувь, өнгөрсөн жилийн хувьд бие махбодын шийтгэл хүлээлгээгүй гэж 6-9 хувь нь хариулжээ (Хүснэгт 14).

Хүснэгт 14. Сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхдийн эсрэг үзүүлсэн бие махбодын шийтгэл (хувь)

№	Бие махбодын хүчирхийлэл	1-2 удаа	3-5 удаа	6-10 удаа	>10 удаа	Өнгөрсөн жил үгүй	Хэзээ ч үгүй
1	Өшиглөсөн	12	3	1	1	9	73
2	Толгой руу цохисон	12	3	-	1	8	75
3	Чимхсэн	7	2	-	1	6	83
4	Саваа, шүүр, шаахай, таяг, бүс зэргээр цохисон	7	1	1	-	6	83
5	Дух руу нясалсан	5	3	1	1	6	85
6	Гарыг нь өргүүлж эсвэл юм өргүүлж зогсоосон	6	1	1	1	6	85
7	Чихийг мушгисан	4	1	-	-	7	87

Насанд хүрэгчдийн мэдүүлснээр тэдний дийлэнх нь бие махбодын хүчирхийлэл хэрэглэдэггүй боловч 13-27 хувь бие махбодын шийтгэлийг ямар нэг хэлбэрээр хүүхдэд хүлээлгэж байна. Тодруулбал, хүүхдийг өшиглөх, толгой руу цохих үйлдлийг сүүлийн нэг жилд 1-2 удаа гаргасан гэжээ. Ерөнхийд нь харвал бие махбодын хүчирхийлэл үйлдэж байгаа насанд хүрэгчдийн хувьд ийм үйлдлийг олон удаа гаргадаггүй нь хүснэгтээс харагдаж байна.

Эцэг эх, асран хамгаалагчдын хамгийн түгээмэл хэрэглэдэг шийтгэл (Хавсралт 20)-ийн хоёр хэлбэрээр авч үзвэл, бага насны эрэгтэй хүүхдүүд илүүтэй бие махбодын хүчирхийлэлд өртөж байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. Хүүхдийн эсрэг бие махбодын түгээмэл шийтгэл (хүүхдийн нас, хүйс, хувь)

Шийтгэл	Хүүхдийн хүйс		Хүүхдийн насны бүлэг				Насанд хүрэгчдийн хүйс	
	Эрэгтэй	Эмэгтэй	0-5	6-9	10-14	15-18	Эрэгтэй	Эмэгтэй
Хүүхдийг өшиглөсөн								
1-2 удаа	84	64	52	47	57	23	36	64
3-5 удаа	88	62	62	54	65	8	50	50
6-10 удаа	90	80	70	50	70	30	20	80
>10 удаа	91	45	36	82	36	27	36	64
Хүүхдийн толгой руу цохисон								
1-2 удаа	85	74	48	57	52	27	26	74
3-5 удаа	84	64	52	52	76	8	44	56
6-10 удаа	75	50	0	75	75	0	0	100
>10 удаа	86	71	71	71	43	29	43	57

Бага насны, эрэгтэй хүүхдүүд хөдөлгөөн ихтэй байдаг, түүнийг нь хүлээн зөвшөөрч, ойлгож харилцах тэвчээр дутагдсанаас энэ бүлгийн хүүхдүүд бие махбодын шийтгэл бусдаас илүү амсдаг болох нь харагдаж байна. Түүнчлэн, бие махбодын хүчирхийлэл үйлдэж буй хүмүүсийн хувьд дийлэнх нь эмэгтэйчүүд байна. Гэхдээ энэ нь эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд “хэрцгийдээ” биш харин жендэрийн хэвшмэл үүргийн дагуу хүүхдийг асран халамжлах, хүмүүжүүлэх ажил тэдэнд голлон ногддоогоос ийм дүн харагдаж байж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн, ам бүлийн тоо олон, огт гэрлэж байгаагүй хүмүүс бие махбодын хүчирхийллийг олон давтамжтайгаар үйлдэх хандлага ажиглагдлаа. Насны бүлэг ахих тусам энэ төрлийн хүчирхийлэл үйлдэх давтамж нь буурах төлөв харагдаж байгаа нь эмээ өвөө нь ач зээгээ илүү их энхрийлэн хайрлаж, гар хүрдэггүйтэй холбоотой байж болно.

Насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас үзвэл, хүүхдэд, нэн ялангуяа Монгол хүүхдэд бие махбодын шийтгэл хүлээлгэх нь зөв, тийм учраас хүүхдэдээ “хэрэгтэй цагт нь биед нь мэдрүүлж байх” хэрэгтэй гэж хэлэх хүн олон байна.

Хэдийгээр олонх насанд хүрэгчийн хувьд бие махбодын шийтгэл хэзээ ч хэрэглэж байгаагүй гэж мэдүүлсэн боловч ярилцлагын үр дүнг авч үзвэл бие махбодын шийтгэл хүлээлгэх нь бодит байдалд тэдний хэлснээс арай их давтамжтай байх магадлалтай байна. Насанд хүрэгчдийн дунд “багадаа зодуулж өссөн гээд буруудсан зүйл алга” гэх хандлагыг дэмждэг хүмүүс олон байсныг өмнө дурдсан билээ. Тэгэхээр насанд хүрэгчдийн энэ хандлага нь бие махбодын хүчирхийлэл үйлдэх дадлыг үргэлжлүүлсээр, бэхжүүлсээр байна.

...Гадаадын хүүхдүүдийг Монгол хүүхдүүдтэй харьцуулах боломжгүй. Монгол хүүхдүүдийг ер нь чанга гараар хүмүүжүүлэхгүй бол болдоггүй. Бид нар бага байхдаа аав, ээжээсээ алганы амт үздэг байсан. Тэглээ гээд муудсан юм алга. Гэтэл зодохыг хүчирхийллийн нэг хэлбэр гээд үгүйсгэнэ. Монгол хүүхдүүдийн цусанд байдаг зэрлэгдүү зан чанар хэзээ ч өөрчлөгдөхгүй. Алган боов амсуулдгаараа амсуулаад явахаас өөр арга байхгүй.

Насанд хүрэгчдийн фокус бүлгийн ярилцлагаас

Ихэнх насанд хүрэгчийн хувьд хүүхдийг зодож шийтгэх нь буруу гэдгийг мэддэг ч ийм үйлдэл гаргаад байдгийн учрыг тэднээс болон хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдээс лавласан юм. Насанд хүрэгчдийн хувьд нэрлэсэн голлох хоёр шалтгаан нь нэг талаас хүүхдийг хүмүүжүүлэхийн тулд ийм үйлдэл гаргадаг гэсэн бол нөгөө талаас уур бухимдал, стрессээ барьж чадахгүй, өөрийгөө хянах, тэвчих чадваргүйгээс болдог гэж хариулсан байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Хүүхдээ зодож шийтгэж болохгүйг мэддэг ч үйлддэгийн шалтгаан

Шалтгаан	Тоо	Хувь	Хүйс (хувь)	
			Эрэгтэй	Эмэгтэй
Хүмүүжүүлж, ойлгуулж байгаа арга хэлбэр	419	35	16	18
Уур бухимдал, стрессээ барьж чаддаггүй	400	33	25	26
Хэлж мэдэхгүй байна	82	7	8	6
Ухамсар, боловсрол тааруу	78	6	9	4
Буруу л гэдгийг нь мэднэ	46	4	4	4
Харилцаж, ойлголцож чаддаггүй байдал	32	3	2	3
Хүмүүжлийн өөр арга мэдэхгүй	22	2	2	2
Дадал зуршил	20	2	2	2
Зодвол үгэнд орно	6	0	1	0

Үүнээс насанд хүрэгчдийн хувьд хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлдэх дадал нь эргээд тэдний хандлагатай шууд хамааралтай байгааг харж болно. Насанд хүрэгчдийн хувьд хүүхдийг зодож шийтгэх нь хүмүүжлийн зөв арга гэдэгт итгэдэг учраас үйлдлийн шалтгааныг ийнхүү тайлбарлаж байна. Түүнчлэн, 10 хүн тутмын 6 нь бие махбодын хүчирхийллийн талаар бүрэн мэдлэгтэй байсан, харин үлдсэн 4 хүн нь мэдлэггүйгээс ийм хандлага гаргаж, энэ нь үйлдэл болж илэрдэг байх талтай. Тийм учраас энэ хандлага, дадлыг өөрчлөхийн тулд хүүхдийг

зодож шийтгэхийн хор уршгийг сайтар таниулах ажил зохион байгуулах хэрэгтэй. Үнэндээ хүүхдийг зодож шийтгэх нь зөвхөн тухайн үед л хүүхдийн буруу зан үйлийг “засах” бөгөөд урт хугацаандаа хүүхэд түрэмгий авиртай болох, өөртөө итгэхээ болих, өвчин ээрэмтгий болдгийг мета-анализ судалгаагаар нотолсон байдаг (Гершофф & Гроган-Кейлар, 2016). Түүнчлэн, уур бухимдал, стрессээ барих, өөрийгөө хянах чадварт насанд хүрэгчдийг сургах зайлшгүй хэрэгцээг тэдний нэрлэсэн шалтгаанаас бэлхнээ харж болно.



... Хүүхэд эцэг, эхийнхээ үгэнд орохгүй уурыг нь хүргэж тэвчээрийг нь барснаас болж эцэг, эх тэвчиж чадахгүй гар хүрдэг байх. Зодохгүй л бол эвээр хэлээд ойлгодоггүй хэцүү хүүхдүүд байдаг.

... Миний бодлоор 2 шалтгаантай. Нэгдүгээрт насанд хүрэгчид багадаа аав ээждээ зодуулж өссөн тул хүүхэд хүмүүжлийн шилдэг аргыг зодох гээд ойлгочихсон хүмүүс бий. Нөгөө талаар хүүхдээ хэт эрхлүүлснээс болж хүүхэд нь үгэнд нь орохгүй зөрүүдэлснээс болж хүчирхийллийн шинжтэй хүмүүжлийн аргууд ашиглаж байна.

... Хүүхэд нь буруу зүйл хийснээс болж аав ээжүүд нь гар хүрдэг байх. Эцэг эхдээ зодууллаа гээд буруудах зүйлгүй. Бид нар бүгдээрээ л зодуулж, загнуулж өссөн.

Насанд хүрэгчдийн фокус бүлгийн ярилцлагаас

Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар, насанд хүрэгчид бие махбодын шийтгэлийг хүүхэд хүмүүжлийн нэг арга гэж итгэдэг, хүүхдүүд мөн энэ аргыг байх л зүйл гэж итгэж өсдөг гэнэ. Энэ нь хүүхэд санаа бодол, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар султай насанд хүрэгч болон төлөвшихөд нөлөөлж байна гэж мэргэжилтнүүд үзэж байна.



... Зодож шийтгэхийг эцэг эх, асран хамгаалагчид уламжлалт арга гэж тайлбарладаг. Жишээ нь би бага байхдаа зодуулдаг байсан муудаагүй, үхээгүй л байна гэж л тайлбарладаг.

... Зарим нь аргаа барсан үедээ гар хүрдэг байх, зарим нь байнга гар хүрээд сурчихсан байдаг. Хүүхэд хүмүүжлийн буруу аргаасаа салж чадахгүй байна. Хүүхдүүд нь ч зодуулаад дадчихсан, эвээр хэлээд ойлгохгүй заавал цохиулж зодуулж, чанга дүүгаар хэлүүлж байж ойлгодог болчихсон байдаг. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ буруу зам руу битгий орчхоосой, сайн хүн болоосой гэсэн дээ л ингэдэг гэж өөрсдийгөө өмөөрдөг. Тиймээс насанд хүрэгчдэд хүмүүжлийн эерэг аргуудыг ойлгуулж тэдэнд дадал болгоход арга хэмжээ зохион байгуулах нь зайлшгүй юм.

Мэргэжилтнүүдтэй ярилцсан ганцаарчилсан ярилцлагаас

2) Сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх дадал

Судалгаанд оролцогчдын 44-87 хувь нь хүүхдийг хэзээ ч сэтгэл санааны хувьд хүчирхийлэх үйлдэл гаргаж байгаагүй гэсэн бол 5-6 хувь нь өнгөрсөн жил ийм үйлдэл гаргаагүй гэжээ (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхдэдээ үзүүлсэн сэтгэл санааны хүчирхийлэл (хувь)

№	Сэтгэл санааны хүчирхийлэл	1-2 удаа	3-5 удаа	6-10 удаа	>10 удаа	Өнгөрсөн жил үгүй	Хэзээ ч үгүй
1	Хэлсэн зүйл нэг чихээр нь ороод нөгөө чихээр нь гардаг гэхчлэн загнасан	24	16	5	6	5	44
2	Дүлий, залхуу зэргээр нэрлэж хочилсон	18	11	4	5	5	57
3	Бусадтай харьцуулсан	15	6	1	1	6	70
4	Бүтэлгүй, унхиагүй, өөдтэй хүн болохгүй гэхчлэн харааж загнасан	7	2	-	2	6	82
5	Бусдын буруутай үйлдэлд хүүхдийг буруутгасан	9	3	-	1	6	79
6	Орхиж явна эсвэл гэрээсээ хөөнө гэж сүрдүүлсэн	7	2	-	-	6	84
7	Олны өмнө эвгүй байдалд оруулсан	4	1	-	-	6	87

Дээрх хүснэгтээс харвал, өнгөрсөн нэг жилийн хугацаанд 1-2 удаа хүүхдийг “хэлсэн зүйл нэг чихээр нь ороод нөгөө чихээр гардаг гэхчлэн загнасан” гэж нийт эцэг эх, асран хамгаалагчийн 24 хувь мэдүүлжээ. Мөн “дүлий, залхуу зэргээр нэрлэж хочлох”, “бусадтай харьцуулах” үйлдэл гаргадаг гэж насанд хүрэгчдийн 24 болон 18 хувь нь тус тус хариулсан байна. Гэхдээ олон удаагийн давтамжтай үйлдэх нь бага байна.

Эцэг эх, асран хамгаалагчдын хамгийн түгээмэл үйлддэг сэтгэл санааны хүчирхийлэл (Хавсралт 21)-ийн гурван хэлбэрийг авч үзвэл охид, хөвгүүд ялгаагүй энэ төрлийн хүчирхийлэлд өртөх талтай байна. Түүнчлэн, бусад бүлэгтэй харьцуулахад 10-14 насны хүүхдүүд илүүтэй сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх төлөвтэй аж (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Хүүхдийн эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх дадал (хувь)

Сэтгэл санааны хүчирхийлэл	Хүүхдийн хүйс		Хүүхдийн насны бүлэг				Насанд хүрэгчдийн хүйс	
	Эрэгтэй	Эмэгтэй	0-5	6-9	10-14	15-18	Эрэгтэй	Эмэгтэй
Хэлсэн зүйл чинь нэг чихээр нь ороод нөгөө чихээр нь гардаг гэхчлэн хүүхдийг загнасан								
1-2 удаа	71	73	49	46	51	30	43	58
3-5 удаа	78	71	39	52	63	30	29	71
6-10 удаа	72	72	49	49	65	21	33	67
>10 удаа	81	66	43	45	70	28	30	70
Дүлий, залхуу зэргээр нэрлэж хочилсон								
1-2 удаа	73	74	48	41	56	30	42	58
3-5 удаа	75	70	49	50	59	26	22	78
6-10 удаа	53	83	43	50	67	13	40	60
>10 удаа	80	65	43	35	65	40	30	70
Хүүхдийг бусадтай харьцуулсан								
1-2 удаа	71	74	44	55	51	28	39	61
3-5 удаа	72	67	50	54	70	17	41	59
6-10 удаа	91	45	82	18	73	27	9	91
>10 удаа	78	44	33	33	78	11	33	67

Сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх дадалтай насанд хүрэгчдийн дунд эмэгтэйчүүд нэлээд өндөр хувьтай байна. Энэ нь нэг талаас үнэн байж болох ч нөгөө талаас хүүхдийг асран халамжлах гол үүргийг эмэгтэйчүүд хүлээдгээс ийм зөрүү ажиглагдаж байх талтай. Түүнчлэн, бие махбодын хүчирхийлэл үйлдэх давтамж өндөртэй хүмүүс мөн адил сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх давтамж өндөртэй байгаа нь харагдсан болно.

3) Үл хайхрах хүчирхийлэл үйлдэх дадал

Судалгаанд оролцогчдын 65-91 хувь нь хүүхдийг хэзээ ч үл хайхарч байгаагүй гэсэн бол 5-6 хувь нь өнгөрсөн жил ийм үйлдэл гаргаагүй гэжээ (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхдэдээ үзүүлсэн үл хайхрах хүчирхийлэл (хувь)

№	Үл хайхрах хүчирхийлэл	1-2 удаа	3-5 удаа	6-10 удаа	>10 удаа	Өнгөрсөн жил үгүй	Хэзээ ч үгүй
1	Томчуудын хараа хяналтгүй байдлаас болж хүүхэд бэртсэн	14	1	-	-	6	78
2	Хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэсэн	13	5	1	3	5	72
3	Хүүхдийн хоол ундыг анхаараагүй	10	5	2	1	6	76
4	Хүүхдээ цахим орчинд хэнтэй нөхөрлөж байгааг ярилцаагүй	9	7	2	9	6	65
5	Хүүхдийг гэрт нь цоожилж орхисон	8	3	1	3	6	78
6	Хүүхдэд улиралд тохиромжгүй хувцас өмсгөсөн	5	-	-	-	6	87
7	Хүүхдийг өвдсөн үед нь асрахгүй орхиж байсан	3	-	-	-	6	91

Дээрх хүснэгтээс харвал, өнгөрсөн нэг жилийн хугацаанд “хүүхэд томчуудын хараа хяналтгүй байдлаас болж бэртсэн” гэж нийт эцэг эх, асран хамгаалагчийн 14 хувь мэдүүлжээ. Мөн “хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэсэн” гэж насанд хүрэгчдийн 13 хувь нь тус тус хариулсан байна. Гэхдээ олон удаагийн давтамжтай үйлдэх нь бага байна. Хэдийгээр хүүхдийн хажууд “гэртээ архи, тамхи хэрэглэх нь байх л зүйл” гэх хандлагыг насанд хүрэгчдийн 90 хувь нь хүчтэй эсэргүүцэх хандлагатай байсан ч энэхүү үйлдлийг гаргадаг нь харагдаж байна.

Эцэг эх, асран хамгаалагчдын хамгийн түгээмэл үйлддэг үл хайхрах хүчирхийлэл (Хавсралт 22)-ийн гурван хэлбэрийг авч үзвэл насны бүлэг болон охид, хөвгүүд ялгаагүй энэ төрлийн хүчирхийлэлд өртөх талтай байна (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Хүүхдийн эсрэг үл хайхрах хүчирхийлэл үйлдэх дадал (хувь)

	Хүүхдийн хүйс		Хүүхдийн насны бүлэг				Насанд хүрэгчдийн хүйс	
	Эрэгтэй	Эмэгтэй	0-5	6-9	10-14	5-18	Эрэгтэй	Эмэгтэй
Хүүхэд томчуудын хараа хяналтгүй байдлаас болж бэртсэн.								
1-2 удаа	76	66	55	41	52	21	48	52
3-5 удаа	71	57	57	14	57	43	71	29
6-10 удаа	100	100	100	-	100	-	100	-
10-аас дээш удаа	100	100	-	-	100	-	100	-
Хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэсэн.								
1-2 удаа	75	70	53	45	55	24	50	50
3-5 удаа	75	80	60	58	58	28	60	40
6-10 удаа	90	40	50	70	50	30	50	50
10-аас дээш удаа	72	59	45	38	45	21	76	24
Хүүхдийн хоол ундыг анхаараагүй								
1-2 удаа	67	73	43	46	52	24	40	60
3-5 удаа	73	58	43	55	33	25	45	55
6-10 удаа	54	85	46	31	69	38	38	62
10-аас дээш удаа	58	75	50	25	50	33	50	50

Өрхийн орлогын түвшин нэмэгдэхэд үл хайхрах хүчирхийллийн дадал, давтамж дагаад нэмэгдэх талтай нь статистик шинжилгээгээр илэрсэн болно.

Хүүхдийн эсрэг бие махбодын, сэтгэл санааны, үл хайхрах хүчирхийлэл үйлдэх дадал нь хоорондоо хүчтэй хамааралтай (0.54-0.58, Sig=0.000) байна. Тиймээс аль нэг сөрөг дадлыг бууруулахад бусад сөрөг дадлууд үйлдэгдэх нь ч дагаад багасах талтай тул үүнийг шийдвэр гаргагчид болон хэрэгжүүлэгчид анхаарах хэрэгтэй.

4) Хүчирхийллийн бус арга хэрэглэх дадал

Насанд хүрэгчдийн хувьд бие махбодын, сэтгэл санааны, үл хайхрах хүчирхийллийн аргыг хүүхдээ хүмүүжүүлэхдээ хэрэглэж буй байдлыг өмнө танилцууллаа. Үүнээс гадна энэ судалгаагаар тэдний хувьд хүчирхийллийн бус буюу эерэг арга хэрэглэх дадлыг мөн тандсан болно. Насанд хүрэгчдийн хувьд 22-38 хувь нь хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн бус арга байнга хэрэглэдэг гэж мэдүүлсэн (График 12).



График 12. Хүчирхийллийн бус арга хэрэглэх дадал

График 12-оос харахад, насанд хүрэгчдийн дийлэнх нь давтамж өөр боловч хүчирхийллийн бус аргыг хэрэглэдэг байна. Харин “хүүхэд буруу зүйл хийсэн бол яагаад ингэх болов гэдгийг асууж ярилцдаггүй” эцэг эх, асран хамгаалагч 8 хувь байгаа бол “хүүхдийг бусадтай харьцуулахгүйгээр хувь хүн талаас нь ханддаггүй”, “хүүхдийн насны онцлогийг ойлгон харьцаж чаддаггүй” гэсэн хүмүүсийн хувь тус бүр 6 байна. Эдгээр насанд хүрэгч нь өмнө дурдсан хүчирхийллийн аргуудыг хэрэглэдэг гэдгээ өмнө мэдүүлсэн хүмүүс дийлэнх хувийг эзэлж байна. Түүнчлэн, хүчирхийллийн бус аргуудыг хааяа хэрэглэдэг гэж үзсэн оролцогчид 21-35 хувийг эзэлж байна. Хүйсээр нарийвчлан харвал, эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад хүмүүжлийн эерэг дадал багатай байна (Хүснэгт 21).

Хүснэгт 21. Хүчирхийллийн бус арга хэрэглэх дадал (хувь)

Хүн ам зүйн үзүүлэлт	Хүүхдийг загнаж зодолгүйгээр юуг буруу хийснийг нь тайлбарлаж өгдөг эсэх		Хүүхэд буруу зүйл хийсэн бол яагаад ингэх болов гэдгийг асууж, ярилцдаг эсэх		Хүүхдийн насны онцлогийг ойлгож харьцдаг эсэх		Хүүхдийн хийсэн буруу үйлдлийн үр дагаврыг тайлбарлаж ойлгуулдаг эсэх		Хүүхдийг бусад хүүхэдтэй харьцуулахгүйгээр хувь хүн гэдэг талаас нь ханддаг эсэх	
	Огт үгүй	Байнга	Огт үгүй	Байнга	Огт үгүй	Байнга	Огт үгүй	Байнга	Огт үгүй	Байнга
Насны бүлгээр										
18-22	17	83	29	71	18	82	10	90	7	93
23-30	11	89	30	70	16	84	14	86	13	87
31-40	12	88	18	82	14	86	8	92	11	89
41-50	17	83	30	70	24	76	14	86	13	87
51-60	8	92	34	66	12	88	8	92	24	76
61+	7	93	29	71	20	80	8	92	14	86
Хүйсээр										
Эрэгтэй	18	82	37	63	23	77	13	87	16	84
Эмэгтэй	7	93	18	82	11	89	9	91	11	89
Боловсролын түвшнээр										
Дээд	8	92	16	84	10	90	5	95	6	94
Тусгай дунд	3	97	28	73	17	83	15	85	14	86
Бүрэн дунд	14	86	32	68	19	81	12	88	18	82
Суурь	27	73	50	50	32	68	20	80	24	76
Бага	40	60	25	75	40	60	67	33	17	83
Боловсрол эзэмшээгүй	0	100	50	50	50	50	40	60	50	50

“Хүүхдийг загнаж, зодолгүйгээр юу буруу хийсэн талаар тайлбарлаж өгдөг” гэж хариулсан оролцогчдыг хүн ам зүйн үзүүлэлтүүдээр нарийвчлан харвал насны бүлгийн хувьд 51-ээс дээш насныхан сайн дадалтай байгаа бол эрэгтэйчүүдийн 18 хувь нь юу буруу хийсэн талаар огт тайлбарлаж өгдөггүй байна. Түүнчлэн, “хүүхдийн насны онцлогийг ойлгож харьцдаггүй” гэж хариулсан оролцогчдын дийлэнх нь боловсролын түвшин бага, эрэгтэйчүүд байна. Иймээс эрэгтэйчүүдэд хүүхдээ хүчирхийллийн бус аргаар хэрхэн хүмүүжүүлэх талаарх мэдлэг, ойлголтыг өгөх нь шаардлагатай.

Хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх дадал хоорондын хамаарал

Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага нь тэднийг хүчирхийлэл үйлдэх дадалтай ямар хамааралтай байгаа эсэхэд анализ хийсэн. Ингэхэд дараах үр дүн гарсан болно:

- Хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл үйлдэх дадалтай насанд хүрэгчид хүүхэд хүмүүжлийн хандлагуудаас “өсвөр насны хүүхдүүд эцэг эхээ сонсохгүй, зөрөөд байвал гэрээсээ явж болно гэж тэдэнд хэлэх хэрэгтэй”, “хүүхдэд нүүр өгвөл улам давардаг” гэсэн сөрөг хандлагыг дэмжих талтай байна.

- Хүүхдийн эсрэг сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх дадалтай насанд хүрэгчид хүүхдийн хүмүүжлийн хандлагуудаас мөн л “хүүхдэд нүүр өгвөл улам давардаг”, “одоогийн хүүхдүүд бүх юм нь бэлэн, жаргалтай өсөж байна”, “өсвөр насны хүүхдүүд эцэг эхээ сонсохгүй, зөрөөд байвал гэрээсээ явж болно гэж тэдэнд хэлэх хэрэгтэй” гэх хандлагыг дэмжих талтай байна.
- Үл хайхрах хүчирхийлэл үйлдэх дадалтай хүмүүс нь хүүхдийн хүмүүжлийн хандлагаас “хүүхдэд нүүр өгвөл улам давардаг”, “үзэл бодлоо илэрхийлэх боломж олгож байна гээд эцэг эхчүүд хүүхдүүдэдээ тайлбар тавихыг зөвшөөрөх нь буруу” гэх хандлагатай байна.
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бус арга хэрэглэх дадалтай хүмүүс нь хүүхэд хүмүүжлийн хандлагуудаас “Хүүхдийг үргэлж магтах нь түүний өөртөө итгэх итгэлийг бэхжүүлэх сайн арга”, “Хүүхэд анхаарал татахын тулд л үйлддэг” гэсэн хандлагыг дэмжих талтай байна. Үүнээс эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийг үргэлж магтах нь зөв арга гэж ташаа ойлгож байгаа нь харагдаж байгаа бөгөөд үүнийг чухам яагаад буруу хандлага гэдгийн учрыг өмнө тайлбарласан билээ.

Хүүхэдтэй зүй бус харьцдаг хүмүүс

Судалгаанд оролцсон насанд хүрэгчдийн 57 хувь нь хүүхэдтэй зүй бус харьцдаг хүнийг тухайн хүүхдийн аав гэж тодорхойлж байна (График 13).




График 13. Хүүхэдтэй зүй бус харьцдаг хүмүүс (хувь)

Энэ нь жендэрийн хэвшмэл үүргээс хамааран эрэгтэйчүүд хүүхдийн хүмүүжил, асрамж хамгааллын асуудалд идэвхтэй оролцдоггүйгээс хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудын талаар мэдэхгүй байгаатай холбоотой байж магад. Түүнчлэн, тэдгээр эрэгтэйчүүд багадаа эцэг эх, асран хамгаалагчаасаа бие махбодын шийтгэл хүртэж өссөн байж болох ба сурсан аргаараа өөрсдийнхөө хүүхдэд ч хандаж байж болно. Өмнө танилцуулснаар, эрэгтэй хүүхдүүд бие махбодын шийтгэл хүлээх нь эмэгтэй хүүхдээс их байгаа бөгөөд энэ нь цаашид эдгээр эрэгтэй хүүхэд насанд хүрч, эцэг болохоороо өөрсдийн туулсан зүйлээ хүүхдэдээ мөн л амсуулж болзошгүй. Ийм байдлаар хүчирхийлэл, зүй бус үйлдлийн цикл эргэлдэх тул насанд хүрэгчид, тэр дундаа эрэгтэйчүүдэд хүүхдийн хүмүүжил, хамгааллын талаарх мэдээллийг өгөх, тэдний хүүхэд хамгаалалд оролцох хувь нэмрийг нэмэгдүүлэх талаас нь анхаарах цаг нэгэнт болжээ. Хүүхэдтэй зүй бусаар хэн харьцдагийг цааш нь задалж харвал, эмэгтэйчүүдийн хувьд аавуудыг нэрлэсэн бол эрэгтэйчүүдийн хувьд ээжүүдийг нэрлэсэн байна. Түүнчлэн, хүүхэдтэй зүй бус харьцдаг хүмүүсийн дунд хүүхдийн эцэг эхийн дараа үе тэнгийнхэн, найз нөхөд нь орж байгааг хүснэгтээс харж болно.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл тулгамдсан асуудлын нэг болох нь

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг тулгамдаж буй асуудлын нэг гэж хүлээн зөвшөөрч буй эсэхийг нь насанд хүрэгчдээс мөн тандсан. Ингэхэд хүүхдийн эсрэг хүчирхийлэл тэдний эрэмбэлсэн асуудлуудын дөрөвт буюу 10 хүн тутмын 1-2 нь энэ бол анхаарах ёстой асуудал гэж үзэж байна (График 14).




График 14. Хүүхдэд тулгарч асуудал (хувь)

Дээрх графикаас харахад, судалгаанд оролцогчид хүүхдэд тулгамдаж буй асуудлаас нэгдүгээрт агаарын бохирдол, хоёрдугаарт гэр бүл салалт, гуравдугаарт сургууль, цэцэрлэгийн хүрэлцээгүй байдлыг дурдаж байна. Энэхүү судалгааны мэдээллийг өвлийн ид хүйтний улирал болох 1-2 дугаар сард цуглуулсан тул насанд хүрэгчдийн хувьд агаарын бохирдлыг ийнхүү тэргүүн зэргийн асуудал гэж үзсэн байх талтайг энд онцлох хэрэгтэй. Хүүхдэд тулгамдаж буй асуудлыг нэрлэхдээ эрэгтэйчүүд гэр бүл салалтыг онцолж байгаа бол эмэгтэйчүүд агаарын бохирдлыг тэргүүн асуудал гэж үзжээ. Түүнчлэн, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хоол хүнсний баталгаа, хүүхдэд ээлтэй орчин зэрэг системийн шинжтэй асуудлуудыг насанд хүрэгчид дурдсанаас гадна гэр бүл салалт, архидалт, багшийн чанаргүй байдал зэрэг хүчирхийлэл үүсгэж болох асуудлыг ч нэрлэжээ. Мөн насанд хүрэгчдийн 15 хувь нь сургуулийн орчин дахь үе тэнгийнхний дарамтыг тулгамдсан асуудлаар нэрлэсэн байна. Мөн хүүхэдтэй зүй бусаар харьцдаг хүмүүсийн аав, ээжийн дараа гуравдугаарт үе тэнгийнхэн, дөрөвдүгээрт найз нөхөд нь орж байгааг өмнө дурдсан.

Хүүхэд хүчирхийлэлд өртдөг орчин

Судалгааны хүрээнд бид насанд хүрэгчдээс гадна хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдээс хүүхэд ер нь хаана, ямар орчинд хүчирхийлэлд өртөөд байгаа талаар чанарын аргаар мөн мэдээлэл цуглуулсан. Үр дүнг нэгтгэж үзвэл, хүүхэд нийгмийн бүх орчинд хүчирхийлэлд, нэн ялангуяа сэтгэл санааны хүчирхийлэл, зүй бус үйлдэлд өртөж байгаа нь харагдсан болно (Зураг 7). Гэр бүл, сургуулиас гадна бусад нийгмийн орчинд, тодруулбал нийтийн тээврийн унаанд хүүхдүүд бие махбод, сэтгэл санаа, бэлгийн зүй бус үйлдэл, хүчирхийлэлд өртөж байгаа нь ярилцлагаас өмнө харагдсан болно (Зураг 8). Үүнээс үзвэл, нийтийн тээврийн үйлчилгээнд эрс шинэчлэл хийж, сайжруулахад л хүүхдийн эсрэг аливаа төрлийн зүй бус үйлдлийг бууруулахад чухал хувь нэмэр оруулахаар байна. Тэгэхээр хүүхдийг бүхий л хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх, үр дүнтэй болгоход нэг талаас насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадлыг өөрчлөн сайжруулах нь нэг стратеги мөн боловч нөгөө талаас нийгмийн суурь асуудлуудаа шийдэх нь чухал болохыг эндээс харж болно.



ГЭР БҮЛИЙН ОРЧИН

Бие махбодын хүчирхийлэл

- Зодох

Сэтгэл санааны хүчирхийлэл

- Бусадтай харьцуулах
- Хувийн орон зайд халдах
- Хүүхдийн итгээд ярьсан зүйлийг бусдад задруулах
- Хүүхдийг өөрийнхөө хүслээр байлгах гэж оролдох
- Би чиний төлөө энэ бүхнийг хийж байна гэж дарамтлах, загнах
- Гэр бүлийн таагүй уур амьсгалд байлгах

Үл хайхрах хүчирхийлэл

- Хүүхдийг архи, тамхинд явуулах
- Хүүхдийн хажууд тамхи татах, архи уух



СУРГУУЛИЙН ОРЧИН

Бие махбодын хүчирхийлэл

- Багш нь даалгавар хийсэнгүй гэж гар хүрэх

Сэтгэл санааны хүчирхийлэл

- Үе тэнгийнхэн нь дээрэлхэх
- Багш, үе тэнгийнхэн нь ялгаварлан гадуурхах
- Эдэлж хэрэглэж буй зүйлийг нь шоолох, дооглох
- Багш нар хүүхдүүдийг хооронд нь харьцуулах
- Нэг нэгэндээ нэр хоч өгөх
- Доромжлох
- Шилжиж ирсэн сурагчдыг дээрэлхэх
- Хүүхдийн хувийн мэдээлэл задруулах

Бэлгийн хүчирхийлэл

- Хөвгүүд, охидын биед зөвшөөрөлгүй хүрэх, хөх, бөгсийг нь базах
- +18 агуулгатай онигоо ярих, зураг, бичлэг үзүүлэх

Үл хайхрах хүчирхийлэл

- Багш нь сурлага тааруу хүүхдийг тоохгүй орхих



НИЙГМИЙН ОРЧИН

Бие махбодын хүчирхийлэл

- Зодолдох

Сэтгэл санааны хүчирхийлэл

- Явган хүний замаар тамхи татан алхаж, хүүхдийг дам хордуулах
- Гудамж талбай, тоглоомын талбайд томчууд архи уух
- Хүүхдээ өмөөрч бусдын хүүхдийг загнах
- Согтуу хүмүүс хүүхдийг дуудах, мөнгө нэхэх

Бэлгийн хүчирхийлэл

- Автобусанд ойрхон зогсох, наалдаж зогсох
- Удаан ширтэх



ЦАХИМ ОРЧИН


Сэтгэл санааны хүчирхийлэл

- Хүүхдийн зураг, бичлэгийг тараах, сүрдүүлэх
- Нэр төрд нь халдсан пост хийх, коммент бичих
- Хэвлэл мэдээлэл, цахим орчинд хүчирхийлэл өртсөн хүүхдийн зураг, нэр, нас, хүйс гэх мэт хувийн мэдээллийг нийтлэх

Бэлгийн хүчирхийлэл

- Танихгүй хүнээс бэлгийн харилцааны шинжтэй бичлэг, зураг ирэх

Зураг 7. Хүүхдүүдийн хүчирхийлэлд өртөж буй орчин, хүчирхийллийн хэлбэрүүдээр



Зураг 8. Нийтийн тээврийн унаанд хүүхдүүд хүчирхийлэлд өртөж буй байдал

Хүүхэд хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй хүчин зүйл

Чанарын судалгаагаар хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг нийгмийн, гэр бүлийн хүчин зүйл, хэвшмэл ойлголт, хандлагуудаас гадна хүүхдээс өөрөөс нь хамаарсан хүчин зүйл байна гэж насанд хүрэгчид болон хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд үзэж байна (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд нөлөөлж буй хүчин зүйл

Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйл
<ul style="list-style-type: none"> • Нийгмийн стресс • Архидалт • Ажилгүйдэл • Түгжрэл • Жендэрийн хэвшмэл ойлголт • Хотын буруу төлөвлөлт, хүүхдэд ээлгүй орчин • Агаарын бохирдол • Үнийн өсөлт • Эдийн засгийн хямрал • Эрүүл мэндийн байгууллага, сургууль, цэцэрлэгийн хүрэлцээгүй байдал
Гэр бүлийн орчинд хүүхэд хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй хүчин зүйл
<ul style="list-style-type: none"> • Хүүхэд хамгааллын талаар эцэг, эх, асран хамгаалагчдын мэдлэггүй байх • Гэр бүлийн салах • Гэр бүлийн хэн нэгэн гишүүн нь архины хамааралтай байх • Архидах • Хүүхдийг архи, тамхинд явуулах • Хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэх • Эцэг эхийн боловсролын түвшин доогуур байх • Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс хүүхдээ хараа хяналтгүй орхих • Эцэг, эхийн хоорондын харилцаа таарамжгүй, байнга хэрүүл маргаантай байх • Орлогогүй, амьжиргааны түвшин доогуур байх • “Амьд харилцаа” байхгүй, хоорондоо ярилцдаггүй байх • Аав, ээжүүдэд чөлөөт цаг байхгүйн улмаас хүүхдэдээ анхаарал хандуулахгүй байх • Эцэг эх, асран хамгаалагч нь гэрээсээ хол ажилладаг байх
Хүүхэд хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй хэвшмэл ойлголт, хандлагууд
<ul style="list-style-type: none"> • Барын зулзагыг бага дээр нь • Буруу хүмүүжсэн хүүхэд бухын хүзүүнээс хатуу • Аав ээжийн аль нэг нь чанга хатуу байхгүй бол хүүхдүүд даварна • Хүүхэд зодуулж байж л үг авдаг • Бидний үед ... • Аав, ээждээ зодууллаа гээд буруудаагүй
Хүүхдээс шалтгаалж буй хүчин зүйл
<ul style="list-style-type: none"> • Хүүхдүүд хэт их утас, дэлгэцийн хамааралтай байх • Зөрүүд зантай, дуулгаваргүй байх • Өсвөр насны хүүхдүүд олон ааш гаргах • Дураараа загнах

Хүснэгтээс үзэхэд, насанд хүрэгчид болон хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдийн хувьд хүүхэд өөрөө хүчирхийлэл, зүй бус үйлдлийн шалтгаан болж байна гэж дүгнэсэн бөгөөд дэлгэцээс хамааралтай байх, зөрүүд, дуулгаваргүй байх, олон ааш гаргах, дураараа загнах зэрэг буруу зан авир, үйлдлийг нь засахын тулд тийнхүү хүүхэдтэй зүй бусаар харьцаж байгаа талаар дурджээ. Өмнөх үр дүнгүүдтэй холбон үзвэл, насанд хүрэгчид “хүүхэд эцэг эх, томчуудын үгнээс зөрөхгүй байх, дуулгавартай байх ёстой” гэх хандлагыг түгээмэл илэрхийлж байсан бөгөөд энэхүү хандлага нь эргээд тэдний хүүхдээ хүмүүжүүлэх дадал буюу хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн шинжтэй аргуудыг хэрэглэхэд нь нөлөөлж байгааг энд дахин баталж байна. Мөн “олон юм ярилаа, илүү үгтэй, тайлбар тавилаа” гэх хандлагын үүднээс эцэг эх, асран хамгаалагчид хүүхэдтэйгээ нээлттэй ярилцдаггүйгээс хүүхдэд нь ямар хэрэгцээ, асуудал байгааг олж мэддэггүй, зүгээр л олон ааш гаргалаа, эцэг эхийнхээ үгээс зөрлөө, энэ нь хүүхдийн буруу учраас шийтгэж, хүүхдийг зөв зан үйлд сургана гэж үзэж байгаа нь мөн харагдаж байна.

Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах арга зам

Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах хамгийн сайн арга замын талаар насанд хүрэгчдээс мөн энэ судалгаагаар тодруулсан. Тэдний 22 хувь нь хүүхэдтэйгээ нээлттэй ярилцаж, ойлголцох нь хүүхдийг хүчирхийллээс хамгаалах хамгийн сайн арга зам гэж нэрлэж байна (График 15).



График 15. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хүүхдийг хамгаалах хамгийн сайн арга зам (хувь)

Өмнөх үр дүнтэй холбон үзвэл, насанд хүрэгчид “хүүхдийг даврааж, олон юм яриулж, тайлбар тавиулж болохгүй” гэж хандлагыг 10 хүн тутмын 4-5 нь дэмжих талтайгаас хүүхэдтэйгээ ярилцдаггүй, тэдний хэрэгцээ, сонирхол, асуудлыг сонсдоггүй, эцэг эх нь өөрсдийнхөө төрж өссөн орчин, цаг үеэрээ баримжаалан хүүхдийнхээ хэрэгцээ, сонирхол, асуудлыг хүүхдийн өмнөөс төсөөлж байна. Энэ графикаас харахад, хүүхэдтэйгээ нээлттэй ярилцах, түүгээр дамжуулан хүүхэддээ аливаа зүйлийг ойлгуулах нь хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах хамгийн сайн арга гэж насанд хүрэгчид үзэж байгаа нь тэд өөрсдийнхөө асуудал буюу хүүхэдтэйгээ харилцах, хүүхдээ хүмүүжүүлэхдээ гаргадаг алдаа дутагдлаа ойлгон хүлээн зөвшөөрч буйг харуулах талтай. Гагцхүү хүүхэдтэйгээ нээлттэй ярилцах ёстой гэдгээ мэдэвч хэрхэн нээлттэй байж, ярилцах вэ гэдэг аргаа олдоггүй, мэддэггүй байж болно. Тиймээс насанд хүрэгчдэд хүүхэдтэй ярилцах, аливааг хүүхдийнхээ нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хэрхэн тайлбарлан ойлгуулах талаар нарийвчилсан, алхамчилсан мэдээллийг өгөх нь зүйтэй.

Түүнчлэн, 10 хүн тутмын 2 нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хамгааллын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх замаар тэднийг мэдлэгтэй болгох нь хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах хамгийн сайн аргын нэг юм гэж үзжээ. Өмнө дурдсанаар, 10 хүн тутмын 7 нь үл хайхрах хүчирхийлэл, зүй бус үйлдлийн талаар хангалттай мэдлэггүй, 10 хүн тутмын 3-5 нь бие махбод, бэлгийн, сэтгэл санааны хүчирхийллийн талаар хангалтгүй мэдлэгтэй байсан. Энэ нь насанд хүрэгчдэд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, тэдгээрийн хэлбэрүүд, сөрөг үр дагаврын талаарх мэдлэг олгох шаардлагыг баталж байна. Хүчирхийллийн талаар мэдлэгтэй болж байж түүнийг үйлдэхгүй байх мэдлэг, хандлага, дадалтай болох, улмаар хүчирхийллийг мэдээлэх, хүүхдийг хамгаалах ойлголт, хандлага, дадал тогтох тул хүчирхийллийн хэлбэрүүд, сөрөг үр дагаврын тухай мэдээллийг нийтэд сурталчлан ойлгуулахын нэн чухлыг энд онцолъё. Үүнтэй холбоотойгоор дараагийн хэсэгт насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын мэдлэг, хандлага, дадлыг харуулсантай танилцаарай.

> НАСАНД ХҮРЭГЧДИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ

Зорилт 3: Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодруулах.

Хүүхэд хамгаалал нь нийгмийн бүхий л орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ юм. Хүүхдийг хамгаалахад насанд хүрэгчдийн оролцоо чухал бөгөөд зөвхөн гэр бүл бус нийгмийн бусад орчинд хүүхдийг хамгаалах хандлага, дадал ямар буйг илрүүлэх нь чухал.

Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэгийг үнэн ба худал хариулт бүхий 15 асуултаар шалгасан. Эдгээр асуултад бүгдэд нь зөв хариулсан бол хүүхэд хамгааллын талаар бүрэн мэдлэгтэй, 12-14 асуултад зөв хариулсан бол хангалттай мэдлэгтэй, 8-11 асуултад зөв хариулсан бол дунд зэргийн мэдлэгтэй, 1-7 асуултад зөв хариулсан бол хангалттай мэдлэггүй, бүгдэд нь буруу хариулсан бол талаар огт мэдлэггүй гэж үзлээ. Түүнчлэн, оролцогчдоос хүүхэд хамгааллын мэдлэгээ өөрсдөө хэрхэн үнэлж байгааг тандсан (График 16).




График 16. Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг (бодит, өөрийн үнэлгээ)

График 16-аас харахад, судалгаанд хамрагдсан 1,202 насанд хүрэгчийн 6 хувь нь хүүхэд хамгааллын талаар маш сайн мэдлэгтэй, 34 хувь нь хангалттай мэдлэгтэй, 53 хувь нь дунд зэргийн мэдлэгтэй, 8 хувь нь хангалттай мэдлэггүй байна. Огт мэдлэггүй хүн алга байв. Харин судалгаанд оролцогчдын 36 хувь нь өөрсдийгөө маш сайн мэдлэгтэй, 35 хувь нь сайн мэдлэгтэй, 20 хувь нь дунд зэрэг мэдлэгтэй, 9 хувь нь хангалттай мэдлэггүй гэж үзжээ. Хүүхэд хамгааллын талаар маш сайн болон сайн мэдлэгтэй байгаа насанд хүрэгчдийн нийт хувь нь 40 бол өөрсдийн үнэлгээний энэ түвшин нь 71 байна. Өөрөөр хэлбэл, 10 хүн тутмын 7 нь өөрийгөө хүүхэд хамгааллын талаар сайн, маш сайн мэдлэгтэй үздэг бол 10 хүний 4 нь л бодит байдалд сайн, маш сайн мэдлэгтэй байна.

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх бодит мэдлэгийн түвшинг хүн ам зүйн зарим үзүүлэлтээр шинжилж, тэдгээр үзүүлэлтээр мэдлэг ялгаатай байгаа эсэхийг нягталсан болно (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Хүүхэд хамгааллын мэдлэг (хувь)

Хүн ам зүйн үзүүлэлтүүд	Маш сайн мэдлэгтэй	Сайн мэдлэгтэй	Дунд зэрэг мэдлэгтэй	Хангалттай мэдлэггүй
Насны бүлэг				
18-22	11	46	41	3
23-30	9	41	48	3
31-40	6	40	48	6
41-50	4	29	56	11
51-60	2	22	62	15
61-ээс дээш	0	12	75	13
Амьдарч буй хорооны байршил				
Хотын захын хороо	6	28	56	10
Хотын төвийн хороо	9	39	48	4
Хотын төвд ойр хороо	4	38	51	8
Амьдарч буй хорооллын төрөл				
Орон сууц	7	40	46	6
Гэр хороолол	4	27	59	10
Сууцны төрөл				
Орон сууцны байшин (байр)	8	40	46	6
Бие даасан тохилог сууц (хаус)	6	25	69	0
Сууцны тусдаа байшин	4	28	59	9
Нийтийн байр	9	26	56	9
Оюутны байр	0	75	25	0
Бусдын хашаа, байшин түрээслэгч	0	32	57	11
Монгол гэр	3	26	59	12
Боловсролын түвшин				
Дээд боловсролтой	9	45	41	5
Тусгай дунд боловсролтой	5	18	64	14
Бүрэн дунд боловсролтой	4	30	58	8
Бүрэн бус дунд боловсролтой	0	16	71	13
Бага боловсролтой	0	15	54	31
Боловсрол эзэмшээгүй	0	25	63	13
Ажил эрхлэлт				
Төрийн байгууллага	6	33	53	8
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	5	34	54	7
Хувийн байгууллага	6	34	52	8
Тэтгэвэрт	0	20	60	19
Ажил эрхэлдэггүй	2	38	51	9
Оюутан	13	42	44	0
Өөрийн болон бусдын хүүхэдтэй амьдардаг байдал				
Өөрийн хүүхэдтэй	7	37	50	7
Бусдын хүүхэдтэй	2	27	60	11
Өөрийн болон бусдын хүүхэдтэй	0	21	69	10
Гэрлэлтийн байдал				
Гэрлэлтээ албан ёсоор батлуулсан	5	30	55	10
Гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй ч хамтран амьдарч байгаа	3	36	55	6
Өмнө нь гэрлэж байсан	2	31	59	9
Өмнө нь хамтран амьдрагчтай байсан	3	36	50	11
Огт гэрлэж, хамтран амьдарч байгаагүй	1	40	45	4

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг нь насны бүлэг, амьдарч буй байршил, сууцны төрөл, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал болон өөрийн болон бусдын хүүхэдтэй амьдардаг эсэхээс хамаарсан ялгаа нь статистикийн ач холбогдолтой байна. Өөрөөр хэлбэл, эдгээр үзүүлэлтээс хамааран насанд хүрэгчдийн мэдлэг өөр өөр байна гэсэн үг. Тодруулбал, судалгаанд оролцогчдын насны бүлэг залуу байх тусам хүүхэд хамгааллын талаарх мэдлэг сайтай байгаа бол нас ахих тусам мэдлэгийн түвшин буурч байна. Энэ нь нэг талаас нас ахимаг хүмүүсийн хувьд хүүхдүүд нь насанд хүрснээс үүдэн энэ төрлийн мэдээллүүд хэрэгцээгүй болдогтой холбоотой байж болно. Нөгөө талаас насны бүлгээс үл хамааран бүх хүн хүүхэд хамгааллын талаар хангалттай сайн мэдлэгтэй бол хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг мэдээлж, хүүхдийг хамгаалах боломж нэмэгдэх талтайг мартаж болохгүй. Хотын төвөөс алслагдсан, гэр хороололд амьдарч буй, монгол гэрт эсвэл бусдын хашаа, байшин түрээсэлдэг хүмүүсийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэгийн түвшин хотын төвд, орон сууцанд амьдардаг хүмүүсийнхээс бага байна. Боловсролын түвшин өндөр, ажилтай хүмүүсийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг сайн байна. Түүнчлэн, гэр бүл зохиогоогүй залуусын хүүхэд хамгааллын талаарх мэдлэгийн түвшин бусад бүлгийнхнээс өндөр байгаа юм. Мөн өрхөд зөвхөн өөрийн хүүхэдтэйгээ эсвэл дүүтэйгээ амьдарч буй насанд хүрэгчдийн мэдлэгийн түвшин бусдын хүүхэдтэй амьдарч буй насанд хүрэгчдээс даруй 15 хувиар өндөр байна. Харин насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг нь хүйс, дүүрэг, гэр бүлийн бүтцээр статистикийн ач холбогдолтой ялгаагүй байна.

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэгийг шалгах асуултад багтсан хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой 8 асуултын үр дүнг дэлгэрүүлэн үзье (Хүснэгт 24).

Хүснэгт 24. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таних байдал

#	Асуулт	Үнэн		Худал	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Эмнэлгийн туслалцаа авах шаардлагагүйгээр хүүхдийг гэмтээсэн бол хүчирхийлэл гэж үзэхгүй.	264	22	938	78
2	Ихэнх хүүхэд биеэ авч яваа байдлаасаа болж бэлгийн хүчирхийлэлд өртдөг.	749	62	453	38
3	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хамгийн бага хүчирхийлэлд өртдөг.	354	30	848	71
4	Хүүхдийг хамгаалах тухай хууль манай улсад байдаггүй.	484	40	718	60
5	Хүүхдэд анхаарал халамж тавиагүйг үл хайхрах байдал гэж үзэж, арга хэмжээ авч болно.	959	80	243	20
6	Хүүхэд голдуу гэр бүл, эргэн тойрны таньж мэдэх хүмүүсийн хүчирхийлэлд өртсөн байдаг.	1,036	86	166	14
7	Хүүхдийнхээ нүцгэн зургийг фейсбүүктээ тавьж болохгүй.	1,090	91	112	9
8	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нэр, зургийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үзүүлж болно.	115	10	1,087	90

Дээрх хүснэгтээс харахад, насанд хүрэгчид хүчирхийлэл, тэдгээрийн төрлүүдийн талаар хангалттай мэдлэгтэй байна. Гэвч насанд хүрэгчдийн 10 хүн тутмын 6 нь хүүхдүүд биеэ авч яваа байдлаасаа болж бэлгийн хүчирхийлэлд өртдөг гэсэн буруу мэдээлэлтэй байгаа нь анхаарал татаж байна. Энэ нь бэлгийн хүчирхийллийн хохирогчийг буруутгах хандлага түгээмэл байгааг илтгэж байгаа бөгөөд үүнээс болж хохирогчид хэргийг мэдээлэлгүй нуух, улмаар хүчирхийлэлд дахин өртөх эрсдэл гарахыг үгүйсгэхгүй. Тиймээс энэ чиглэлээр олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх шаардлагатай. Хүн ам зүйн зарим үзүүлэлтээр нарийвчлан үзвэл, 41-ээс дээш насны, эрэгтэй, боловсролын түвшин багатай, ажил эрхэлдэггүй, хотын захад, гэр

хороололд амьдардаг хүмүүс байна (Хавсралт 23). Цаашилбал, 10 насанд хүрэгч тутмын 4 нь Монгол Улсад хүүхэд хамгаалах тухай хууль байдаггүй гэж хариулсан нь базаахгүй үр дүн юм. Мөн 10 хүн тутмын 3 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хүчирхийлэлд бага өртдөг гэсэн ташаа ойлголттой байна. Эдгээр ташаа ойлголт, буруу мэдээллийг засах чиглэлээр ажиллах хэрэгтэй.


Хүүхэд хамгааллын талаарх насанд хүрэгчдийн өөрсдийнх нь ойлголт

Насанд хүрэгчдээс хүүхэд хамгаалал гэдгийг хэрхэн ойлгож буйг нь нээлттэй асуултаар асуухад 22 хувь нь хүүхдийг эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд өсгөх гэсэн бол 15 хувь нь хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалах гэж хариулжээ (Хүснэгт 25, Зураг 9).

Хүснэгт 25. Насанд хүрэгчид хүүхэд хамгааллыг ойлгож буй байдал

Ойлголт	n=1,202		Насны бүлэг					
	Нийт	Хувь	18-22	23-30	31-40	41-50	51-60	61+
Хүүхдийг эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд өсгөх, амьдруулах	262	22	32%	29%	25%	17%	11%	5%
Хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалах	176	15	13%	11%	15%	15%	20%	14%
Хүүхдэд эцэг, эх нь хараа, хяналт тавих	142	12	12%	14%	12%	13%	8%	9%
Хүүхдийн үг, үзэл бодлыг сонсож ярилцах	111	9	10%	14%	10%	7%	5%	4%
Хүүхдийн эрхийг хамгаалах, дээдлэх	102	8	10%	12%	5%	9%	8%	9%
Хүүхдээ зөв хүмүүжүүлэх	84	7	4%	6%	7%	5%	13%	11%
Бүх төрлийн хүчирхийллээс хамгаалах	83	7	11%	7%	6%	6%	8%	8%
Эцэг, эхийн асаргаа, асран хамгаалах	69	6	4%	3%	5%	7%	6%	12%
Хүүхдэдээ эцэг, эхийн хайр халамж мэдрүүлэх	63	5	2%	4%	6%	4%	6%	10%
Хүүхдийн эрхийг зөрчихгүй байх	59	5	5%	6%	5%	4%	5%	1%
Мэдэхгүй	55	5	2%	3%	5%	6%	8%	3%
Хүүхдийн сэтгэл санааг нь тайван байлгах	49	4	8%	8%	2%	4%	1%	2%
Зөвхөн асран хамгаалагч бус нийгмээрээ хүүхдийг хамгаалах	47	4	1%	2%	2%	5%	8%	9%
Хүүхдийн эрүүл мэндэд анхаарч, эрүүл саруул өсгөх	43	4	2%	3%	4%	3%	3%	7%
Хүүхдийн бүх төрлийн хэрэгцээ шаардлагыг хангах	38	3	5%	3%	2%	3%	4%	3%

Хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг насны бүлгээр ангилан харвал залуучууд буюу 30-аас доош насныхан хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдруулах, бүх төрлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн үг, үзэл бодлыг сонсож, ярилцах, хүүхдийн сэтгэл санааг тайван байлгах зэргээр хүүхэд хамгааллыг ойлгож байна. Харин 31-ээс дээш насныхан хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалах, хүүхдээ зөв хүмүүжүүлэх, эцэг, эхийн хайр халамжийг мэдрүүлэх зэргээр хариулсан байна.



Зураг 9. Насанд хүрэгчдийнхээр хүүхэд хамгаалал гэж...

Насанд хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас үзэхэд, хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд өсгөх, үзэл бодлоо илэрхийлэхэд нь сонсож анхаарах, аливаа осол гэмтэл, эрсдэлээс хамгаалах, гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэхийг хүүхэд хамгаалал гэж ойлгож байна. Эдгээр тодорхойлолт нь тоон үр дүнтэй ерөнхийдөө ижил байна.

Энэхүү тоон болон чанарын үр дүнг нийлүүлэн дүгнэвэл, насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт, тодорхойлолтод хүүхдийн хүмүүжил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, эрүүл, аюулгүй орчин гэх санаа илэрч байна. Энэхүү судалгаагаар хүүхэд хамгааллын хүрээнд хүүхдийн хүмүүжил, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлуудыг нарийвчлан хөндсөн нь насанд хүрэгчдийн ойлголттой нийцэж байгааг энд тэмдэглэе. Түүнчлэн, насанд хүрэгчдийн хүүхэд хамгаалал гэсэн ойлголтод эцэг эх гэх хэллэг ажиглагдаж байгаа нь хүүхэд хамгаалалд тэд голлох үүрэгтэйг онцолж байна гэж дүгнэж байна.

Яг дээрхтэй холбоотойгоор насанд хүрэгчдийн дунд хүүхдийг зөвхөн эцэг эх, асран хамгаалагч, багш нь хамгаалах ёстой гэсэн тогтсон ойлголт байгааг тоон судалгааны дүн харуулж байна (График 17).

Судалгаанд оролцогчдын 90 хувь нь хүүхдийг аав, ээж нь хамгаалах ёстой гэсэн бол 433 буюу 36 хувь нь багш хамгаалах ёстой гэжээ. Харин 132 насанд хүрэгч буюу 11 хувь нь хүүхдийг нийгмийн бүхий л орчинд хүн бүр хамгаалах ёстой гэж хариулсан байна. Ингэж хариулсан хүмүүс нь голчлон 18-30 насны, дээд боловсролтой, орон сууцанд амьдардаг оролцогчид аж. Хүүхдийг бүх хүн хамгаалах ёстой гэж 10 хүний 1 нь ойлгож буйг үргэлжлүүлэн нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага, дадал ямар байгааг авч үзье.

Нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага, дадал

Судалгаанд оролцсон насанд хүрэгчид нийгмийн орчинд буюу тухайн хүний эргэн тойронд хүүхэд аль нэг төрлийн хүчирхийлэл, зүй бус үйлдэлд өртөж байвал хамгаалах эсэх хандлага, түүнчлэн тийм үйлдэлтэй таарсан бол хүүхдийг хамгаалж байсан дадлыг тандсан юм.

Ингэхэд нийт судалгаанд оролцогчийн 84 болон түүнээс дээш хувь нь гудамж талбай гэх мэт нийгмийн орчинд хүүхэд ямар нэг зүй бус үйлдэл, хүчирхийлэлд өртөж байвал хамгаалах арга хэмжээ авна гэсэн бол яг ийм үйлдэл хийж байсан дадал нь харьцангуй сул байна (Хүснэгт 26, График 18).





График 17. Хүүхдийг хэн хамгаалах ёстой талаарх насанд хүрэгчдийн санаа бодол

Хүснэгт 26. Нийгмийн орчинд хүүхэд хамгаалах хандлага, дадал (хувь)

Асуулт	Хандлага			Дадал		
	Шаардана	Шаардахгүй	Эргэлзэж байна	Шаардсан	Шаардаагүй	Ийм зүйлтэй таараагүй
1) Гудамжинд бага насны хүүхэд айсан байдалтай ганцаараа зогсож байвал аав ээж нь хаана байгааг асууж, анхаарал тавих	98	1	1	90	7	3
2) Замын гарцаар хамт гарч байгаа хүүхдүүдэд анхаарал хандуулах	98	1	1	73	13	13
3) Гудамжинд зодолдож буй хүүхдүүдэд шаардлага тавьж, болиулах	95	2	3	71	18	11
4) Гудамжинд хэсэг залуус өсвөр насны хоёр охиныг хоргоож бэлхүүс, бөгсөн хэсэгт нь хүрч, яасан хөөрхөн юм бэ гэж инээлдэж буйг харсан бол тэдний үйлдэл буруу гэдгийг хэлэх	94	3	3	65	8	27
5) Хүүхдэд архи, тамхи гэх мэт зохисгүй зүйл худалдаалж байгаа хүмүүст шаардлага тавьж болиулах	92	4	4	53	31	16
6) Тамхи татаж, архи ууж байгаа хүүхдүүдтэй таарвал болиулах	91	4	5	52	24	24
7) Гудамжинд хэрэлдэн муудалцаж буй хүүхдүүдэд шаардлага тавьж, болиулах	91	5	4	40	45	16
8) Хүүхдийн тоглоомын талбайд тамхи татаж буй хүмүүст шаардлага тавьж болиулах	90	4	5	33	16	52
9) Хүүхдээ өвлийн хүйтэнд нимгэн хувцаслан гудамжинд авч яваа хүнтэй таарвал тэр хүнд сануулж шаардлага тавих	85	6	8	31	32	37
10) Гудамжинд хүүхдээ зандчин, загнаж яваа хүнд хүүхэдтэйгээ буруу харьцаж байгааг нь хэлж шаардлага тавих	85	6	9	30	32	38
11) Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн зураг, нэрийг харуулж байгаа хэвлэлийн байгууллага, ажилтанд шаардлага тавих	84	6	10	14	59	28

**График 18. Нийгмийн орчинд хүүхэд хамгаалах хандлага, дадал (хувь)**

Дээрх хүснэгтээс харвал, гудамж талбайд хүүхдүүд бие биетэйгээ муудалцах, зодолдох, архи, тамхи хэрэглэх, бусад хүүхдэд зүй буй үйлдэл гаргаж буй болон ганцаараа яваа, замын хөдөлгөөнд оролцож байгаа хүүхдүүдэд анхаарал тавьж, хамгаалах хандлага сайн буюу 10 хүн тутмын 9 нь эдгээрт анхаарал хандуулна гэдгээ илэрхийлсэн байна. Харин дээр дурдсан үйлдлүүдтэй таараад, хүүхдийг хамгаалах ямар нэг арга хэмжээ авч байсан тухайд 10 хүн тутмын 3-9 нь тийм гэжээ. Үүнээс харахад, насанд хүрэгчдийн нийгмийн орчинд хүүхдийг хамгаалах хандлага эерэг боловч яг хамгаалах арга хэмжээ авах үйлдэл гаргах нь харьцангуй сул байна.



... Гудамжинд хоёр хүүхэд зодолдож байвал салгана, тоглоомын талбай дээр тоглож байгаа хүүхдэд болгоомжтой тоглоорой бэртэх вий гэж сануулдаг.

... Хүүхдүүд гарцаар гарахдаа гэрлэн дохиогоо харахгүй шууд гүйдэг бас гүйж явахдаа халтираад унадаг тэр үед нь болгоомжтой бай гэж хэлээд л өнгөрдөг. Танихгүй хүүхэд гудамжинд зогсоогоод хичээл заана гэж байхгүй.

... Хоёр жоохон хүүхэд хөтлөлцөөд явж байвал миний хоёр дүү хаашаа явж байгаа юм гээд санаа тавьдаг.

... Би өөрийнхөө охин болон тэдний ангийн манай байранд байдаг хүүхдүүдийг сургууль руу нь зөөдөг. Хүүхдүүдийг дагуулж явахдаа миний араас яваарай, гараас хөтлөөд ойрхон яваарай, грашнаас машин гарч ирж байна уу үгүй юу сайн харж яваарай, "school police"-оо сайн харж гарч болно гэсэн үед нь зам гарч байгаарай гэж хэлдэг. Танихгүй хүүхдэд битгий гүй, унах вий, гарцаараа зам гараарай гэж хэлдэг. Эрэгтэй хүүхдүүд зодолдож байвал болиорой гэж анхааруулдаг.

Насанд хүрэгчдийн фокус бүлгийн ярилцлагаас

Түүнчлэн, хүснэгт 26-д үзүүлсэн сүүлийн гурван асуулт буюу "Хүүхдээ өвлийн хүйтэнд нимгэн хувцаслан гудамжинд авч яваа хүнтэй таарвал тэр хүнд сануулж шаардлага тавих байдал", "Гудамжинд хүүхдээ зандчин, загнаж яваа хүнд хүүхэдтэйгээ буруу харьцаж байгааг нь хэлж шаардлага тавих байдал", "Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн зураг, нэрийг харуулж байгаа хэвлэлийн байгууллага, ажилтанд шаардлага тавих байдал" зэрэгт насанд хүрэгчдийн хандлага, дадал нь бусад асуултынхаас харьцангуй сул байна. Нэн ялангуяа эдгээр тохиолдолтой таарсан үедээ 10 хүн тутмын 3 нь шаардлага тавиагүй гэсэн бол цаашид ийм үйлдэлтэй таарвал 10 хүн тутмын 8 нь шаардлага тавьж, хүүхдийг хамгаалах талаар ямар нэг арга хэмжээ авна гэжээ. Эдгээр үйлдэлтэй таарсан ч хүүхдийг хамгаалах талаарх шаардлага тавихгүй гэх хандлагатай хүмүүс дотор 22 хүртэлх насны, эрэгтэй, орон сууцанд амьдардаг, дээд боловсролтой насанд хүрэгчид зонхилж байна. Харин 18-аас доош насны олон хүүхэдтэй, ямар нэг ажил эрхэлдэг оролцогчдын хувьд нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага сайтай байна (Хавсралт 24).

Насанд хүрэгчдийн хувьд үл хайхрах хүчирхийллийн талаарх мэдлэг нь бусад төрлийн хүчирхийллийн мэдлэгээс харьцангуй сул буюу 10 хүн тутмын 7 нь хангалттай мэдлэггүй байсныг өмнө танилцуулсан. Үүнтэй холбож үзвэл, насанд хүрэгчдийн үл хайхрах хүчирхийллийн талаарх мэдлэг сул байгаагаас түүнийг хүчирхийлэл гэж танихгүй байх нь нийгмийн орчинд хүүхдийг хамгаалах хандлага тааруу байгаатай холбогдож байгаа ба улмаар хүүхдийг хамгаалах ямар нэг үйлдэл хийх нь сул байна. Хамаарлын шинжилгээгээр насанд хүрэгчдийн нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага нь хэр сайн эсвэл муу байна, төдий хэмжээгээр дадал сайн эсвэл муу байх, мөн хүүхэд хамгааллын талаар хангалттай сайн мэдлэгтэй хүмүүс нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага сайтай байгаа нь тогтоогдсон (Хавсралт 25) нь дээрх дүгнэлтийг баталж байна. Түүнчлэн, ийм үйлдэлтэй таарч байгаагүй гэж хариулсан оролцогчдын хувьд тэдгээр үйлдлийг үл хайхрах хүчирхийлэл гэж таньж мэддэггүйгээс анзаардаггүй байх талтай. Мөн насанд хүрэгчдийнхээр хүүхэд хамгаалах үүрэг нь голчлон тухайн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, багш нарт ногддог тул нийгмийн орчинд хүүхэд зүй буй үйлдэлд өртөж байвал хамгаалах хандлага, дадал нь ийнхүү харьцангуй

сул байгаад нөлөөлж байж болно. Тиймээс нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах хандлага, дадлыг нэмэгдүүлэхийн тулд эхлээд тэдэнд хүчирхийлэл, нэн ялангуяа үл хайхрах хүчирхийлэл, түүний шинжүүдийг танилцуулах, уг хүчирхийллийн нөлөөгөөр хүүхдэд, эцэг эх, асран хамгаалагчдад, улмаар нийгэмд ямар сөрөг үр дагавар гарах тухай мэдээллийг насанд хүрэгчдэд өгөх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх мэдлэг, хандлага, дадал

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх нь хүүхдийг хамгаалах арга хэмжээний нэг хэсэг билээ. Тиймээс насанд хүрэгчдийн хувьд хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх, хандлага, дадал ямар байгааг энэ судалгаагаар мөн тодруулсан болно.

Насанд хүрэгчдийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэгийг шалгах бүлэг асуултуудад хүчирхийллийг мэдээлэхтэй холбоотой тэдний мэдлэгийг тодруулах зорилготой 6 асуултыг багтаасан. Үүнийг үр дүнг танилцуулъя (Хүснэгт 27).

Хүснэгт 27. Хүчирхийллийг мэдээлэхтэй холбоотой мэдлэг

#	Асуулт	Үнэн		Худал	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Багш, эмч гэх мэт мэргэжилтнүүд хүүхэд хүчирхийлэлд өртсөн байж магадгүй гэж үзвэл хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй.	1,141	95	61	5
2	Хүүхдийн эсрэг аливаа төрлийн хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдвэл мэдээлэх үүргийг бүх хүн хүлээнэ.	1,133	94	69	6
3	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг зөвхөн 108 дугаарт мэдээлэх ёстой.	706	59	496	41
4	Жирийн иргэд хүүхдийн эсрэг хүчирхийллийг шууд мэдээлэх боломжгүй заавал нийгмийн ажилтан эсвэл багшаар дамжуулна.	498	41	704	59
5	Хүүхдийн хүчирхийллийн талаар өгсөн мэдээлэл нь батлагдаагүй эсвэл буруу байвал мэдээлэл өгсөн хүн буруутан болно.	661	55	541	45
6	Хүүхдийг хүчирхийлсэн байж болзошгүй хүн өөрийнх нь тухай мэдээлсэн хүний талаар мэдээлэл авах эрхтэй.	545	45	657	55

Дээрх хүснэгтээс харвал, насанд хүрэгчдийн 59 хувь нь “хүүхдийн эсрэг хүчирхийллийг зөвхөн 108 дугаарт мэдээлэх ёстой”, 41 хувь нь “жирийн иргэд хүүхдийн хүчирхийллийг шууд мэдээлэх боломжгүй заавал нийгмийн ажилтан болон багшаар дамжуулна” гэсэн буруу ойлголттой байна. Насанд хүрэгчдийн 10 хүн тутмын 9 нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдвэл мэдээлэх үүргийг бүх хүн хүлээнэ гэж мэддэг ч 10 хүн тутмын 4-6 нь хэнд, хэрхэн хандах талаар үнэн зөв мэдлэггүй байгаа нь анхаарах ёстой асуудал мөн. Нарийвчилбал, 31-ээс дээш насны, хотын зах, гэр хороололд амьдардаг, боловсролын түвшин багатай, ажил эрхэлдэггүй, хүүхэдгүй хүмүүс бусдаас илүүтэй буруу ойлголттой байна (Хавсралт 26). Түүнчлэн, “хүчирхийллийн талаар өгсөн мэдээлэл батлагдаагүй эсвэл буруу байвал мэдээлэл өгсөн хүн буруутан болно” гэж насанд хүрэгчдийн 55 хувь, “хүчирхийлэл үйлдсэн байж болзошгүй хүн өөрийнх нь тухай мэдээлэл авах эрхтэй” гэж 45 хувь нь буруу ойлгож байгаагаас хүчирхийллийг мэдсэн ч мэдээлэхээс татгалзах нөхцөл болох магадлалтай тул үнэн зөв мэдлэг олгох арга хэмжээ авах хэрэгтэй байна.

Түүнчлэн, судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 9 нь хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана хандахаа мэднэ гэж хариулсан бол 82 насанд хүрэгч буюу 7 хувь нь мэдэхгүй гэжээ (График 19).




График 19. Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл хаана, хэнд мэдээлэх ёстойг мэдэх байдал

Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл хаана, хэнд хандах талаар мэдэхгүй гэж хариулсан насанд хүрэгчдийг боловсролын түвшнээр харвал дундаас доош боловсролтой иргэд байгаа ба дүүргийн хувьд СХД-ээс судалгаанд хамрагдсан оролцогчид бусад дүүрэгтэй харьцуулахад мэдэхгүй байгаа нь зонхилж байна (Хавсралт 27).

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх хандлага, дадлын хувьд цаашид хүүхэд хүчирхийлэлд өртөж буйг мэдвэл холбогдох газруудад болон мэргэжилтнүүдэд мэдээлэх эсэхийг насанд хүрэгчдээс тодруулахад тэдний 99 хувь нь тийм гэжээ. Харин сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг судалгаанд оролцогчдын 13 хувь нь мэдсэн бөгөөд тэдний 74 хувь нь арга хэмжээ авсан бол 26 хувь нь арга хэмжээ аваагүй гэжээ (График 20). Хүүхэд хүчирхийлэлд өртөж буйг мэдсэн даруйдаа арга хэмжээ яагаад аваагүй талаар тодруулахад хаана хандахаа мэдэхгүй байсан, бусдын асуудалд оролцохыг хүсээгүй, хүчирхийлэл мөн эсэхэд эргэлзсэн гэжээ. Иймээс насанд хүрэгчдэд хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагууд болон мэргэжилтний үүргийг ойлгуулахаас гадна хүчирхийллийг мэдээлэхгүй орхихын сөрөг үр дагавар зэргийг таниулах нь чухал байна.



График 20. Сүүлийн нэг жилд хүүхэд хүчирхийлэлд өртөж буйг мэдээд ямар нэгэн арга хэмжээ авсан байдал

Үүнээс хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх хандлага сайн байгаа ч дадал нь сул байгааг харж болно. Нэмээд, сүүлийн нэг жилд хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдээгүй гэж хариулсан 87 хувийнх нь хувьд хүчирхийллийн талаарх мэдлэг хангалтгүйгээс хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдэхгүй, анзаарахгүй өнгөрөх тохиолдол байж болохыг үгүйсгэхгүй.

Хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хэнд хандах тухай насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадлыг харьцуулан үзье (Хүснэгт 28).

Хүснэгт 28. Хүүхэд хүчирхийллийг хэнд мэдээлэх талаарх мэдлэг, хандлага, дадал (хувь)

№	Хэнд мэдээлэх	Мэдлэг	Хандлага	Дадал
1	108 дугаарт мэдээлэх	81	70	53
2	Цагдаад мэдэгдэх	62	67	35
3	Аав, ээж асран хамгаалагчдад нь хэлэх	14	14	25
4	Сургуулийн нийгмийн ажилтанд хандах	7	8	8
5	Анги удирдсан багшид мэдэгдэх	4	7	6
6	Тухайн хүүхдийн гэр бүл, хамаатан садны бусад хүнтэй ярилцах	-	4	6
7	Хорооны нийгмийн ажилтанд хандах	10	3	5
8	Бусад	1	3	4
9	Сургуулийн захиралд нь хэлэх	2	1	3
10	Хорооны засаг дарга хандах	3	1	3
11	Сургуулийн захиралд хэлэх	2	-	2

Дээрх хүснэгтээс харвал, хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана, хэнд хандахаа мэднэ гэж хариулсан оролцогчдоос хаана, хэнд мэдээлэх вэ гэж нээлттэйгээр асуухад 10 хүн тутмын 8 нь хүүхдийн тусламжийн 108 дугаарт хандана гэж хариулсан бол 10 хүн тутмын 6 нь цагдаад хандана гэжээ. Харин ирээдүйд хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл 10 хүн тутмын 7 нь хүүхдийн тусламжийн 108 дугаарт, 10 хүн тутмын 6 нь цагдаад мэдэгдэнэ гэжээ. Үүнээс хүүхдийн эсрэг хүчирхийллийг хэнд мэдээлэх талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага нь ойролцоо байна. Харин сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхэд хүчирхийлэлд өртсөнийг мэдээд, мэдээлэл өгсөн 10 хүн тутмын 5 нь хүүхдийн тусламжийн 108 дугаарт, 10 хүн тутмын 3 нь цагдаад хандсан байна. Үүнээс үзвэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг хэн нэгэнд мэдээлсэн дадал нь мэдлэг, хандлагатай харьцуулбал сул байна.

Сүүлийн нэг жилийн хугацаанд хүчирхийлэлд хүүхэд өртөж байгааг мэдсэн эсвэл сэжиглэсэн тохиолдлыг холбогдох хүмүүст мэдээлсэн 157 хүнийг нарийвчлан харвал, ажил эрхэлдэг, гэр хороололд амьдардаг хүмүүсийн хувьд бусдаас илүүтэй мэдээлэх үйлдэл хийж байна.

Түүнчлэн, хүчирхийллийг хаана, хэнд мэдээлэхээ мэддэг, мэдээлэх олон сувгууд нэрлэж чадаж байгаа хүмүүс эсрэг бүлгийнхээ хүмүүсээс 6.9 дахин илүүгээр хүчирхийллийг мэдээлэх хандлага, дадалтай байна. Мөн ам бүлийн гишүүний нэг нэгжээр нэмэгдэхэд хүчирхийллийг мэдээлэх, арга хэмжээ авдаг байдал 5.9 дахин нэмэгдэж буй нь нарийвчилсан шинжилгээгээр гарсан болно (Хавсралт 28). Харин хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдсэн ч мэдээлээгүй хүмүүсийн дунд гэрлэж, хамтран амьдарч байгаагүй, хувийн орлого өндөртэй насанд хүрэгчид зонхилж байна (Хавсралт 29).



... Манай хажуу талын хөрш айл нэг удаа зодолдоод хүүхэд нь уйлаад байсан. Би тандаж зогсож байгаад хаалганы цаанаас нь сонсоод үзэхэд хүүхэд нь үгэнд нь орохгүй байгаа учраас цохисон гэж ойлгоод орхисон. Гудамж талбайд танихгүй хүн хүүхдийг илт хүчирхийлээд байвал очиж хэлнэ. Гэхдээ цааш нь мэдээлэхгүй.

... Хүчирхийлэл ямар орчинд үйлдэгдэж байгаагаас хамаарна. Ил байгаа тохиолдолд өөрөө очиж “та ингэж болохгүй, хүүхэд таны гарын аяыг даахгүй” гэж хэлнэ. Хэрвээ эсэргүүцвэл цагдаа дуудна, хүүхдийн 108 утас руу залгана.

... Биед халдаж байгаа халдлагыг бол мэдээлнэ. Түүнээс чанга дуугараад хашхираад байгааг мэдээлэхгүй. Хуулиараа гэмт хэрэг гэж үзэхгүй.

Насанд хүрэгчдийн фокус бүлгийн ярилцлагаас

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхэд тулгарч буй саад бэрхшээл

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхэд тулгарч болох бэрхшээлүүдийг насанд хүрэгчдээс мөн тандсан болно. Ингэхэд, тэдний дунд “бусдын хувийн асуудалд оролцох нь буруу” гэсэн хандлага түгээмэл байна (Хүснэгт 29).

Хүснэгт 29. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхэд тулгарч буй саад бэрхшээл (хувь)

Саад бэрхшээл	Маш их	Зарим талаар	Бага зэрэг	Саад байхгүй
Бусдын хувийн асуудалд оролцох нь буруу гэсэн бодол	11	28	28	33
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдээлбэл тухайн хүүхдэд улам муу юм болох вий гэсэн айдас	12	21	31	35
Мэдээлбэл цагдаагаар явах гэх мэт бөөн чирэгдэл болох байх гэсэн болгоомжлол	12	16	23	50
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл биш байвал яана гэсэн болгоомжлол	6	17	27	50
Хүүхдийг хүчирхийлсэн хүн намайг мэдээлэл өгсөн гэдгийг мэдчих вий гэсэн айдас	7	11	16	66
Мэдээлэх зав гарахгүй байдал	3	10	17	70

Түүнчлэн, “хүүхдийн хүчирхийллийн талаар мэдээлбэл тухайн хүүхдэд улам муу зүйл болох вий гэсэн айдас”, “мэдээлбэл цагдаагаар явах гэх мэт бөөн чирэгдэл болох байх гэсэн болгоомжлол”, “хүүхдийн эсрэг хүчирхийлэл биш байвал яана гэсэн болгоомжлол” судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын 5-6-д нь байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх мэдлэгийн талаарх асуултуудаас үзэхэд, “хүчирхийллийн талаар өгсөн мэдээлэл батлагдаагүй эсвэл буруу байвал мэдээлэл өгсөн хүн буруутан болно” гэж насанд хүрэгчдийн 55 хувь нь буруу ойлгож байгааг өмнө танилцуулсан. Үүнээс насанд хүрэгчдийн хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхтэй холбоотой мэдлэг хангалтгүй байх нь хүчирхийллийг мэдээлэхэд саад болж байгааг харж болно.

Насанд хүрэгчид болон мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын үр дүн дээр дурдсан тоон мэдээллийг бататгаж байна (Зураг 10).

НАСАНД ХҮРЭГЧДИЙН ЯРИЛЦЛАГААС	МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЯРИЛЦЛАГААС
<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн буруу байж магадгүй гэх бодол бий. - Бие махбодын л хүчирхийлэл үйлдээгүй, хүүхдээ загнаж байвал нотлох баримт байхгүй, холбогдох байгууллага үнэн зөвийг тогтоон шийдвэр гаргахад хүндрэлтэй. - Мэдээлсэн хүн рүү олон удаа залгах, мэдүүлэг авах зэргээс төвөгшөөдөг. - Томчуудад буруу гэдгийг нь хэлэхээр уурлаад хүүхдээ улам шийтгээд байгаа мэдрэмж төрүүлдэг. - Хүүхдийн тусламжийн 108 дугаарт итгэдэггүй. Дуудлага өгдөг боловч арга хэмжээ аваагүй байдаг. - Мэдээлэл өгсөн хүний хувийн мэдээллийг нууцалдаггүй. 	<ul style="list-style-type: none"> - Иргэд иргэний үүргээ биелүүлж хүчирхийллийг мэдээллээ гэхэд мэдээлсэн хүнийг мэдүүлэг авах гэж олон цаг болно, удаа дараа ирж мэдүүлэг өг гэж дуудна. - Гэрчээс мэдүүлэг авахын тулд байн байн холбогдоно, цагдаагийн байгууллагад дуудагдана гэдэг айдас байдаг. - Хоорондоо учраа олог гээд орхидог хандлага түгээмэл. - Зарим тохиолдолд ажил мэргэжлээсээ шалтгаан мэдээлэл өгөхгүй байх тохиолдол ажиглагддаг.

Зураг 10. Хүчирхийллийг мэдээлэхэд гарах саад бэрхшээл

Үүнээс үзэхэд, хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхэд учирч болзошгүй саад бэрхшээлүүд нь бодит байдалд гардаг эсэхийг нарийвчлан тодруулах, хэрэв байгаа түүнийг арилгах, улмаар ийм саад бэрхшээлүүд байхгүй бол насанд хүрэгчдийн ташаа ойлголтыг залруулах талаар ажиллах нь чухал байна.



Насанд хүрэгчид хүүхдийн хүчирхийллийн талаар мэдээлэх дадал сул байгаа нь хэрвээ би хүчирхийллийн талаар дуудлага өгөөд мэдэгдвэл надад төвөг болно, гай болно, мэдүүлэг өгөхөөс авахуулаад төвөгшөөнө. Манай улсын тогтолцоо хохирогчид ээлтэй бус, мэдүүлэг авах гэж олон цаг суулгана, хохирогчийг хэд хэдэн удаа дуудна, ялангуяа хүчирхийллийн тохиолдолд шалгаж тогтоох гэж олон удаа дуудаж мэдүүлэг авдаг гэх мэт асуудлууд байна. Хохирогч мэдүүлгээ өгсөн ч гэсэн төвөг болж олон удаа дуудагддаг, ажлаасаа хоцордог чөлөө авдаг. Мөн гэрч болж байгаа хүн мэдээлэл өглөө гэхэд гэрчээс асуух зүйл гарвал мэдээлэл авахын түлд ажлын байран дээр нь очих зэрэг мэдрэмжгүй үйлдлүүд гардаг. Цагдаагийн байгууллага мэдүүлэг авах гээд дуудлаа гэхэд завгүй хүмүүс төвөгшөөдөг. Та мэдээлэх үүргээ гүйцэтгэх ёстой гэж дарамт, шахалт үзүүлдэг.

Хохирогч мэдүүлэг өгөх гэж ажлаа тасална, чөлөө авна, хүүхдийн сургууль цэцэрлэг тасарна гэх мэтээр бид хохирогчоо нэмээд хохируулдаг. Хохирогчдоо аваад хамгаалах байранд оруулдаг үүнээс болоод хохирогчоо улам хохироодог. Энэ асуудлыг шийдэх цаад тогтолцоо нь буруу байна. Хүмүүс хүчирхийллийг мэдүүлэхгүй байгаа нь төвөгшөөдөг, дараагийн удаа мэдүүлэхгүй хэрвээ мэдэгдвэл хамгаалах байр луу ороод олон хоног сургууль, ажлаа алдаж өөрөө хохирол амсдаг.

Ерөнхийдөө хүмүүс хүчирхийллийг мэдээлэх үүргээ сайн биелүүлэхгүй байгаа. Тийм учраас хүүхэд эндэх, бэртэх тохиолдол гараад байна. Мэдсэн ч гэсэн төвөгшөөдөг, адгийн зарга 13 хоног гэгчээр мэдээллээ гэхэд мэдүүлэг өгөхөөс төвөгшөөдөг. Иргэд мэдээлэх ёстой гэдгээ сайн мэддэг хэр нь төвөгшөөдөг, намайг цагдаа шүүхээс дуудна гээд хэлдэггүй байх. Мэдээлэх байдлыг сайжруулахын түлд шүүх цагдаа дээр олон удаа явж очдоггүй болгосоор байна. Нэг удаа мэдээлэл өгсөн, тухайн нөхцөл байдлыг хэлсэн л бол тэр хүнийг дахин дуудахгүй байх. Нэг л удаа хэлдэг, очиж мэдүүлэг өгөх шаардлагагүй, ажилд нь саад болохгүйгээр дахин дахин нааш цааш нь дуудаж явуулахгүй байх хэрэгтэй.

Мэдээлэхгүй байхад ажил мэргэжил нөлөөлдөг. Сургуульд насаараа ажилласан, хуулийн байгууллагад насаараа ажилласан, эрүүл мэндийн байгууллагад насаараа ажилласан хүмүүс мэдээлэл сайтай, мэдээлэл сайн өгдөг.

Мэргэжилтэнтэй ярилцсан ганцаарчилсан ярилцлагаас

Өөрийгөө хамгаалах талаар хүүхдэдээ өгдөг мэдээлэл

Өмнөх судалгаанууд (ХЭҮК, Гүүд Нейборс, 2014; Хүүхдийг Ивээх Сан, 2021)-аас харахад, хүүхдүүдийн хувьд хүүхэд хамгааллын талаар мэдээлэл авдаг гол эх сурвалж нь тэдний эцэг эх, асран хамгаалагч талаар дурдсан байдаг. Иймээс энэ судалгаагаар эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ чухам ямар мэдээлэл зөвлөгөө өгдөг, тэр мэдээлэл зөвлөгөө нь үнэн зөв эсэх, хүүхдэдээ өгч буй мэдээллээ хаанаас авдгийг тодруулах шаардлагатай гэж үзсэн.

Насанд хүрэгчид, тодруулбал эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ өөрийгөө хамгаалах талаар ямар мэдээлэл өгдгийг нээлттэй асуухад дараах хариултуудыг өгсөн (Хүснэгт 30).

Хүснэгт 30. Хүүхдэдээ өөрийгөө хамгаалах талаар өгдөг насанд хүрэгчдийн мэдээлэл зөвлөгөө

Хариултууд	Тоо	Хувь	Насанд хүрэгчдийн хүйс (хувь)			
			Эрэгтэй		Эмэгтэй	
			Хүүхдийн хүйс		Хүүхдийн хүйс	
			Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Танихгүй хүнтэй ярихгүй байх	275	23	17	19	29	33
Анхаарал болгоомжтой байх	158	13	18	18	13	11
Ямар ч асуудал тулгарсан аав, ээждээ хэлэх	155	13	10	10	15	15
Хүмүүстэй эвтэй найртай байх	130	11	11	10	11	8
Ямар ч зүйл тохиолдсон өөрийгөө хамгаалаад гарах	101	8	9	9	8	7
Замын хөдөлгөөний дүрмийг баримтлах, гарцаар зам хөндлөн гарах	63	5	8	7	4	5
Шөнө оройгоор гадуур явахгүй байх	56	5	7	6	2	5
Цахим орчинд болгоомжтой байх	41	3	1	2	5	5
Ямар нэгэн юм болбол шууд залгах	35	3	4	4	2	4
Найз нөхдийн хүрээллээ зөв сонгох	30	2	3	2	3	3
Хаалгаа танихгүй хүнд тайлж өгөхгүй байх	24	2	1	1	3	5
Ямар нэгэн юм болбол зугтах	22	2	2	1	2	1
108 утсанд мэдээлэл өгөх	21	2	3	1	1	0
Том хүнд мэдэгдэх	20	2	2	2	2	2
Ээжээс нь өөр хүн биед нь хүрэхгүйг хэлэх	16	1	1	1	2	3
Хүүхдийн эрхийг мэддэг байх	16	1	2	2	0	1
Цагдаад хандах	12	1	1	2	1	0
Мэдэхгүй	155	13	15	14	8	7

Дээрх хүснэгтээс харахад, судалгаанд оролцогчдын 23 хувь нь “танихгүй хүнтэй ярьж болохгүй” гэж хүүхдэдээ зөвлөдөг байна. Энэ нь нэг талаар хүүхдэд хэрэгтэй мэдээлэл зөвлөгөө байж болох ч нөгөө талаар хүүхэд хүчирхийлэл, зүй бус үйлдэлд өртөх болон өртсөн үед бусад хүнээс тусламж хүсэхгүй байх эрсдэл үүсгэж болзошгүй. Түүнчлэн, эрэгтэйчүүд хүүхдүүдэдээ анхаарал болгоомжтой байх, ямар ч зүйл тохиолдсон өөрийгөө хамгаалаад гардаг байх, шөнө оройн цагаар гадуур явахгүй байх зэргийг зөвлөдөг бол эмэгтэйчүүд хүүхдүүдэд танихгүй хүнтэй ярихгүй байх, ямар ч асуудал тулгарсан аав, ээждээ хэлэхийг анхааруулдаг байна. Хүснэгтэд үзүүлсэн мэдээллээс харахад, эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ өөрийгөө хэрхэн хамгаалах талаар өгч буй мэдээллийн зарим нь хэт ерөнхий (цахим орчинд өөрийгөө хамгаалах, анхаарал болгоомжтой байх), эсвэл өөрийгөө хамгаалах асуудлыг хүүхдэд өөрт нь даатгасан (ямар ч зүйл тохиолдсон өөрийгөө хамгаалаад гарах) байх талтай байна. Үүнээс хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогт тохируулан нарийвчилсан мэдээллийг өгөх талаас нь эцэг эх, асран хамгаалагчдад сануулах хэрэгтэй нь харагдаж байна.

Түүнчлэн, дээрх хүснэгтээс үзвэл, хүүхдэдээ өөрийгөө хамгаалах талаар ямар мэдээлэл өгөх ёстойг мэдэхгүй гэж 155 насанд хүрэгч хариулсан ба үүний 85 өрхөд 18-аас доош насны хүүхэд амьдардаг оролцогчид байгаа бол 99 нь эрэгтэйчүүд байна. Энэ нь жендэрийн хэвшмэл үүргээс хамааран эрэгтэйчүүд хүүхдийн хүмүүжил, хамгааллын асуудалд төдийлөн идэвхтэй оролцдоггүйгээс тэдэнд мэдье гэсэн хэрэгцээ үүсдэггүйтэй холбоотой байж болно. Мөн өмнө дурдсанаар “ямар ч зүйл тохиолдсон өөрийгөө хамгаалаад гарах” гэсэн зөвлөгөөг эрэгтэй асран хамгаалагчид хүүхдэдээ өгдгөөс харахад тэд хүүхдэдээ өөрийгөө хамгаалах талаар өгөх мэдээлэлгүй нь харагдаж байна.

Судалгааны хүрээнд бид хүүхэд хамгааллын анхан болон дунд шатанд ажиллаж байгаа нийгмийн ажилтан болон бусад мэргэжилтнээс хүүхдэдээ ямар мэдээлэл өгөөсэй гэж эцэг эх, асран хамгаалагчдаас хүсдэг вэ гэж асуусан (Зураг 11).



Зураг 11. Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдийнхээр хүүхдэд өгөх ёстой мэдээлэл зөвлөгөө

Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ өгдөг мэдээлэл, мэргэжилтнүүдийн зүгээс эцэг эх, асран хамгаалагчдыг хүүхдэдээ өгөөсэй гэж хүсдэг мэдээллийн хооронд зарим ялгаа байгаа нь харагдаж байна (Хүснэгт 30, Зураг 11-ийг тус тус үзнэ үү). Тодруулбал, бусдыг ялгаварлахгүй байх, үе тэнгийнхнээ дээрэлхэхгүй байх, бусдыг хүндэлж хайрлах тухай мэдээлэл зөвлөгөөг хүүхдэдээ өгөх ёстой гэж мэргэжилтнүүд үзэж байхад эцэг эх, асран хамгаалагчдын хувьд эдгээр мэдээллийг хүүхдэдээ өгдөггүй байх талтай байна. Харин өмнө дурдсанчлан, насанд хүрэгчдийн хувьд үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийг тулгамдсан асуудлын тоонд оруулснаас гадна хүүхэдтэй зүй бус харьцаж байгаа хүмүүс нь эцэг эх, асран хамгаалагчаас гадна үе тэнгийнхэн нь байдаг гэж үзсэн. Хэдий насанд хүрэгчдийн хувьд үүнийг анхаарах ёстой асуудал гэж үзэж буй ч ялгаварлан гадуурхалт, үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийн талаар хангалттай мэдлэггүй учраас хүүхдэдээ энэ талын мэдээлэл өгдөггүй байж болно. Урьдчилсан фокус бүлгийн ярилцлагын үеэр үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийн асуудал тулгардаг талаар хүүхдүүд мэдээлсэн, гэвч хүүхдүүдийн мэдээллийн гол эх сурвалж болсон эцэг эх, асран хамгаалагч нь энэ талаар мэдээлэл өгдөггүй нь анхаарал татаж байна. Иймд эцэг эхчүүдэд энэ талын мэдээлэл өгөх чиглэлээр ажиллах хэрэгтэй.

Түүнчлэн, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ өгдөг хүүхэд хамгааллын мэдээллээ хаанаас авдаг талаар тодруулахад, 10 хүн тутмын 5-6 нь фейсбүүк болон телевизийг нэрлэжээ (Хүснэгт 31).

Хүснэгт 31. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах талаарх мэдээлэл авдаг сувгууд

Мэдээлэл авдаг сувгууд	Тоо	Хувь	Насны бүлэг (хувь)					
			18-22	23-30	31-40	41-50	51-60	61+
Фейсбүүк	773	64	76	73	74	55	50	35
Телевиз	651	54	36	43	54	57	72	69
Юутүб	234	19	26	33	22	13	7	7
Инстаграм	201	17	27	28	19	11	5	4
Багш	87	7	11	9	6	7	7	1
Цагдаагаас	77	6	10	9	6	7	3	5
Гэр бүлийн бусад гишүүдээсээ	61	5	12	9	4	3	3	1
Хүүхэд тусламжийн 108 утас	48	4	4	5	4	3	1	4
Хүүхдийн байгууллага	46	4	5	6	4	3	4	0
Баг/хорооны нийгмийн ажилтан	45	4	1	2	5	4	4	3
Найз нөхдөөсөө	43	4	5	5	3	4	2	1
Брошюр, танилцуулга, нугалбар	37	3	1	3	2	2	4	9
Ном, сонин, сэтгүүл	28	2	5	3	1	1	4	3
Ажлын хамт олноос	26	2	1	2	3	2	3	0
Эхнэрээсээ, нөхрөөсөө	25	2	3	2	2	3	1	0
Хүүхдийн төлөө ажилладаг ТББ	24	2	4	2	2	2	1	2
Олны танил хүмүүсээс	19	2	2	2	1	1	3	1
Ам дамжсан яриа	16	1	1	2	1	2	0	4
Хүүхдүүдээсээ	15	1	1	1	1	2	2	0
Хуулиас	15	1	3	0	1	2	3	0
Гүүгл	14	1	5	1	2	0	0	0
Цэцэрлэгийн эрхлэгч	12	1	1	1	1	1	1	0
Сургалт	12	1	2	2	0	1	1	0
Хамтарсан баг	8	1	1	0	1	2	1	0
Мэдээлэл авдаггүй	60	5	1	5	4	5	6	9

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр харьцуулан харвал, нас залуужих тусам фейсбүүк, юутүб, инстаграмаас мэдээлэл авч байгаа бол насны бүлэг ахих тусам телевиз, брошюр, танилцуулга, ам дамжсан яриа зэрэг уламжлалт мэдээллийн эх сурвалжаас авдаг ажээ. Тэгэхээр хүүхэд хамгааллын талаар олон нийтэд мэдээлэл түгээхдээ дээрх сурвалжуудыг анхаарч үзэх нь хэрэгтэй байж болно. Гэвч эцэг эх, асран хамгаалагчдын мэдээлэл авч буй фейсбүүк, юутүб, инстаграм нь мэргэжлийн байгууллагынх эсэх нь мэдэгдэхгүй байна. Фейсбүүк зэрэг социал медиад буруу, ташаа мэдээлэл байх талтай тул яг ямар байгууллагын социал медиа хаягаас үнэн зөв мэдээлэл авах талаар насанд хүрэгчдэд мөн ойлгуулах шаардлагатай. Мөн хүүхдийг хамгаалах тухай мэдээлэл авч байгаагүй гэж судалгаанд оролцогчдын 5 хувь нь хариулсныг анхаарахад илүүдэхгүй.

> ХҮҮХЭД ХАМГААЛАЛД НАСАНД ХҮРЭГЧДИЙН ОРОЛЦОО

Хүүхдийг хамгаалахад хүн бүрийн үүрэг оролцоо хэрэгтэй. Энэ судалгаанд зорилт болгож оруулаагүй ч хүүхэд хамгаалалд насанд хүрэгчдийн оролцоо ямар байгаа, цаашид оролцоог нь хэрхэн сайжруулах талаар холбогдох талуудын саналыг сонсож, дүгнэлт гаргах шаардлагатай.

Хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага болон насан хүрэгчидтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагын мэдээлэлд тулгуурлан насанд хүрэгчид хүүхэд хамгаалах ажилд хэрхэн оролцох шаардлагатай тухай, энэ чиглэлд тулгамдаж буй асуудлууд, цаашид хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээ зэргийг тодруулахыг зорилоо.

Мэргэжилтнүүдээс хүүхэд хамгаалалд насанд хүрэгчдийн оролцоо гэдгийг хэрхэн ойлгож буйг тодруулахад, насанд хүрэгчид хүүхдийн эсрэг хүчирхийлэлд дуу хоолойгоо илэрхийлдэг байх, үүнийг цаг алдалгүй мэдээлэх үүргээ биелүүлдэг байх, хүүхэд хамгааллын мэдлэгээ нэмэгдүүлж зөв арга хэмжээ авдаг байх нь чухал гэж үзэж байна.



... Насанд хүрэгчид хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлийн талаарх мэдээ мэдээллийг цагдаагийн байгууллага болон холбогдох байгууллагуудад шуурхай хүргэх нь чухал. Сүүлийн үед хүмүүсийн мэдээлэл өгөх хандлага бүүрсан. Үүний шалтгаан нь аливаа зөрчлийг мэдээлсэн тохиолдолд хувийн мэдээлэл задрах, цагдаагийн байгууллагад очиж мэдүүлэг өгөх зэргээс болгоомжилдог байдал нь иргэдийн дуудлага өгөх хандлагыг бүүруулж байна. Дуудлага өгч байгаа хүмүүс миний мэдээллийг нууцлаарай гээд хүчирхийлэл үйлдэгч хүнээс айсан, болгоомжилсон байдалтай залгадаг.

Хэсгийн байцаагчтай хийсэн ярилцлагаас

Түүнчлэн, ярилцлагад оролцогчдын санал болгосноор, хүүхэд хамгаалахад насанд хүрэгчид идэвхтэй оролцох, эргэн тойронд хүүхдэд халтай зүйл байвал холбогдох байгууллагуудад мэдээлж, арга хэмжээ авхуулах, СӨХ, хороо гэх мэт байгууллагатай нягт хамтран ажиллах ёстой талаар саналууд хэлсэн (Зураг 12).



ГЭР ХОРООЛЛЫН ИРГЭД

- Хөршийн холбоог сайжруулах;
- Дуудлага мэдээллийг цаг алдалгүй мэдээлэх хандлагыг нэмэгдүүлэх;
- Гудам гудмаараа хамтраад хүүхэд хамгаалалд оролцох, санаачилга гаргах, бусдыгаа уриалах;
- Тухайн гудмын худаг, дэлгүүр, хөршүүд хүүхэд хамгаалахад илүү үүрэг оролцоотой байх;
- Төрөөс гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах (харанхуй гудамд гэрэлтүүлэг тавих, зам, замын тэмдэг тэмдэглэгээ, камертай болох);
- Иргэд, олон нийт гудмаар алхахдаа хүүхдэд аюул учирч болзошгүй зүйлсийг анзаарч анхааралдаа авах (траншейн таггүй, цахилгааны утас ил гарсан, хүүхэд унаж бэртэх нүх байвал холбогдох газар нь мэдээлж аюулгүй болгоход анхаарах);
- Хороо, дүүргээс зохион байгуулсан арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцох



ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН ИРГЭД

- Хөршийн холбоог сайжруулах;
- Байр хороолол нь гэр хороололтой харьцуулахад харьцангуй дуу чимээтэй, дээд, доод айлын хүүхэд уйлахад сонсогддог тул цаг алдалгүй мэдээлдэг байх;
- СӨХ оршин суугчдын аюулгүй байдалд анхаарч ажиллах, стандартаа дагаж мөрдөх (хүүхдийн тоглоомын талбайд анхаарал хандуулах, хүүхэд тоглоход аюулгүй эсэхийг байнга шалгаж, сайжруулах);
- СӨХ хариуцсан дарга, ажилчдад хүүхэд хамгааллын сургалт явуулж, айл өрхүүдэд мэдээлэл түгээдэг болгох;
- Цахилгаан, усны төлбөрийг айлын хаалга дээр наадагтай адилаар хүүхэд хамгааллын мэдээллийг түгээх;
- Дэд бүтцийг сайжруулах (хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэх, чанаржуулах, камер нэмж суурилуулах гэх мэт);
- Иргэд, олон нийт хүүхдэд аюул учирч болзошгүй зүйлийг анзаарч, холбогдох газар нь мэдээлэн аюулгүй болгоход анхаардаг болгох;
- Хороо, дүүргээс зохион байгуулсан арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцох.

Зураг 12. Насанд хүрэгчид хүүхдийг хамгаалахад хэрхэн оролцож болох тухай тэдний өөрсдийнх нь санаа

Дээр дурдсан арга хэмжээнээс гадна дараах арга хэмжээг зохион байгуулах нь хүүхэд хамгааллыг сайжруулахад чухал нөлөөтэйг мэргэжилтнүүд онцолсон болно:

- Хүүхэд хамгааллын талаар богино хэмжээний контент бэлтгэж, социал медиа сувгуудаар олон нийтэд түгээх;
- Хүүхэд хамгааллын талаарх мэдээ, мэдээлэл түгээх тусгай телевизтэй болох;
- Хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, надгүйгээр болно гэсэн хандлагыг багасгахад чиглэсэн нөлөөллийн ажлууд зохион байгуулах;
- Зорилтот бүлэг рүү чиглэсэн сургалтуудыг давтамжтай зохион байгуулах;
- Хүүхэд хамгааллын аянуудыг ойрхон давтамжтай зохион байгуулах.

Хүүхэд хамгаалалд аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоо

Хүүхэд хамгаалалд насанд хүрэгчдээс гадна гадна аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг оролцоо тун чухал. Тийм учраас судалгааны хүрээг ялимгүй тэлж, аж ахуйн нэгж, байгууллагууд хүүхэд хамгаалах чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулж, хувь нэмрээ оруулж болох талаар хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдийн саналыг сонссон юм. Гэхдээ энэ асуудлыг бид гүехэн авч үзсэн, тиймээс үүнийг цааш нь гүнзгийрүүлэн судалбал зохилтойг энд тэмдэглэе.



... 2018 оноос эхлэн байгууллага бүр эцэг эхийн зөвлөлтэй байх шаардлагын дагуу байгууллагууд эцэг эхийн зөвлөлтэй болсон. Үүний хүрээнд хэрэгжсэн сайн туршлагаас дүрдвал ГХЯ хүүхэд хамгааллын орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд хүүхдийн өрөөтэй болсон. Яамнаас үлгэрлээд бүх төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд хүүхэд хамгааллын бодлоготой болчихсон. Эцэг эхийн зөвлөлтэй болчихсон. Эцэг эхийн зөвлөлөөрөө дамжуулаад ажилтан, албан хаагчдынхаа хүүхдүүд рүү анхаарал хандуулж тодорхой хөгжлийн үйлчилгээнүүдийг үзүүлдэг болсон. Жишээлбэл, хувийн хэвшлээс “Говь” ХХК хажуудаа цэцэрлэгтэй болсон. Энэ бол хүүхэд хамгаалалд хувь нэмрээ оруулсан ажил болсон. Энэхүү цэцэрлэгийг байгуулснаар ажилтнууд амар тайван ажлаа хийх боломжийг бүрдүүлж өгсөн ба хүүхэд үл хайхрах хүчирхийлэлд өртөхгүй байх шийдэл болсон. Өрхийн эдийн засаг сайжрах, хүүхэд сурч боловсрох, сургууль завсардахгүй байх гэх мэт олон сайн талтай юм. Тиймээс хүүхэд хамгаалалд албан байгууллагуудыг оролцоог сайжруулах нь чухал.

Мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас

Хүүхдийг хамгаалахад албан байгууллагууд хэрхэн оролцож болох тухай зарим саналыг мэргэжилтнүүд дурдсаныг цаашид харгалзан үзвэл зохино.

- Байгууллагууд өөрсдийн ажилтнуудадаа хүүхэд хамгааллын талаарх сургалтууд зохион байгуулах. Нэг удаа сургалт ороод орхих нь үр дүнгүй тул сургалтуудыг давтамжтай зохион байгуулах нь чухал. Мэргэжлийн байгууллагууд, хороод олон нийтэд хүүхэд хамгааллын талаарх мэдээ, мэдээлэл түгээх олон арга хэмжээ зохион байгуулдаг ч ирж оролцдог хүн цөөн байдаг тул байгууллагыг түшиглэн аливаа сургалтыг зохион байгуулах нь хүртээмжтэй.
- Аж ахуйн нэгж, байгууллагууд хүүхэд хамгааллын бодлоготой болох. Хүүхэд хамгааллын хүрээнд хүүхдэд ээлтэй орчинтой болох, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хажуудаа цэцэрлэгтэй болох гэх мэт ажлыг зохион байгуулж болох юм. Мөн төрөөс хүүхэд хамгааллын хүрээнд идэвхтэй, санаачилгатай үйл ажиллагаа зохион байгуулж байгууллагуудыг татвараас хөнгөлөх зэргээр урамшуулж хамтын ажиллагааг дээшлүүлбэл үр өгөөжтэй.
- Бүх байгууллага эцэг, эхийн зөвлөл байгуулж хүүхэд хамгаалахад хамтарч ажиллах. Байгууллагын эцэг, эхийн зөвлөл сар тутам тухайн байгууллагынхаа ажилтнуудад зориулсан арга хэмжээ зохион байгуулах. Ялангуяа хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн шинжтэй аргууд ашиглахгүй байх, хүүхдийн эрх, хүүхдийн насны онцлогт тохирсон хүмүүжлийн арга хэрэглэх зэрэг нөлөөллийн ажлуудыг хийх.
- Байгууллагууд өөрсдийн пэйж хуудсаар дамжуулан хүүхэд хамгааллын талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Насанд хүрэгчдийн хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлагыг илрүүлэх; хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг илрүүлэх; хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодруулах гэсэн зорилтын хүрээнд энэхүү судалгааг тоон болон чанарын аргыг хослуулан хийж, судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлт, санал зөвлөмжийг танилцуулж байна.

Насанд хүрэгчдийн хүүхэд хүмүүжлийн талаарх хандлага:

- Насанд хүрэгчдийн дунд хүүхдээс зохисгүй зүйл хүлээх, тухайлбал “хүүхдийг дуулгавартай, эцэг эхийнхээ үгийг дагадаг болгож хүмүүжүүлэх хэрэгтэй”, “одоогийн хүүхдүүд бүх юм нь бэлэн, жаргалтай өсөж байна” гэсэн хандлага түгээмэл байна. Үүнээс болж хүүхэд эцэг эх, асран хамгаалагчидтайгаа ярилцах хүсэлгүй болох, асуудал тохиолдвол хэлэхгүй нуух гэх мэт сөрөг үр дагавар гарч болзошгүй. Улмаар энэ нь хүүхэд хүчирхийлэлд өртөх, түүнийгээ хэлэхгүй дахин дахин хүчирхийлэлд өртөх эрсдэлийг дагуулах магадлалтай. Тийм учраас эцэг эхчүүд, насанд хүрэгчдэд хүүхэдтэйгээ ярилцахгүй байхын сөрөг үр дагаврыг таниулах, хүүхэдтэйгээ хэрхэн яаж ярилцах аргачилсан зөвлөмж өгөх чиглэлээр ажиллах хэрэгтэй байна. Түүнчлэн, насанд хүрэгчдийн хувьд хүүхэдтэйгээ ярилцдаггүйгээс хүүхдийнхээ хэрэгцээ, сонирхол, асуудлыг мэддэггүй, ойлгодоггүй, өөрийнхөө төрж өссөн цаг үе, орчноороо баримжаалан хүүхдийнхээ хэрэгцээ, сонирхол, асуудлыг хүүхдийнхээ өмнөөс төсөөлөн боддог, тэрхүү төсөөллөөрөө хүүхдэдээ хандах нь түгээмэл байна. Тиймээс хүүхэдтэйгээ харилцах, хүүхдээ хүмүүжүүлэх, хүүхдээсээ хүлээж буй аливаа зүйл нь насанд хүрэгчдийн өөрсдийн төрж өссөн биш одоо байгаа энэ цаг үеийн онцлог, нөхцөл байдлаас хамаарах ёстойг ойлгуулахад чиглэсэн мессэжийг хүмүүст хүргэх талаас нь анхаарах хэрэгтэй.
- Насанд хүрэгчид хүүхдийн оронд өөрийгөө тавьж ойлгохгүй байх нь хүүхдээс зохисгүй, хэт их зүйл хүлээх хандлагыг бий болгож, улмаар хүүхдэд өөрсдийн үүргийг шилжүүлэх хандлагыг өөгшүүлж байна. Тэгэхээр насанд хүрэгчдийн хувьд хүүхдэд ямар үүргийг хэр хэмжээгээр шилжүүлж байгаагаа ухамсартайгаар бодож эргэцүүлэх, хүүхэдтэй ярилцаж, тэдэнд ямар байгааг нь асууж мэдэх, асуудал байвал шийдэх талаас нь анхаарах хэрэгтэй. Үүний тулд хүүхэдтэй хэрхэн ярилцах, харилцах аргууд бүхий алхамчилсан заавар зөвлөгөө бүхий мэдээллийг аудио, видео болон бичгэн хэлбэрээр бэлтгэн насанд хүрэгчдийн өргөн хэрэглэдэг мэдээллийн сувгуудаар түгээвэл зохистой.
- Насанд хүрэгчид хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, бие даасан байдлыг хүлээн зөвшөөрч, дэмжих эерэг хандлагатай байгаа нь сайшаалтай хэдий ч “давларлаа, илүү үгтэй, тайлбар тавилаа” гэх байдлаар хүүхдээ сонсохгүй, тэдэнтэй ярилцахгүй байх хандлагыг илэрхийлж байна. Энэ нь дээрх дүгнэлтүүдийг бататгаж байгаа бөгөөд насанд хүрэгчдэд хүүхдээ яагаад сонсох ёстой, яагаад тэдэнтэй ярилцах ёстой, яаж ярилцах талаарх аргачилсан зөвлөгөө, заавар, удирдамж хэрэгтэйг дахин харуулж байна. Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)”-ийн 2.2.3-д “хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлж, бодлого төлөвлөх,

хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог нэмэгдүүлнэ” гэсэн зорилтыг тавьсан бол уг зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “хүүхдэд нөлөөлөх аливаа асуудлыг шийдвэрлэх явцад тэдний үзэл бодлыг харгалзан үзэх, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгох хандлагыг эцэг эх, асран хамгаалагч болон багш, нийгмийн ажилтанд төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах” зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Уг хөтөлбөрийн, түүний дотор 2.2.3-д заасан зорилтын хэрэгжилтэд үнэлгээ хийж, түүнд тулгуурлан цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай.

- “Эрэгтэй хүүхэд уйлах нь сул доройн шинж” гэх хандлагыг судалгаанд оролцогчид нийтээрээ хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх чиглэлээр сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн ажлын үр дүн гарч байна гэж үзэж болохоор байна. Иймд энэ чиглэлд хэрэгжүүлсэн ажлын сайн туршлагыг хүүхдийн хүмүүжлийн талаарх хэвшмэл буруу ойлголтыг залруулахад ашиглах нь зүйтэй.

Хүүхэд эсрэг хүчирхийллийн талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадал:

- Хүүхдийн хүмүүжлийн талаарх хандлага, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх болон хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал нь харилцан уялдаатай болохыг олон улсад хийгдсэн судалгааны үр дүн харуулж байгаа бөгөөд энэ удаагийн судалгаа ч мөн үүнийг нотолсон. Тиймээс хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх хүүхэд хамгааллын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ дээрх гурван ухагдахууны хүрээнд цогц байдлаар авч үзэх шаардлагатай. Хүүхэд хүмүүжлийн талаар хэвшмэл буруу ойлголт, хандлагатай байх нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, нийгмийн орчинд бусдын хүүхдийг хамгаалах талаар сөрөг хандлагатай байхад нөлөөлж байна.
- Насанд хүрэгчид сэтгэл санааны, бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн талаарх хангалттай мэдлэгтэй байгаа хэдий ч үл хайхрах хүчирхийллийн талаарх тэдний мэдлэг хангалтгүй байгааг судалгааны үр дүн харууллаа. Үл хайхрах хүчирхийлэл нь сэтгэл санааны хүчирхийллийг дагуулж, улмаар бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл буюу илүү ноцтой хүчирхийлэл үйлдэгдэх эрсдэлийг үүсгэх магадлалтай. Иймд үл хайхрах хүчирхийллийн нөхцөл байдал, төрөл хэлбэр, түүнээс үүдэн гарах сөрөг үр дагавар, хор уршгийг таниулах мэдээлэл сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.
- Үл хайхрах хүчирхийллийн талаар хангалттай мэдлэггүйгээс хүүхдээ үл хайхрах шинжтэй аргыг хэрэглэж байгаагаа хүмүүс мэдэхгүй байх, түүнийгээ зөвтгөх хандлагатай байна. Гэхдээ энэ нь зөвхөн насанд хүрэгчдийн өөрсдийнх нь мэдлэг, ойлголт хангалтгүй байгаатай холбоотой бус бас дэлхий нийтийг хамарсан цар тахлын үеийн болон түүний дараах хүндрэлүүд, эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн стресс, уур бухимдал, завгүй амьдралын хэв маяг зэргээс хамаатай байж болно. Энд онцлоход, ажил олгогчид ажилтнаа зөвхөн ажилтан гэх бус гэр бүл, үр хүүхэдтэй гэдэг талаас нь харж, ажил амралтын цагийг зохицуулах, уян хатан байх шаардлага тавигдах болсныг хүний нөөцийн олон улсын чиг хандлага харуулж байна (Гартнер, 2022). Гэр бүл, үр хүүхдэдээ цаг гаргадаг, санаа тавьдаг, энэ талаар санаа зовох зүйлгүй ажилтнууд илүү бүтээмжтэй ажиллах магадлалтай байна. Тиймээс үл хайхрах болоод бусад хэлбэрийн зүй бус үйлдэл, хүчирхийллээс хүүхдийг хамгаалахын тулд насанд хүрэгчдэд өөрсдөд нь чиглэсэн ажлуудаас гадна аж ахуйн нэгж, байгууллага гэх мэт нийгмийн бусад институтуудын оролцоог нэмэгдүүлэх замаар ажиллах шаардлагатай нь харагдаж байна.
- Судалгаанаас анхаарал татсан нэг үр дүн нь бэлгийн хүчирхийллийн талаар огт мэдлэггүй насанд хүрэгчид бусад төрлийн хүчирхийллийн талаарх мэдлэггүй насанд

хүрэгчдээс их байгаа явдал юм. Нарийвчлан үзвэл, бага боловсролтой, ажил эрхэлдэггүй, алслагдсан дүүрэг, гэр хороололд амьдардаг хүмүүс бэлгийн хүчирхийллийн талаар мэдлэггүй байгаа нь энэ төрлийн хүчирхийлэл голчлон үйлдэгддэг бүлэг, байршилтай таарч байна. Иймээс хүүхэд хамгааллын аливаа бодлого, хөтөлбөрийг тодорхой бүлэг, сегментүүдэд чиглүүлэн ялгаатай байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай.

- Насанд хүрэгчдийн дунд бие махбодын хүчирхийллийг зөвтгөх хандлага байсаар байна. Тухайлбал, судалгаанд оролцсон 10 хүн тутмын 4 нь “зодууллаа гээд буруудаагүй” гэх зэргээр энэ төрлийн хүчирхийллийг дэмжих хандлагыг илэрхийлж, үүнийгээ хүүхэд хүмүүжүүлэх арга гэж үзэж байна. Хүүхдэд бие махбодын шийтгэл үзүүлэх бус хүмүүжлийн эерэг арга, хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах нь зүйтэй. Бага насны, эрэгтэй хүүхдүүд бие махбодын шийтгэл амсах нь элбэг байна. Хүүхдийг зодож шийтгэх нь буруу гэдгийг мэддэг боловч уг үйлдлийг хийдгийн гол шалтгаан нь насанд хүрэгчдийн хувьд үүнийг хүмүүжлийн арга мөн гэж үздэгтэй холбогдож байна. Насанд хүрэгчдээс гадна багш, нийгмийн ажилтан гэх хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд хүртэл хүүхдийг хүмүүжүүлэхийн тулд зодож шийтгэх хандлага харуулж байгаа нь чанарын судалгаанаас харагдсан. Иймээс насанд хүрэгчдийнх гэлтгүй хүүхэд хамгаалалд хамаатай мэргэжилтнүүдийн хандлагыг нарийвчлан судлах, сөрөг хандлагатай бол өөрчлөх чиглэлээр цаашид ажиллах шаардлагатай гэж үзэж байна.
- Насанд хүрэгчдийн 35 хувьд нь бэлгийн хүчирхийллийг эсэргүүцэх хандлага сул байгаагийн дотор 18-31 насны хүмүүсийн 10 хүн тутмын 4 нь “охид өмсөж буй хувцас, хийж буй үйлдлээсээ болоод бэлгийн хүчирхийлэлд өртдөг” гэх хандлагатай санал нийлж байна. Энэ нь хүчирхийллийн хохирогчийг буруутгах хандлага ялангуяа залуусын дунд түгээмэл байгааг харуулж байна. Иймэрхүү сөрөг хандлагаас болж хүчирхийлэлд өртсөн охид тусламж хүсэхгүй, хүчирхийлэлд өртөж байгаагаа нуух, улмаар хүчирхийлэлд дахин дахин өртөх эрсдэл дагуулна. Тийм учраас насанд хүрэгчдийн ойлголт мэдээллийг залруулах чиглэлээр нөлөөллийн ажлууд хийх шаардлагатай.
- 10 насанд хүрэгч тутмын 3 нь сэтгэл санааны хүчирхийллийг эсэргүүцэх хандлага сул байна. Хүүхдэд шаардлага тавьж байна, хүүхдүүд үүнийг ойлгох ёстой гэх байдлаар загнах, бусадтай харьцуулах үйлдэл гаргаж байгаагаа, түүнчлэн өхөөрдөж байна гээд хүүхдэд элдэв нэр хоч өгөх зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэж буйгаа тэр бүр ухаарч ойлгохгүй байна. Тиймээс иймэрхүү хандлагуудыг өөрчлөх чиглэлээр нөлөөллийн ажлууд хийх, үүнд насанд хүрэгчдийн мэдээлэл өргөн хүлээн авдаг сувгуудыг ашиглах хэрэгтэй.

Хүүхэд хамгааллын талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадал:

- Хүүхэд хамгааллын талаарх насанд хүрэгчдийн мэдлэг хангалттай сайн биш байна. Зарим талаар ташаа ойлголттой байх нь ч түгээмэл байна. Тийм учраас энэ талаарх мэдлэгийг насанд хүрэгчдэд хүргэх шаардлагатай. Үүний тулд ямар мэдээллийг ямар бүлгийн хүмүүст ямар сувгаар хүргэх тухайд анхаарах хэрэгтэй бөгөөд энэ талаарх тодорхой саналыг дор танилцуулав.

Зорилтот бүлэг	Боломжит мэдээллийн суваг, үйл ажиллагаа	Шаардлагатай мэдээлэл
41-ээс дээш насныхан	Сошиал медиа сувгуудыг ашиглах - Телевиз, радио, хорооны хамтарсан баг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс сургалт, өдөрлөг хийх - Автобусны буудал, худаг, дэлгүүрийн хаалган дээр мэдээлэл байршуулах	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж • Хүүхэд хамгааллын талаар иргэдийн хүлээх үүрэг, оролцоо • Хүүхэд хамгааллын зөрчил, зөрчлийг мэдээлэх арга зам • Хүүхэд хүмүүжлийн эерэг аргууд • Хүүхдийн эсрэг хүчирхийллийн төрөл, хэлбэр, үр дагавар
Дундаас доош түвшний боловсролтой иргэд		
Гэр хороололд амьдардаг иргэд		
Тэтгэврийн насныхан		
Ажилгүй иргэд		
Төрийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх шатны ажилтнууд	Сургалт хийх	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж • Төрийн байгууллагын эрх үүрэг, хамтын ажиллагаа гэх мэт
Хувийн байгууллагын гүйцэтгэх шатны ажиллагсад	Сургалт, өдөрлөг, бусад үйл ажиллагааг хийх	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомж • Хөдөлмөрийн тухай хуульд заасан хүүхэд хамгааллын бодлого • Ажил амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүл, үр хүүхдэдээ цаг зав гаргах тухай сурталчилгаа

- Судалгаанд оролцогчдын нас залуужих тусам фейсбүүк, юутүб, инстаграмаас мэдээлэл авч байгаа бол насны бүлэг ахих тусам телевиз, брошюр, танилцуулга, ам дамжсан яриа зэрэг уламжлалт мэдээллийн эх сурвалжаас авдаг ажээ. Тиймээс хүүхэд хамгааллын талаар олон нийтэд мэдээлэл түгээхдээ дээрх мэдээллийн сувгуудыг анхаарч үзэх нь чухал. Цахим орчинд хүүхэд хамгааллын талаар буруу, ташаа мэдээлэл байх талтай тул яг ямар байгууллагын сошиал медиа хаягаас үнэн зөв мэдээлэл авах талаар насанд хүрэгчдэд мөн ойлгуулах шаардлагатай.
- Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдээ “танихгүй хүнтэй ярихгүй байх”, “анхаарал болгоомжтой байх” зөвлөгөөг голчлон өгдөг бол энэ чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүд тэднийг “найзуудаа дээрэлхэж болохгүй”, “үе тэнгийн дээрэлхэлтийн сөрөг үр дагавар”, “хүүхдийн тусламжийн 108 дугаарт хэрхэн, ямар үед хандах” талаарх мэдээллийг өгдөг байгаасай гэж хүсэж байна. Тиймээс эцэг эх асран хамгаалагчдад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажилд энэ мэдээллийг оруулах зүйтэй. Нөгөө талаар “танихгүй хүнтэй ярихгүй байх” гэсэн зөвлөгөөг өгч байгаа нь эрсдэлт нөхцөл үүссэн тохиолдолд хүүхэд бусдын тусламжийг авахаас татгалзах байдлыг үүсгэх талтай тул нарийвчилсан мэдээлэл хүүхдэдээ өгөхийн чухлыг насанд хүрэгчдэд сануулах нь зүйтэй. Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдэдээ өгдөг мэдээлэл нь ерөнхий байх шинжтэй тул хүүхдэдээ мэдээлэл өгөхдөө тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохируулан дэлгэрүүлэн тайлбарлах арга барилыг эзэмшихэд нь тэдэнд туслах хэрэгтэй байна.
- Насанд хүрэгчдийн хувьд “хүүхдийг зөвхөн эцэг эх, асран хамгаалагчид хамгаалах ёстой” гэх хандлага нийтлэг байна. 10 тутмын зөвхөн 1 нь л бүх хүн хүүхэд хамгааллын үүрэг хүлээдэг гэж үзэж байна. Тиймээс насанд хүрэгчдэд зөвхөн хүүхэд хамгааллын мэргэжилтнүүд хүүхдийг хамгаалах биш насанд хүрсэн хүн бүрийн үүрэг гэдгийг таниулах нь чухал байна. Ингэж чадвал гудамж талбай, нийтийн тээвэрт хүүхдийн аливаа хэлбэрийн хүчирхийлэл, зүй бус байдалд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.
- Насанд хүрсэн 10 хүн тутмын 8-9 нь гудамж талбай гэх мэт нийгмийн орчинд бусдын хүүхэд ямар нэг зүй бус үйлдэл, хүчирхийлэлд өртөж байвал хамгаалах арга хэмжээ

авна гэсэн эерэг хандлагатай байгаа хэдий ч тийм үйлдэлтэй таараад, хамгаалах арга хэмжээ, ямар нэг үйлдэл хийсэн байдал харьцангуй доогуур байна. Бусдын хүүхэд яах нь надад хамаагүй, хүний хэрэгт оролцохгүй гэсэн аминчхан үзэл давамгайлж байна. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд хүн бүр оролцох ёстой гэсэн нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх нь чухал юм. Мөн төр, хувийн хэвшлийн байгууллагуудад НҮБ-ын Хүүхдийн Сан, Глобал компакт, Хүүхдийг Ивээх Сангаас гаргасан “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчмууд”-ыг сурталчлан таниулах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна (Гартнер, 2022).

- Насанд хүрсэн 10 хүн тутмын 9 нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зүй бус үйлдлийг мэдвэл мэдээлэх үүргийг бүх хүн хүлээнэ, хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана, хэнд хандахыг мэднэ гэж хариулсан хэдий ч 10 хүн тутмын 5 нь л хэнд, хэрхэн хандах талаар үнэн зөв мэдлэгтэй байна. Тиймээс насанд хүрэгчдийн хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана, хэнд хандах талаарх мэдлэгийн зөрүүг арилгаж, зөв мэдлэг мэдээлэлтэй болгох шаардлагатай байна.
- Сүүлийн нэг жилийн хугацаанд хүүхэд хүчирхийлэлд өртөж байгааг мэдсэн дөрвөн хүн тутмын нэг нь ямар нэг арга хэмжээ аваагүй бөгөөд үүнийхээ шалтгааныг хаана, хэнд хандахаа мэдэхгүй байсан, бусдын асуудалд оролцохыг хүсээгүй гэжээ. Түүнчлэн, хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэхэд цагдаагаар дахин дахин явах, мэдээлэгчийг нууцлахгүй байх зэрэг нь хүчирхийллийг мэдээлэхэд саад болдог гэж хандлага түгээмэл ажиглагдаж байна. Иймэрхүү саад бодит байдалд байгааг насанд хүрэгчдээс гадна мэргэжлийн хүмүүсийн ярианаас харагдаж байсан. Тийм учраас дүрэм журмыг өөрчлөх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулах хэрэгтэй.
- Гэр хороололд амьдардаг, ам бүл олуулаа, олон хүүхэдтэй, ажил эрхэлдэг иргэд хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх хандлага, дадал өндөр байгаа бол өндөр орлоготой, төвийн орон сууцны хороололд амьдардаг, цөөн ам бүлтэй, 1-2 хүүхэдтэй иргэд хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх хандлага, дадал харьцангуй доогуур байна. Тиймээс хүүхдийн эсрэг хүчирхийллийг таниулахад чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг өндөр орлоготой, орон сууцад амьдардаг иргэдийн дунд зохион байгуулах нь зүйтэй. Ингэхдээ СӨХ-той хамтран орон сууцны цахилгаан шатанд зураг хуудас байршуулах, дэлгэц болон оршин суугчдын сошиал групп дээр мэдээлэл сурталчилгааг цацах, нийтлэх, хөршийн холбоо, оршин суугчдын хамтын ажиллагааг идэвхжүүлэх нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Мэргэжилтнүүдтэй ярилцсан ганцаарчилсан ярилцлагын үеэр хүүхэд хамгаалахад ААНБ-ыг түшиглэх нь үр дүнтэй хэмээн дийлэнх нь зөвлөсөн билээ. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 7 дугаар сард батлан гаргаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж байна. Уг хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д “Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. ХНХЯ, ГБХЗХГ-аас ААНБ-уудын хүүхэд хамгааллын бодлогыг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлэх талаарх заавар, зөвлөмж, гарын авлага, сургалтын материалыг боловсруулан гаргаж, ААНБ-ын удирдлага, ажил олгогч, хүний нөөцийн менежерүүдэд зориулсан сургалтыг зохион байгуулах, хүүхэд хамгааллын бодлогыг амжилттай хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг сурталчлан таниулах ажлыг хийх хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

Bavolek, S. J., & Keene, R. G. (1984). *Adult-Adolescent Parenting Inventory AAPI-2 Form A*. Park City, Utah: Family Development Resources, Inc.

Morris, A. S., Hays-Grudo, J., Zapata, M. I., Treat, A., & Kerr, K. L. (2021). Adverse and protective childhood experiences and parenting attitudes: The role of cumulative protection in understanding resilience. *Adversity and Resilience Science*, 2, 181–192. DOI: <https://doi.org/10.1007/s42844-021-00036-8>

LeCroy, C. W., & Milligan-LeCroy. (2020). Public perceptions of child maltreatment: A national convenience sample. *Children and Youth Services review*, 119, 1–6. DOI: <https://doi.org/10.1016/j.chidyouth.2020.105677>

Conners, N. A., Whiteside-Mansell, L., Deere, D., Ledet, T., & Edwards, M. C. (2006). Measuring the potential for child maltreatment: The reliability and validity of the Adult Adolescent Parenting Inventory-2. *Child Abuse and Neglect*, 30, 39–53. <https://doi.org/10.1016/j.chiabu.2005.08.011>.

Zolotor, A. J., Runyana, D. K., Dunne, M. P., Jainc, D., Peturs, H. R., Ramirez, C., Volkovaf, E., Debg, S., Lidchih, V., Muhammadi, T., & Isaeva, O. (2009). ISPCAN Child Abuse Screening Tool Children's Version (ICAST-C): Instrument development and multi-national pilot testing. *Child Abuse & Neglect*, 33, 833–841. DOI: [10.1016/j.chiabu.2009.09.004](https://doi.org/10.1016/j.chiabu.2009.09.004)

International Society for the Prevention of Child Abuse and Neglect [ISPCAN]. (2015). *Manual for administration: The ISPCAN child abuse screening tool (ICAST)*. Retrieved from [ICAST-Combined-Manuals_V3.pdf](#)

Gartner. (2022). *EVP Employee Survey*.

Gershoff, E. T., & Grogan-Kaylor, A. (2016). Spanking and child outcomes: Old controversies and new meta-analysis. *Journal of family psychology*, 30(4), 453–469. DOI: [10.1037/fam0000191](https://doi.org/10.1037/fam0000191).

Dweck, C. (2014, December). *The power of believing that you can improve* [Video]. TED conferences. https://www.ted.com/talks/carol_dweck_the_power_of_believing_that_you_can_improve

Kazdin, A. E. (n.d.). *Everyday parenting: The ABCs of child rearing*. Coursera. <https://www.coursera.org/learn/everyday-parenting>

Save the Children. (2021). *Knowledge, attitude and practice surveys in child protection. The Child Protection Initiative, Save the Child*

Гэр Бүл, Хүүхэд, Залуучуудын Хөгжлийн Газар, Сургалт судалгаа мэдээллийн төв. (2018). *Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан. Улаанбаатар хот*.

Мобиком корпорац. (2020). 14-23 насны залуусын чанарын судалгааны тайлан. Улаанбаатар хот.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйборс ОУБ. (2017). Хүүхдийн эрх ба хамгаалал: Хүүхдийн эрхийн мэдлэг, хандлага, хэрэгжилт тодорхойлох судалгаа. Улаанбаатар хот.

Монгол Улс. (1999 оны 6 11). Гэр бүлийн тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://old.legalinfo.mn/law/details/226?lawid=226>

Монгол Улс. (2016 оны 12 22). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail/12393>

Монгол Улс. (2016 оны 2 5). Хүүхэд хамгааллын тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11710>

Монгол Улс. (2016 оны 12 22). Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. <https://old.legalinfo.mn/law/details/12393?lawid=12393>

Нийслэлийн Хүүхэд, Гэр Бүлийн Хөгжлийн Газар. (2014). Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа. Улаанбаатар хот.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан. (2018). Замын хөдөлгөөн дэх хүүхдийн аюулгүй байдал, осол гэмтлийн нөхцөл байдал. Улаанбаатар хот.

Хууль сахиулах их сургууль. (2019 он). МУ-д насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл. Улаанбаатар хот.

Хүүхдийг Ивээх Сан. (2017). Өсвөр үеийнхний дуу хоолой. Улаанбаатар хот.

Хүүхдийг Ивээх Сан. (2020). Корона вируст цар тахлын үр нөлөөний үнэлгээ. Улаанбаатар хот.

Хүүхдийг Ивээх Сан. (2021). Кейс менежментэд (зайнаас) хийсэн чанарын үнэлгээ. Улаанбаатар хот.

Харилцаа Холбооны Зохицуулах Хороо. (2020). Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал . Улаанбаатар хот .

Үндэсний Статистикийн хороо. (2017). Хүчирхийллийн нүцгэн үнэн: Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан. Улаанбаатар хот .

Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яам, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт. (2019). Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт. Улаанбатаар хот.

Хүүхдийг Ивээх Сан. (2022). Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь төслийн суурь судалгаа. Улаанбаатар хот.

Хүүхдийг Ивээх Сан. (2022). Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь (2021-2024) төслийн нөхцөл байдлын үнэлгээний тайлан. Улаанбаатар хот.

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН ХУГАЦААНЫ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

1. “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийн суурь судалгаа, 2021	
Байгууллага	Хүүхдийг Ивээх Сан
Судалгааны зорилго	“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл хэрэгжихээс өмнөх суурь үзүүлэлтүүдийг тодорхойлох, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх.
Судалгааны арга зүй	<ul style="list-style-type: none"> - Тоон судалгаанд 12-18 насны 664 сурагч охид хамрагдсан. - УБ хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг бүрээс 3 сургууль сонгосон бөгөөд уг гурван сургууль тус бүрийн нэг нь алслагдмал байршсан. - Судалгаанд хамрагдсан 14 болон түүнээс доош насны охидыг дунд анги, 15 болон түүнээс дээш насны охидыг ахлах ангийн охид гэж бүлэглэн “CAPI” аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан байна. - Чанарын судалгаанд хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүд, сургуулийн ажилтнууд, үйлчилгээ үзүүлэх бусад төрийн болон төрийн бус байгууллагын 63 голлох мэргэжилтэнтэй ярилцлага хийсэн байна. - Зорилтот 15 сургуулийн 14-18 насны сурагч охидоос хохирогч болсон хүүхдүүдийг холбогдох байгууллагууд, сургуулиудын нийгмийн ажилтнуудтай хамтран сонгон авч чанарын судалгаанд хамруулсан.
Судалгааны үр дүн	<ul style="list-style-type: none"> - Охидын дийлэнх нь буюу гурван охин тутмын хоёр нь эрсдэл, аюултай нөхцөл байдалд орвол хамгийн түрүүнд эцэг, эх, асран хамгаалагчдаа ханддаг байна. Харин хоёр охины нэг нь хүүхдийн тусламжийн 108 утсанд эсвэл цагдаад ханддаг аж. - Хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн төлөө ажилладаг ТББ, Хүүхэд, гэр бүл хөгжлийн төв, сургуулийн удирдлага, багш, сургуулийн болон баг, хорооны нийгмийн ажилтан, баг, хорооны засаг даргад хандах охидын тоо харьцангуй цөөн байгаа нь тэд эдгээр хүмүүс, байгууллагад хандах боломжтойг мэдэхгүй байгаатай холбоотой. - Охид хэн нэгнээс тусламж авч, хамгаалуулахдаа тэдний нэр төрд халдахгүй, сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөхгүй, нэмж эрсдэлд оруулахгүй, хүүхдийн эрхийг дээдэлсэн, шударга зарчимд тулгуурласан хүүхэд хамгааллын үйлчилгээ хүсэж байна. - Охидын хувьд өөрсдийгөө хамгаалах талаарх мэдлэг мэдээллийг голлон эцэг эх, асран хамгаалагчаасаа авдаг байна.
Судлаачийн дүгнэлт	Охидын хувьд өөрсдийгөө хамгаалах тухай мэдээлэл авах, түүнчлэн тэдэнд ямар нэг асуудал, эрсдэл учирвал хамгийн түрүүнд хандах хүн нь эцэг эх, асран хамгаалагч байна. Иймээс эцэг эх, асран хамгаалагчийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал ямар байгааг тодруулах шаардлага эндээс гарч байна.
2. Кейс менежментэд (зайнаас) хийсэн чанарын үнэлгээ, 2021	
Байгууллага	Хүүхдийг Ивээх Сан
Судалгааны зорилго	Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоо дахь кейс менежментийн үйл ажиллагааны чанарыг үнэлэх, кейс менежментийн үйл ажиллагааг сайжруулах

Судалгааны арга зүй	<p>Үнэлгээнд чанарын болон тоон мэдээлэл цуглуулах аргыг хослуулан хэрэглэжээ.</p> <ul style="list-style-type: none"> - Энэхүү үнэлгээний хүрээнд кейс файлын шалгалт 82, кейс ажилтны өөрийн үнэлгээ 32, Мэргэжлийн удирдлагын өөрийн үнэлгээ 11, Кейс ажилтны чадамжийн үнэлгээ 31, ганцаарчилсан ярилцлага (ГБХЗХГ) 2, Кейс ажилтнуудтай хийсэн бүлгийн ярилцлага 4, Мэргэжлийн удирдагчидтай хийсэн фокус бүлгийн ярилцлага 4, Эцэг эх/ асран хамгаалагчтай хийсэн ярилцлага 8, Эцэг эхээс санал дүгнэлт өгөх маягт 32, Хүүхдээс санал дүгнэлт өгөх маягт 33 хүнийг тус тус хамруулжээ. - Чанарын үнэлгээнд Архангай, Дорнод, Дундговь, Төв, Ховд аймаг болон Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Багахангай, Баянгол дүүргүүдийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсүүд, 33 хамтарсан баг хамрагджээ. - Тоон судалгааг Ковид-19 цар тахлаас хамааран үнэлгээнд хэрэглэх мэдээллийг цахим болон үүрэн телефон операторуудын гар утсаар харилцах арга хэрэгслийг ашиглан зайнаас цуглуулсан байна.
Судалгааны үр дүн	<ul style="list-style-type: none"> - Хүүхдийн тусламжийн 108 утас, айл өрхөөр явах, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх, цагдаад дуудлага өгөх, хэсгийн ахлагчдаар дамжуулан өрхүүдээр тандалт хийлгэх гэх мэт олон төрлийн арга хэмжээний дүнд хүүхэд хамгааллын кейсийг илрүүлэх, бүртгэх ажил ихээхэн ахицтай явагдаж байна. - Кейс менежментийн алхам бүрд хүүхдийн оролцоог хангах, сайжруулах, ингэхдээ кейс ажилтнуудын энэ талын чадавхыг дээшлүүлэх, хэрэгцээ байгаа нь харагдаж байна. - Хүүхэд, эцэг эхийг оролцуулахдаа мэдээлэл өгсний үндсэн дээр зөвшөөрөл авах, тэдний өгсөн мэдээллийг бүртгэх, хадгалах, хуваалцах практикийг сайжруулах, үүний тулд хүүхэд, эцэг эхээс зөвшөөрөл авах маягтыг боловсруулж, хэрэглэх гэжээ. - Хамтарсан багуудын мэдээллийн баримтжуулалт, хадгалалт, мэдээллийн менежмент, мэдээллийн хамгаалалт, мэдээлэл хуваалцах, нууц хадгалж буй өнөөгийн байдлыг сайжруулах хэрэгтэй гэжээ. - Кейс менежментийн үйл ажиллагааг хариуцах үндсэн үүрэг бүхий кейс ажилтан, мэргэжлийн удирдагч гэсэн ажлын байрыг хүүхэд хамгааллын тогтолцоонд бий болгох ёстой гэжээ.
Судлаачийн дүгнэлт	<p>Хүн ам багатай аймаг, суманд нууц хадгалах нь бэрхшээлтэй байдаг. Зарим нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүд эсвэл төрийн албаны бусад ажилтнуудын дунд нууц задруулдаг. Тиймээс нийгмийн ажилтны мэргэжилдээ хандах хандлагыг судлах хэрэгцээ байна. Кейс менежментийн үйл ажиллагааны хүрээнд кейс ажилтны дагах үйл явц болон кейсийг тодорхой цаг хугацаанд системтэй хийгээд зохистойгоор шийдвэрлэж буй байдал, кейс менежментийн үйл явцын алхмуудаа дагаж мөрдөж буй байдал зэргийг судлах шаардлагатай.</p>
3. 14-23 насны залуусын чанарын судалгааны тайлан, 2020	
Байгууллага	Мобиком корпорац, Эм Эм Си Жи ХХК
Судалгааны зорилго	<ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотын “Be” брэндийн үйлчилгээний 14-23 насны хэрэглэгчдийн онцлог шинж чанар, зан төлөвийг тодорхойлох - Тэдэнд хэрэгцээтэй байгаа бүтээгдэхүүнийг илрүүлэх - Залуусыг Мобикомын хэрэглэгч болгож, цаашид тогтоон барих кампанит ажлын чиглэлийг тодорхойлох
Судалгааны арга зүй	<ul style="list-style-type: none"> - Хоёрдогч мэдээлэлд анализ хийсэн. - Чанарын судалгааны арга буюу фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан. Уг ярилцлагад нас, насны төлөөлөл болсон 26 хүүхэд хамрагдсан байна. - Мөн 20 хүүхдээр ажлын 3 хоног, амралтын 2 хоног буюу 5 өдрийн турш 14-23 насны залуусын онцлог шинж чанар, зан төлөвийг тодорхойлох зорилготой өдрийн тэмдэглэл хөтлүүлсэн.

Судалгааны үр дүн	<p><u>Гэр бүлийн харилцаатай холбоотой санаа зовоосон асуудлууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Ганцаарддаг. Гэрийнхэнтэйгээ байгаад байхаар намайг ойлгодог хүн гарч ирээсэй гэж хүсдэг болчихдог. Найзуудтайгаа уулзахаараа маш их хөгжилтэй байдаг хэр нь гэртээ очихоороо маш ганцаардмал байдаг. - Хувийн орон зай дутагддаг. Өрөөндөө жаахан байх гэхээр “Юугаа хийгээд байгаа юм, гарч дүүгээ хар, юугаа хийгээд өрөөндөө шигдээд байгаа юм” гэдэг. - Эцэг, эх нь өөрийн сонирхлыг хүүхдүүддээ тулгадаг. - Хэрэв намайг ойлгох хүн байхгүй бол утастайгаа нөхөрлөдөг. - Гэр бүлийн харилцаа тааруухан. Аав ээжтэйгээ найз нөхөд шиг илэн далангүй байдаггүй. Аав ээж нар хуучны сэтгэхүйгээрээ ханддаг - Бидний үеийн хүүхдүүдийн онцлогийг ээж аав нар мэдэхгүй. Өөрсөд шигээ байлгах гээд зүтгээд байдаг. - 2-3 үеийн хүмүүс нэгэн зэрэг амьдарч байгаа болохоор хуучин үеийнхэн нь шинэ үеийнхнээ ойлгож хүлээн зөвшөөрч чаддаггүй. BTS, Чингис хаан хоёрыг харьцуулдаг. - Дүүтэй хүүхдүүд хэцүү. Чи айлын том эгч нь байж дүү нартаа үлгэр дуурайл үзүүл гээд байдаг. Хамгийн хэцүү нь дүү нарын хийсэн бүх буруу миний бурууг болдог. Тэгээд зодуулна. - СУ –д орж бөөнөөрөө сууж ярилцдаг. Гэртээ бол дураараа байж чаддаггүй. Ингээд хэлчихвэл юу гээд загнуулчих бол гэж бодоод байдаг. - Ярилцах гэхээр өөдөөс ууртайгаар “Яасан юм. Хурдан хэл” гэдэг. Тэгэхээр нь айгаад хэлдэггүй. - Сонирхлоороо найз нөхөдтэйгөө уулзаад явъя гэхээр эцэг эх нь гаргадаггүй. Түүнээс болж хэтэрхий их утсаа ухдаг. Ер нь бол биеийн хүч муу болсон. <p><u>Онлайн орчинд</u></p> <ul style="list-style-type: none"> - Хуурамч аккаунтаар амныхаа зоргоор муулдаг. Зүгээр явж байгаа хүний зургийг дараад “Ямар тэнэг юм өмссөн юм бэ?” гэдэг. Өөрөөс нь илүү гарсан, эсвэл үнэнийг хэлсэн хүүхдүүдэд дургүй нь хүрээд ийм үйлдэл гаргадаг. - Хэрвээ ийм зүйлд өртвөл олон сөрөг сэтгэгдлүүд ирдэг нь маш хэцүү. Тиймээс хэсэг хугацаанд фейсбүүк орж чаддаггүй, хичээлдээ явах дургүй болчихсон. - Хөвгүүд ч өртдөг. Санамсаргүйгээр шорт нь шувтрах, жаахан эвгүй үйлдэл гаргах үед зургийг нь дараад социалд тавьдаг байна. <p><u>Сургуулийн болон бусад орчинд</u></p> <ul style="list-style-type: none"> - Гадуурхал, нэгнээ гутаан доромжлох. Дээд үеийн эгч, дүү нар сургуулийн орчинд, гэр бүлийн, үеийн охидын дарамт - Охид төрөлхийн давхраатай нэгнээ муулдаг. - Зуны трендээр хувцасласан байсан ч “Юу өмсчихсэн юм бэ” гэж хардаг. - Хөвгүүд доожоогүй нэгнээ дээрэлхдэг. - Хөгжлийн бэрхшээл, мэнгэ, сорви, биеийн хэлбэр, ар гэрийн байдал, өвөрмөц стиль зэргээр ялгаварлаж хоч өгдөг нь сэтгэл санааны их дарамт мэдрүүлдэг. Үүнээс болж өөр сургууль руу шилждэг. - Хэрэв онлайнд, сургуулийн орчинд доромжлоод байвал сэтгэлийн хатгүй хүүхдүүд амиа хорлох эрсдэлтэй. <p><u>Нийгмийн зүгээс ирэх дарамт, асуудал:</u></p> <ul style="list-style-type: none"> - Сонирхлоор гадуурхах – К-поп сонсохоор гадаадын юмнуудыг сонсох хэрэггүй, гомо, лесби, мэс засал хийлгэсэн, нүүрээ буддаг зэргээр харьцуулж ялгаварладаг. - Жендерийн асуудал – Волейбол тоглодог эрэгтэй, сагс тоглодог эмэгтэй хүүхэд гэхээр сонин болоод байдаг. Эрэгтэй эмэгтэй хүүхдүүд хамт найзалбал ийм тийм гээд ярьдаг. - Мөнгө үрэхгүйгээр цагаа өнгөрүүлэх газар байхгүй. Хэрэв найзуудын гэр боломжтой бол очдог. Кофе шопод сууя 20 мянган төгрөг зарцуулна.
-------------------	--

	<ul style="list-style-type: none"> - Буруу зуршил – Уур бухимдлаа дарах гэж тамхи татдаг, архи их уух. - Чөлөөтэй байя гэхээр гаднын нөлөөнөөс болж муугаар хэлүүлэх гээд байдаг учраас айгаад сэтгэл зовнидог. - Стилиэ дагаад хурц өнгөтэй хувцас өмсөх гэхээр ахимаг насныхан элдвээр хэлдэг. Автобусанд юбкатай орохоор “Алцганасан юм. Одоогийн хүүхдүүд ийм болсон” гэдэг.
Судлаачийн дүгнэлт	<p>Гэр бүлийн орчинд хүүхдүүдэд тулгамддаг гол асуудлууд нь эцэг, эх, асран хамгаалагч нь тэднийг ойлгодоггүй, тэдний үзэл бодлыг хүндэтгэдэггүй, хувийн орон зайг нь олгодоггүй, хувь хүн талаас нь авч үзэхгүй өөрсдийн хүслээр байлгах хандлагатай байдаг нь хүүхдүүд гэрт байх дургүй болоход нөлөөлж байна. Дүү нартай хүүхдүүдийн хувьд дүү нарынх нь хийсэн бүх буруу өөрийнх нь буруу болдог байна. Энэ нь хүүхдүүдэд шударга бус санагдаж байна. Иймээс эцэг, эх, асран хамгаалагч болон хүүхэд хоорондын харилцаа хандлагыг судлах мөн эцэг, эх, асран хамгаалагч хүүхдүүдийнхээ нас насны онцлогт тохирсон хүмүүжлийн эерэг арга хэрэглэх мэдлэг, хандлага, дадал ямар байгааг судлах хэрэгцээ байна.</p>
4. “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал” суурь судалгаа, 2020	
Байгууллага	Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
Судалгааны зорилго	13-18 насны хүүхдүүд болон 7-18 насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдээ цахим орчинд дарамт шахалт, доромжлол, гэмт хэрэгт өртөх эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэг, хандлага, дадлыг судалжээ.
Судалгааны арга зүй	<p>Уг судалгааг гүйцэтгэхдээ тоон болон чанарын судалгааны арга ашигласан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Судалгааны нэгж буюу түүврийн нэгж нь 13-18 насны хүүхдүүд байсан ба түүврийн хамрах хүрээг тогтооходоо Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг, Налайх дүүрэг болон Дархан, Эрдэнэт хот болон баруун, зүүн, төв, говийн бүсийн тус бүр 1 аймгийн төвийг сонгон авч 705 хүүхдээс нүүр тулсан ярилцлагын аргаар тоон судалгааны мэдээлэл цуглуулжээ. - Цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг 7 мэргэжилтэнтэй ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан. Ингэхдээ цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр цаашид хийж хэрэгжүүлбэл зохих ажлууд, хүндрэл бэрхшээл зэргийг тодорхойлоход чиглэгдсэн байна.
Судалгааны үр дүн	<ul style="list-style-type: none"> - 7-12 насны хүүхдүүдийн 62% нь, 13-18 насны хүүхдийн 71% нь өдөр бүр интернэт ашигладаг байна. - Интернэт орчинд 7-12 насны хүүхдүүд өдөрт дунджаар 2.3 цагийг, 13-18 насныхан 4.0 цагийг зарцуулдаг байна. - Олон улсын цахилгаан холбооны байгууллага (ITU) нь 5-10 насны хүүхдэд өдөрт 1 цагаас бага, 11-18 насны хүүхдэд өдөрт 2-оос бага цагийг цахим хэрэглээнд зарцуулах стандартыг гаргасан байдаг. Энэ стандартаас манай хүүхдүүдийн цахим хэрэглээ өндөр байна. - Эцэг, эхчүүдийн 91% нь өөрийн хүүхдээ цахим орчны халдлагад өртөж байгаагүй гэж боддог байна. Гэтэл хүүхдүүдийн судалгаанаас харахад тэдний 87% нь цахим орчны халдлагад өртөж байжээ. Хүүхдүүд эцэг, эх, асран хамгаалагчдаа цахим дарамтад өртсөн гэдгээ хэлэхгүй байгаа нь цахим халдлагаас гарах сөрөг нөлөөг улам ихэсгэх нөхцөл нь болж байна. - 13 болон түүнээс дээш настай хүүхдийг фейсбүүк хаяг нээхийг зөвшөөрдөг боловч бодит байдал дээр 7-12 насны хүүхдүүдийн 50% нь фейсбүүк хэрэглэж байна. Гэтэл эцэг, эх, асран хамгаалагчид хүүхэд хэдэн настайгаасаа фейсбүүк ашиглах эрхтэй байдаг гэдгийг 62% нь мэдэхгүй байна. Мөн хүүхдийнхээ цахим орчин дахь найзуудыг 30% нь огт мэддэггүй, бүх найзуудыг нь мэддэг эцэг, эх зөвхөн 11% нь байна. - 13-18 насны хүүхдүүдийн 10 хүүхэд тутмын 8 нь буюу 77% нь фейсбүүкийн 1-ээс олон хаягтай байна. Найзууд нь дунджаар 3-4 хаягтай. Фейсбүүкийн илүү хаягаараа 61% нь бусадтай чатлах, танилцах, 36% нь эцэг эхийн хяналтгүй сошиал медиа ашиглах зорилготой байдаг гэжээ.

	- Хүүхдүүдийн 93% нь интернэт орчноор дамжуулан үйлдсэн гэмт хэргийн талаар ямар нэгэн байдлаар сонсож байсан боловч өөрийгөө хамгаалах үйлдлүүдийг хангалттай түвшинд хийж чадахгүй байна. Тухайлбал, найзуудаас ирсэн холбоос бүхий мэдээллийг 52% нь шууд дарж үздэг гэжээ.
Судлаачийн дүгнэлт	Бүх насны хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагч хамгаалах үүрэгтэй. Гэтэл хүүхдүүд хараа хяналтгүйгээр цахим орчинд чөлөөтэй зорчиж, цахим орчинд болдог бүхий л эрсдэл, аюулын дунд амьдарсаар байна. Тиймээс цахим орчны зөв зохистой хэрэглээний талаар эцэг, эх, асран хамгаалагчийн мэдлэг, хандлага, дадал ямар байгааг үргэлжлүүлэн судлах хэрэгцээ байна.
5. Коронавируст цар тахлын үр нөлөөний үнэлгээ, 2020	
Байгууллага	Хүүхдийг Ивээх сан
Судалгааны зорилго	Энэхүү түргэвчилсэн үнэлгээг Ковид-19 цар тахал, түүнээс урьдчилан сэргийлэхээр тогтоосон хөл хорио, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосноос үүдэн өрх гэр бүл, хүүхдийн амьдралд гарч буй өөрчлөлтийг судлан хэрэгцээг тодорхойлох зорилгоор хийжээ.
Судалгааны арга зүй	Түргэвчилсэн үнэлгээнд тоон судалгааны аргыг ашигласан байна. Түүврийн хамрах хүрээг сонгохдоо зорилтот түүврийн аргыг ашиглан тухайн орон нутгийн хамгийн эмзэг өрхийг сонгон зохион байгуулжээ. <ul style="list-style-type: none"> - Үнэлгээг Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн 9 хороо, орон нутагт Ховд, Завхан, Өвөрхангай, Архангай, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод аймгийн 35 сумаас нийт 555 өрх; - 12-18 насны 59 хүүхэд; - Салбарын үйлчилгээ үзүүлэгч 108 хүн буюу нийт 722 хүнийг хамруулсан байна.
Судалгааны үр дүн	- Судалгаанд хамрагдсан хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч нарын 45.9% нь энгийн үетэй харьцуулахад цар тахлын хөл хорионоос хойш хүүхдийн эсрэг хүчирхийлэл, тэр дундаа хүүхдийн эсрэг сэтгэл санааны дарамт болон үл хайхрах хүчирхийлэл ихэссэн гэж мэдээлэв. Түүнчлэн хүүхдийн эсрэг бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл мөн тодорхой хувиар ихэссэн байна. <ul style="list-style-type: none"> - Эцэг эх, асран хамгаалагч болон хүүхдүүдийн дийлэнх нь гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг ямар нэг байдлаар мэдээлэх ёстой гэдгээ мэдэж байв.
Судлаачийн дүгнэлт	Цар тахлын үед хүүхдүүд гэр бүлийнхэнтэйгээ хамгийн их цаг өнгөрөөсөн. Энэ үед хүүхдийн эсрэг хүчирхийлэл тэр дундаа сэтгэл санааны дарамт, үл хайхрах хэлбэр хамгийн түгээмэл байгаа нь судалгаанаас харагдаж байна. Тиймээс эцэг, эх, асран хамгаалагчид одоо хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг ашиглаж чадаж байгаа эсэхийг нь үргэлжлүүлэн судлах хэрэгцээ байна.
6. Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт, 2019	
Байгууллага	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Судалгааны зорилго	Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийг судалж, 2004, 2010 оны суурь судалгаануудтай харьцуулж, өөрчлөлтийг тодорхойлоход судалгааны зорилго оршино.
Судалгааны арга зүй	Тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан ашигласан. Мөн баримт өгөгдөлд дүн шинжилгээ хийжээ. Судалгааны түүвэрлэлт: Нийслэлд 816, аймгуудад нийт 1200 өрх, үүнээс тэгш хуваарилалтаар аймаг бүрд 120 өрхийг судалгаанд хамруулжээ.
Судалгааны үр дүн	- Хүмүүжлийн хэв маягийн хувьд эцэг, эхчүүд хүүхдийнхээ дэргэд зүй бус үг хэллэг ашиглах, согтууруулах ундаа хэрэглэх, хүүхдээ зодох үйлдлүүдийг гаргаж байна. <ul style="list-style-type: none"> - Судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүд хүүхдээ хүмүүжүүлэхдээ ихэвчлэн хүчирхийллийн шинжтэй шийтгэлийн аргуудыг хавсран хэрэглэж байна. - Бага насны хүүхдийн видео тоглоомын хэрэглээг эцэг, эхчүүдийн 64.2 хувь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэх шалтгаанаар хорьдог ба тоглож буй төхөөрөмжийг хураах, интернэт салгах зэрэг арга хэрэглэдэг байна.

	<ul style="list-style-type: none"> - Гэр бүл цуцлалтад анхаарал, халамж, эрүүл мэндийн байдал, гэр бүлийн хүчирхийлэл хамгийн ихээр нөлөөлж байна. Гэр бүлд зөрчил маргаан үүсгэгч хүчин зүйлүүдийг эрэмбэлбэл санхүү (41.4%), согтууруулах ундааны хэрэглээ (15.7%), хүүхдийн асуудал (15.3), өр зээл (13.9%), үзэл бодлын зөрчлөөс (11) байна. Үүсэж байгаа зөрчил, маргааныг гэр бүлийн гишүүдээр нь харьцуулахад ихэвчлэн эхнэр, нөхрийн хооронд (79.9%) эцэг, эх болон хүүхдүүд (19.1%), хадмууд болон хүргэн бэрүүдийн (7.1%) хооронд хамгийн ихээр үүсдэг байна. - Монгол гэр бүлийн төр, засгаас зохицуулалт хүсэж, дэмжин ажиллахыг хүссэн гол асуудал бол гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг өсгөх, орлого нэмэгдүүлэх асуудал байна. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх олон талт ажлыг зохион байгуулахгүй бол оюуны хэрэгцээ буюу сурч хөгжих, үр хүүхдэдээ анхаарах хэрэгцээ гарч ирэхгүй гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн амьдралын сөрөг асуудлыг багасгахад тэдний анхдагч хэрэгцээгээ хангахад дэмжлэг үзүүлэх асуудал нэн тулгамдсан асуудал болжээ.
Судлаачийн дүгнэлт	Гэр бүлийн гишүүд тэр дундаа хүүхдийн хүмүүжил, төлөвшил, түүнд нөлөөлөгч хүчин зүйлийг илрүүлэх үндэсний хэмжээний судалгааг олон улсад хэрэглэдэг арга, аргачлалын дагуу тогтмол зохион байгуулах, хүүхдэд тохиромжтой эерэг хүмүүжлийн хандлагыг тодорхойлж, төрийн бодлого, хөтөлбөрт ашиглах хэрэгцээ байна.
7. Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайлан, 2018	
Байгууллага	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сургалт судалгаа мэдээллийн төв
Судалгааны зорилго	Өсвөр үеийнхний цахим хэрэглээний түвшин, мэдлэг, хандлагыг тодорхойлон, хүүхдийг цахим хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн нотолгоонд тулгуурласан зөвлөмж боловсруулах юм.
Судалгааны арга зүй	ЕБС-ийн 11-17 насны сурагчид, багш, нийгмийн ажилтнууд болон 11 наснаас дээш хүүхэдтэй эцэг эхчүүд судалгаанд хамрагдсан. 21 аймаг болон Нийслэлийн 9 дүүргээс нийт 30 сургуулийг сонгон хамруулсан. Түүвэрлэлтийн нэгжийг сургуулиар сонгон авсан бөгөөд нэгж сургуулиас 11-17 насны сурагчдын тоог хамгийн багадаа 70 байхаар тооцоолон, сурагчдын нэрсийн жагсаалтаас тохиромжит түүврийн аргаар сонгон асуулга судалгаанд хамруулжээ. Судалгаанд 11-17 насны 2240 хүүхэд, 378 эцэг эх болон ЕБС-ийн 402 багш, нийгмийн ажилтан нийт 3019 хүнийг тоон судалгаанд хамруулсан байна.
Судалгааны үр дүн	<ul style="list-style-type: none"> - Судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн интернэтийн хэрэглээ маш өндөр байсан ба тэдний нас өсөх тусам цахим хэрэглээний түвшин нэмэгдсэн байна. - Сурагчдын дийлэнх буюу 85 орчим хувь нь ухаалаг утас хэрэглэдэг, тэдний 92 хувь нь фейсбүүк хаягтай байв. Эндээс үзэхэд ухаалаг утас авах нь тийм ч хүндрэлтэй асуудал биш гэдэг нь харагдаж байна гэж дүгнэсэн байна. - 3 хүүхэд тутмын 1 нь цахим орчны хувийн нууц мэдээллээ хадгалах тохиргоог огт мэддэггүй бөгөөд эцэг эхчүүдийн энэ талын мэдлэг нь хүүхдээсээ муу гэж дүгнэгдсэн байна. - 2 хүүхэд тутмын 1 нь садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, 5 хүүхэд тутмын 4 нь цахимаар зүй бус утгатай зурвас авдаг ба эцэг эхчүүдийн 35 хувьд нь ийм төрлийн сөрөг мэдээллийг шүүх программ хангамжийг ашиглах чадвар огт байхгүй байсан байна. - 3 хүүхэд тутмын 1 нь гар утасны дугаар өөр хүний нэр дээр бүртгэлтэй байна. Гар утасны дугаарыг хүүхдийн нэр дээр бүрэн бүртгэгдүүлснээр хориглосон буюу сөрөг нөлөө бүхий мэдээлэл хүлээн авахаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой гэж үзсэн байна.

	<ul style="list-style-type: none"> - Эцэг, эхчүүдийн 80 орчим хувь нь хүүхдийнхээ интернэтийн хэрэглээнд их бага хэмжээнд хяналт тавьдаг гэсэн хэдий ч тэдний 95 орчим хувь нь цахим орчны шүүлтүүрийн программ хангамжийг ашиглах чадваргүй, 40 хувь нь цахим орчинд хувийн мэдээллээ нууцлах тохиргооны мэдлэг огт байхгүй байна. Түүнчлэн хүүхэд нь цахим хүчирхийлэлд өртвөл 92 хувь нь гэрийнхэндээ энэ тухайгаа хэлдэг гэж эцэг, эхчүүд хариулсан хэдий ч энэ асуултыг хүүхдээс өөрөөс нь асуухад дөнгөж 36 хувь нь эцэг эх, гэр бүлийн гишүүддээ хэлнэ гэж хариулжээ. Энэ нь цахим орчинд аливаа хүчирхийлэлд өртсөн гурван хүүхэд тутмын нэг нь эцэг эхдээ хэлдэг болохыг харуулж байна. - ЕБС-ийн 3 багш тутмын 1 нь сурагчдад энэ талын зөвлөгөө өгөхөд бэлэн биш гэж өөрийгөө дүгнэсэн байв. ЕБС-д өсвөр насны хүүхдүүдэд цахим орчны аливаа эрсдэлийг таниулах, урьдчилан сэргийлэх талаар хичээл явуулах арга зүйн болон сургалтын материал дийлэнхэд нь байхгүй байна. Иймээс цаашид сурагчдад цахим орчны зөв хэрэглээ, аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох багш бэлтгэх шаардлагатай гэж 80 орчим хувь нь үзжээ.
Судлаачийн дүгнэлт	Бүх насны хүүхдүүдийг эцэг эх, асран хамгаалагч хамгаалах үүрэгтэй. Гэтэл хүүхдүүд хараа хяналтгүйгээр цахим орчинд чөлөөтэй зорчиж, цахим орчинд болдог бүхий л эрсдэл, аюулын дунд амьдарсаар байна. Тиймээс цахим орчны зөв зохистой хэрэглээний талаар эцэг, эх, асран хамгаалагчийн мэдлэг, хандлага, дадал ямар байгааг үргэлжлүүлэн судлах хэрэгцээ байна.
8. Замын хөдөлгөөн дэх хүүхдийн аюулгүй байдал, осол гэмтлийн нөхцөл байдал, 2018	
Байгууллага	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сан (НҮБХС)-гийн захиалгаар Судалгаа зөвлөх үйлчилгээний Эм Эм Си Жи ХХК, Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачидтай хамтран хийсэн.
Судалгааны зорилго	Зам тээврийн осол гэмтлийн цар хүрээ, хандлага, нөлөөлж буй хүчин зүйлс, хууль эрхзүйн болон бодлогын орчин, тогтолцоонд дүн шинжилгээ, үнэлгээ хийж зам тээврийн осолд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж, хууль эрхзүйн болон тогтолцооны дутагдалтай байдлыг илрүүлж, дүгнэлт санал зөвлөмж боловсруулах зорилготой.
Судалгааны арга зүй	<p>Энэхүү үнэлгээний хүрээнд дараах асуудлыг хамруулан авч үзсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Зам тээврийн осол, гэмтэл, нас баралтын нөхцөл байдал, чиг хандлага. - Зам тээврийн осол, гэмтэл нас баралтад нөлөөлөгч хүчин зүйлс. - Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль эрх зүйн орчин, тогтолцоо, тухайн чиглэл дэх бодлого хөтөлбөрүүд. <p>Дээрх асуудлыг тодруулахдаа одоогийн байгаа статистик мэдээлэл, холбогдох байгууллагуудаас гаргасан тайлан мэдээлэл, судалгаа зэрэгт дүн шинжилгээ хийсэн байна. Үүнээс гадна зам тээврийн осолд нөлөөлөгч хүчин зүйлийг нарийвчлан тодорхойлох зорилгоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх олон нийтийн мэдлэг, хандлага, туршлага”-ын тоон болон чанарын судалгааг хийж, үр дүнг нэгтгэн үнэлгээний тайланд тусгасан байна.</p>
Судалгааны үр дүн	<ul style="list-style-type: none"> - Иргэдийн дунд зөвхөн зам хөндлөн гарч байгаагаа замын хөдөлгөөнд оролцож байна гэж ойлгох хандлага байсаар байна. - Хүүхэд зам тээврийн осолд өртсөн тохиолдолд хүнд, хүндэвтэр гэмтэх, нас барах хандлага илүү байдаг ба зам тээврийн ослын гол хохирогч нь хүүхэд болдог байна. - 2000-2017 оныг хүртэлх хугацаанд зам тээврийн ослын улмаас нийтдээ 851 хүүхэд амь насаа алдаж, 3,446 хүүхэд хүнд болон хүндэвтэр гэмтсэн нь маш ноцтой үзүүлэлт юм. Хүүхэд бага насандаа зам тээврийн осолд өртөж хүнд болон хүндэвтэр гэмтэх нь хүүхдийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлж, хөгжлийн бэрхшээлтэй болоход хүргэх талтай. - Нийслэл хотод хүүхдүүд явганаар зорчиж байгаад осол гэмтэлд ихээхэн өртөж байгаа бол орон нутгийн замд тээврийн хэрэгслээр зорчиж байгаад зам тээврийн осолд өртөж амь насаа алдах тохиолдол давамгайлдаг байна.

	<ul style="list-style-type: none"> - Нийслэлд хотод хүүхэд явган зорчигч хэлбэрээр осолд өртсөн тохиолдол нь хотын зах, гэрэлтүүлэг хангалтгүй газар бүртгэгдсэн байв. - Эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэг, хандлага муу байдлаас болж хүүхэд зам тээврийн осолд өртөхөд нөлөөлдөг байна. Жишээ нь Хүүхдийн цүнх хувцсанд цацруулагч хийж өгөхөд ач холбогдол өгдөггүй байна. - Эцэг эхчүүд хүүхдэдээ замын хөдөлгөөнд оролцохдоо “Явган хүний гарцаар гарах”, “ногоон гэрлээр зам хөндлөн гарах”, “машин ирж байгаа эсэхийг сайтар харж байгаад гарах”-ыг голчлон зөвлөдөг байна. - Хүүхдэдээ анхаарал хандуулах байдал өрхийн сууцны төрөл, байршил, орлогын түвшнээс хамаарч өөр өөр байдаг байна. - Нөгөө талаас хүүхдүүд замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдээллийг сургуулиасаа авах ёстой хандлага давамгайлж байна. - Багш нарын үзэж байгаагаар эцэг, эхчүүд өөрсдөө хүүхдээ буруу төлөвшилд сургадаг. Энэ нь хүүхдийг сургуулиас тараад ирэхэд нь эцэг, эхчүүд хүүхдүүдээсээ асууж буй асуултаар илэрдэг. Тухайлбал, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ сургуулиас нь тараад ирэхэд нь “Юу сурсан, юу мэдэж авсан” гэх асуулт асуухын оронд “Багш нь загнасан уу, ямар хоол идсэн, ямар дүн авсан” гэж асуудаг. Энэ нь худал хэлэх, багшаа үл хүндэтгэх буруу төлөвшлийг суулгадаг гэжээ. - Эцэг, эхчүүд хүүхдэдээ 1-3 дугаар анги хүртэл анхаарал хандуулж байгаад 4 дүгээр ангиас эхлэн хүүхдэдээ анхаарал тавих нь сулардаг байна.
<p>Судлаачийн дүгнэлт</p>	<p>Хүн амын тоо, түүн дотроо нийслэл хотын хүн амын тооны өсөлтөөс тээврийн хэрэгслийн тооны өсөлт нь хэд дахин илүү байгаа нь цаашид замын хөдөлгөөн аюулгүй байдлын чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авахгүй бол зам тээврийн осол, гэмт, түүнээс шалтгаалсан нас баралт улам нэмэгдэхээр байна.</p> <p>2000-2017 оныг хүртэлх хугацаанд зам тээврийн ослын улмаас нийтдээ 851 хүүхэд амь насаа алдаж, 3,446 хүүхэд хүнд болон хүндэвтэр гэмтсэн нь маш ноцтой үзүүлэлт юм. Хүүхэд бага насандаа зам тээврийн осолд өртөж хүнд болон хүндэвтэр гэмтэх нь хүүхдийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлж, хөгжлийн бэрхшээлтэй болоход хүргэх талтай. Гэхдээ зам тээврийн ослын улмаас авсан гэмтэл бэртэл нь хөгжлийн бэрхшээлд хүргэсэн эсэх талаар нарийвчилсан судалгаа байхгүй байна.</p> <p>Эцэг эх, асран хамгаалагчдын мэдлэг, хандлага муу байдлаас болж хүүхэд зам тээврийн осолд өртөхөд нөлөөлдөг байна. Жишээ нь Хүүхдийн цүнх хувцсанд цацруулагч хийж өгөхөд ач холбогдол өгдөггүй,</p>
<p>9. Хүчирхийллийн нүцгэн үнэн “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа”, 2017</p>	
<p>Байгууллага</p>	<p>Үндэсний Статистикийн Хороо нь НҮБ-ын Хүн амын сан болон Швейцарын Хөгжлийн Агентлагийн техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр анх удаа зохион байгуулжээ.</p>
<p>Судалгааны зорилго</p>	<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай үндэсний хэмжээний статистик тоо мэдээ, мэдээллийг болгох, мэдээллийн эх үүсвэртэй болох зорилготой.</p>
<p>Судалгааны арга зүй</p>	<p>Энэхүү төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын аргачлалыг ашиглан хийжээ. Уг судалгааг тоон болон чанарын судалгааны аргаар хийжээ.</p> <ul style="list-style-type: none"> - Тоон судалгааны хүрээнд хүн амд суурилсан өрхийн судалгаагаар Монгол Улсын 21 аймагт мэдээлэл цуглуулжээ. Ингэхдээ олон шатлалт түүврийн аргыг ашиглан 7860 өрхийг сонгосон бөгөөд өрхөөс судалгаанд хамрагдах шалгуурт нийцсэн 15-64 насны нэг эмэгтэйг санамсаргүйгээр сонгон нийт 7319 эмэгтэйтэй ярилцлага хийжээ. - Чанарын судалгааны хүрээнд тоон судалгаанаас гарах боломжгүй байсан нэмэлт мэдээллийг цуглуулахын тулд 392 иргэнтэй 64 зорилтот бүлгийн ярилцлага (ЗБЯ), 87 ганцаарчилсан ярилцлага, 59 мэргэжилтнүүдийн ярилцлагыг зохион байгуулжээ. Мөн 15-64 насны 197 эрэгтэйтэй хийсэн ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагаар мэдээлэл цуглуулсан байна.

Судалгааны үр дүн	Уг судалгааны 8 дугаар бүлэгт хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн хүүхдэд үзүүлэх нөлөө гэсэн дэд бүлэгт хүчирхийлэлтэй гэр бүлд өсөж байгаа хүүхдүүд илүү аймхай, зожиг, түрэмгий ааштай, хар дарж зүүдэлдэг ба хүчирхийлэл нь хүүхдийн зан байдалд сөрөг нөлөөтэй болохыг дурджээ.
Судлаачийн дүгнэлт	Гэр бүлийн хүчирхийлэл нь хүүхдүүд болон гэр бүлийн бусад гишүүдэд сөргөөр нөлөөлдөг. Хүчирхийлэлд өртсөн, хүчирхийлэл харж өссөн хүүхэд хүчирхийлэлд өртөж байгаагүй хүүхдүүдтэй харьцуулахад өөртөө итгэлгүй, өөрийн үзэл бодолгүй, аймхай, зожиг, түрэмгий ааштай, зан харьцааны доголдолтой болж өсдөг байна. Иймээс гэр бүлийн хүчирхийлэл нь хүүхдэд хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг олон улсын арга аргачлалд тулгуурлан гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ байна.
10. Өсвөр үеийнхний дүү хоолой, 2017	
Байгууллага	Хүүхдийг Ивээх Сан
Судалгааны зорилго	Судалгаагаар хүүхдүүд санал бодлоо илэрхийлж чадаж байгаа эсэх, хүүхдийн санал бодлыг хүндэтгэн сонсож чаддаг эсэх, хүүхдийн эрх хаана хамгийн их зөрчигдөж байна, эрх үүргээ мэдэж байгаа байдал зэргийг тодруулсан байна.
Судалгааны арга зүй	Судалгааг тоон болон чанарын судалгааны аргаар хийжээ. Шведийн Хүүхдийг Ивээх Сангийн боловсруулсан асуулгыг орчуулан, Монголын нөхцөлд тохируулан хэрэглэлээ. Уг судалгаанд ерөнхий боловсролын сургуулийн 6 (11-12 нас), 8 (13-14 нас), 10 (15-16 нас)-р ангийн сурагчдыг хамруулсан байна.
Судалгааны үр дүн	<ul style="list-style-type: none"> - Хүүхдүүдийн 18.9% нь төлбөрөөс болж сургуулийн ямар нэг үйл ажиллагаанд оролцож чадаагүй, 20.9% нь төлбөр, хувцас, хэрэгслээс болж чөлөөт цагийн үйл ажиллагаанд оролцож чадаагүй гэсэн нь анхаарал татам асуудал юм. Энэ нь орлого багатай өрхийн хүүхдүүд сургуулийн зарим үйл ажиллагаанд хамрагдах боломжгүйг илтгэж байгаа бөгөөд энэ хэрээр тэдний оролцоо, хөгжил хязгаарлагдаж байна гэсэн үг. - Хүүхдүүдийн 15.4% нь бусдад дээрэлхүүлж доромжлуулах вий гэж санаа зовдог бөгөөд хөвгүүдийн хувьд энэ тоо охидынхоос өндөр байна. - Хэдийгээр хүүхдүүдийн 56.2% нь Хүүхдийн эрхийн тухайн конвенцын талаар сонсож байгаагүй гэж хариулсан ч, 10 хүүхэд тутмын ес нь хүүхдийн эрхийн талаар сонсож байсан гэж хариулсан нь хүүхдүүдийн дунд ойлголт мэдээлэл нэмэгдэж байгааг харуулсан үзүүлэлт юм. - Ерөнхий боловсролын бүх сургуульд нийгмийн ажилтан байдаг ч хүүхдийн сэтгэлзүйн хэрэгцээ, асуудалд хандсан үйл ажиллагааг дорвитой хэрэгжүүлэхгүй байна гэж дүгнэж болно. Нийгмийн ажилтнууд сэтгэлзүйн анхан шатны үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй байдгийг хүүхдүүд мэддэггүй бөгөөд нийгмийн ажилтнууд тэдний нууцыг хадгалж чадахгүй байх гэж бодлогоо бүлгийн ярилцлагын үеэр хүүхдүүд хэлсэн байна. Тиймээс хүүхдийн хувийн нууцыг хадгалах, эрхийг хүндэтгэх чиглэлээр нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах бодлого, хариуцлагын тогтолцоотой болоход Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам анхаарах хэрэгтэй.
Судлаачийн дүгнэлт	Ерөнхий боловсролын бүх сургуульд нийгмийн ажилтан байдаг ч хүүхдийн сэтгэлзүйн хэрэгцээ, асуудалд хандсан үйл ажиллагааг дорвитой хэрэгжүүлдэггүй гэж байна. Мөн хүүхдүүд нийгмийн ажилтнуудад сэтгэлзүйн анхан шатны үйлчилгээ үзүүлэх байдгийг хүүхдүүд мэддэггүй бөгөөд өөрсдийн асуудлаа хэлбэл нууц хадгалахгүй байх вий гэдгээс эмээж байна. Тиймээс сургуулийн нийгмийн ажилтнуудын ажлын ёс зүй, хүүхдэд үйлчилгээ үзүүлж тэдний асуудлыг шийдэж өгч чадаж байгаа эсэхийг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ байна.
11. Хүүхдийн эрх ба хамгаалал, 2016	
Байгууллага	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйборс ОУБ-ын Монгол дахь Төлөөлөгчийн газар

Судалгааны зорилго	Энэхүү судалгааны зорилго нь хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид болон хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн хүүхдийн эрхийн талаарх мэдлэг ойлголт, хандлага, хэрэгжилтийн түвшин тодорхойлон гаргасан байна.
Судалгааны арга зүй	Түүвэрлэлтийн хувьд Монгол улсын зүүн, баруун, төвийн, хангайн гэсэн 4 бүсийн 8 аймгийн 23 сум болон Нийслэлийн 7 дүүргээс нийт 57 сургуулийг сонгон хамруулсан. Судалгаанд 11-18 насны 4,264 хүүхэд, 2,743 эцэг эх, асран хамгаалагч болон хүүхэд хамгааллын хамтарсан багийн 152 гишүүн хамрагдсан байна.
Судалгааны үр дүн	<ul style="list-style-type: none"> - “Хүүхдүүд хүүхдийн эрхийн талаарх ойлголт мэдээллийг хамгийн түрүүнд аав, ээжээсээ авдаг гэжээ. - Хүүхэд буруу хэрэг хийсэн бол “бие махбодын шийтгэл оногдуулах” нь зөв гэж үзэх хандлага хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдын аль алинд нь байсаар байна. - Ээж, аавууд хүүхэдтэйгээ сайн ярилцаж, болох болохгүйг ойлгуулах хэрэгтэй гэсэн санал хүүхдүүдээс гарч байсан ба энэ нь хүүхдүүд хүмүүжлийн эерэг арга хэрэглэхийг санал болгож байгаагийн тод жишээ юм. - Судалгаанд хамрагдсан 2 хүүхэд тутмын 1 нь буюу тал хувь нь “хэн нэгнээс айдаг” гэж хариулсан бөгөөд тэдний 45.3 хувь нь гэр бүлийн орчинд буюу өөрийн төрсөн эцэг эхээс (30.6 хувь) хамгийн их айдаг гэжээ. - Гэр бүлийн орчинд эцэг эхчүүд хүүхдийн эрхийг зөрчсөөр байна. Эцэг эх, асран хамгаалагчдын тал хувь нь хүүхдээ хүмүүжүүлэх зорилгоор хүүхдэдээ гар хүрч, хэл амаар доромжилж, бусад харьцуулж байгаа нь хүүхэдтэйгээ хэрхэн харилцах болон хүүхдийнхээ нас, сэтгэхүйн онцлогийн талаар мэдлэггүй байгаагаас гадна өөрийн уур бухимдлаа барьж чадахгүй байгаатай холбоотой байна. - Түүнчлэн судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн 52.9 хувь нь хүүхэд хүмүүжүүлэх арга мэдэхгүйгээс, 40.2 хувь нь хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогийг мэдэхгүйгээс, 49.6 хувь нь хүүхдийн эрхийн ойлголт, мэдлэг дутмагаас хүүхдийнхээ эрхийг зөрчдөг гэж хариулсан байна.
Судлаачийн дүгнэлт	Хүүхдүүд, хүүхдийн эрхийн талаарх ойлголт мэдээллийг хамгийн түрүүнд аав, ээжээсээ авч байна. Гэтэл хүүхдүүдийн эрх гэр бүлийн орчинд хамгийн их зөрчигдөөд байна. Иймээс эцэг эх, асран хамгаалагчийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадал ямар байгааг тодруулах шаардлага эндээс гарч байна.
12. Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа, 2014	
Байгууллага	Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, Эм Эм Си Жи ХХК
Судалгааны зорилго	Нийслэлийн 7 дүүргийн хүрээнд хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдал, түүний төрөл хэлбэрүүдийг үнэлэх зорилготой хийгдсэн судалгаа юм.
Судалгааны арга зүй	Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын захиалгаар нийслэлийн 7 дүүргт амьдардаг 11-17 насны хүүхдүүд, тэдний эцэг эх, асран хамгаалагчид болон 18-24 насны 400 хүүхэд, залуучуудаас тоон судалгаа авсан ба мэдээлэл цуглуулахдаа CAPI арга ашиглажээ.
Судалгааны үр дүн	<ul style="list-style-type: none"> - Судалгаанд хамрагдсан нийт эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдүүдээ хүмүүжүүлэхдээ 31.1 хувь нь эерэг хандлагатай хүмүүжлийн аргыг хэрэглэж байгаа бол 34.7 хувь нь бие махбодын хүчирхийллийн хэлбэртэй хүмүүжлийн арга, 34.2% нь сэтгэл зүйн хүчирхийллийн хэлбэртэй хүмүүжлийн аргыг ашигладаг байна. Үүнээс харахад судалгаанд хамрагдсан эцэг, эх, асран хамгаалагчдын 69 хувь нь хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүчирхийллийн шинжтэй арга барилыг ашиглаж байгаа ба хүүхдээ буруу зүйл дахин хийхгүй байлгах зөв арга гэж тэд үзэж байгаа юм. - Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдэдээ анхаарал халамж бага үзүүлдгийн улмаас судалгаанд хамрагдсан 10 хүүхэд тутмын 4 нь хэнд ч хэрэггүй, хэн ч түүний төлөө санаа тавихгүй, дэмжихгүй, туслахгүй байна гэсэн мэдрэмжийг мэдэрдэг байна.
Судлаачийн дүгнэлт	Хүүхдийг буруу зүйл хийхэд нь загнах, зодох хандлага эцэг, эх, асран хамгаалагч дунд одоог хүртэл байсаар байна. Багадаа зодуулж өссөн хүүхэд ирээдүйд хүүхдээ болон бусдыг хүчирхийлдэг болох нь “Хүчирхийллийн нүцгэн үнэн” тайланд дурдагдсан байсан. Иймээс Гэр бүлийн гишүүд тэр дундаа хүүхдийн хүмүүжил, төлөвшил, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлэх судалгааг олон улсад хэрэглэдэг арга, аргачлалын дагуу тогтмол зохион байгуулах, хүүхдэд тохиромжтой эерэг хүмүүжлийн хандлагыг тодорхойлж, төрийн бодлого, хөтөлбөрт ашиглах хэрэгцээ байна.

ХАВСРАЛТ 2. НАСАНД ХҮРЭГЧДЭЭС АВСАН АСУУЛГА

[ТАНИЛЦУУЛГА] Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг гэдэг. Би судалгаа, зөвлөх үйлчилгээний “Эм Эм Си Жи” компанийн судлаач байна.

[ЗОРИЛГО] Энэхүү судалгааг Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар манай компани гүйцэтгэж байна. Судалгаа нь насанд хүрэгчийн хүүхэд хамгааллын талаарх мэдлэг, хандлага, дадлыг судлах зорилготой.

[БАТЛАМЖ] Энэхүү судалгаа нь ойролцоогоор 20-25 минут орчим үргэлжилнэ. Та бүхний хэлсэн бүхий л зүйлд зөв болон буруу хариулт гэж байхгүй тул зөвхөн өөрийнхөө бодлыг чөлөөтэй илэрхийлээрэй. Таны өгсөн бүхий л хариултыг Монгол Улсын “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”, ОУ-ын судалгааны ёс зүйн код ESOMAR, ISO20252:2023 стандартад заасны дагуу чандлан хадгалах болно.

1. СУДЛААЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ

Ярилцлага авагчийн нэр, код:	
Ярилцлага авсан огноо (он/сар/өдөр): он сар өдөр
Ярилцлага эхэлсэн хугацаа (Цаг/минут): цаг минут
Ярилцлага дууссан хугацаа (Цаг/Минут): цаг минут
Дүүрэг:	Багануур дүүрэг Багахангай дүүрэг Баянгол дүүрэг Баянзүрх дүүрэг Налайх дүүрэг Сонгинохайрхан дүүрэг Сүхбаатар дүүрэг Чингэлтэй дүүрэг Хан-уул дүүрэг
Хороо	Click or tap here to enter text /Бичих...../

2 ХҮН АМ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ

2.1	Та хэдэн настай вэ?	1. 18-22 нас 2. 23-26 нас 3. 27-30 нас 4. 31-35 нас 5. 36-40 нас 6. 41-45 нас 7. 46-50 нас 8. 51-55 нас 9. 56-60 нас 10. 61-65 нас 11. 66 болон түүнээс дээш
2.2	Хүйс	1. Эрэгтэй 2. Эмэгтэй

2.3	Таны гэрлэлтийн байдал?	<ol style="list-style-type: none"> 1. Гэрлэлтээ албан ёсоор батлуулсан 2. Гэрлэлтээ албан ёсоор батлуулаагүй ч, хамтран амьдарч байгаа 3. Өмнө нь гэрлэж байсан [2.4 руу үсрэх] 4. Өмнө нь хамтран амьдрагчтай байсан [2.4 руу үсрэх] 5. Огт гэрлэж, хамтран амьдарч байгаагүй [2.5 руу үсрэх]
2.4	[2.3=3, 4 бол асуух] Хамтран амьдраагүй байгаа шалтгаан юу вэ?	<ol style="list-style-type: none"> 1. Салсан 2. Тусгаарласан 3. Бэлэвсэн/хамтрагч нас барсан 4. Хариулахаас татгалзсан
2.5	Та хөгжлийн бэрхшээлтэй юу?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм /Тийм бол ямар бэрхшээлтэй вэ/? 2. Үгүй
2.6	Ам бүлийн тоо	Click or tap here to enter text. /Тоог бичих...../
2.7	Та хэн хэнтэйгээ амьдардаг вэ? /Олон сонголттой/	<ol style="list-style-type: none"> 1. Аав буюу нөхөр 2. Ээж буюу эхнэр 3. Өөрийн хүүхэдтэйгээ 4. Бусдын хүүхэдтэй (Ач, зээ г.м) /Тийм бол хэдэн хүүхэд байна вэ?/ 5. Төрсөн ах, эгч, дүүтэйгээ /Тийм бол хэдэн хүүхэд байна вэ?/ 6. Өвөө/эмээтэйгээ /Тийм бол хэдэн хүүхэд байна вэ?/ 7. Хадмуудтайгаа /Тийм бол хэдэн хүн байна вэ?/ 8. Хамаатан садантайгаа /Тийм бол хэдэн хүн байна вэ?/ 9. Найз нөхөдтэйгөө /Тийм бол хэдэн хүн байна вэ?/ 10. Бусад /Бичих...../ /Тийм бол хэдэн хүн байна вэ?/
2.8	Танай өрхөд 18-аас доош насны хүүхэд байгаа юу?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй [2.14 руу үсрэх]
2.9	Өрхөд 18-аас доош насны хүүхэд байгаа бол та хүүхэдтэй ямар хамааралтай вэ? /Олон сонголттой/	<ol style="list-style-type: none"> 1. Аав 2. Ээж 3. Ах 4. Эгч 5. Эмээ 6. Өвөө 7. Хамаатан 8. Бусад /Бичих...../
2.10	[2.7=1 бол асуух] Танай өрхөд 18-аас доош насны хэдэн хүүхэд байгаа вэ?	<ol style="list-style-type: none"> 1. Нэг хүүхэдтэй 2. Хоёр хүүхэдтэй 3. Гурав хүүхэдтэй 4. Дөрвөн хүүхэдтэй 5. Таван хүүхэдтэй 6. Зургаан хүүхэдтэй 7. Долоогоос дээш хүүхэдтэй
2.11	Хүүхэд хэдэн настай вэ? /Хамгийн том хүүхдээс эхлэн насыг нь тэмдэглэх/	Click or tap here to enter text. /Бичих...../
2.12	Хүүхдийн хүйс тэмдэглэнэ үү? /Хамгийн том хүүхдээс эхлэн хүйс тэмдэглэх/	<ol style="list-style-type: none"> 1. Эрэгтэй 2. Эмэгтэй

2.13	Хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэх? /Хамгийн том хүүхдээс эхлэн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тэмдэглэх/	1. Тийм /Тийм бол ямар бэрхшээлтэй вэ/? 2. Үгүй
2.14	Амьдран суугаа хорооллын төрөл	1. Байшин хороолол 2. Гэр хороолол 3. Байшин болон гэр хороолол хосолсон
2.15	Амьдардаг сууцны төрөл	1. Орон сууцны байшин (байр) 2. Бие даасан тохилог сууц (хаус) 3. Сууцны тусдаа байшин 4. Монгол гэр 5. Нийтийн байр 6. Оюутны байр 7. Бусдын хашаа, байшинг түрээслэгч 8. Бусад /Бичих...../

Одоо танд хэд хэдэн бодомжууд уншиж өгье. Та эдгээр бодомжийг зөв болон буруу гэдэг хариултын хувилбараар зөвхөн өөрийн бодлоо илэрхийлнэ үү? [Бодомжуудыг сэлгэж асууна. Ингэснээрээ яг энэ дарааллын дагуу асуугдахгүй гэсэн үг юм]

3 ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ			
№	Бодомж	Зөв	Буруу
3.1	Хүүхдийг хүмүүжүүлэх зорилгоор зодож шийтгэх нь зөв үү, буруу юу?		+
3.2	Хүүхдэд ойлгуулахын тулд духыг нь няслах нь зодож байгаа хэрэг биш. Энэ нь зөв үү? Буруу юу?		+
3.3	Даалгавраа хийсэнгүй гэж багш нь сурагчид гар хүрэх эрхтэй. Энэ нь зөв үү? Буруу юу?		+
3.4	Хүүхдийг алдаа гаргасных нь төлөө хашраах зорилгоор гарыг нь өргүүлэн шийтгэх нь зөв үү, буруу юу?		+
3.5	Хүүхдийг хүчиндээгүй, зөвхөн эмзэг эрхтэнд нь хүрсэн бол бэлгийн хүчирхийлэл гэж үзэхгүй. Энэ нь зөв үү, буруу юу?		+
3.6	Хүүхдийг биеийнх нь онцлох шинжээр нэрлэн өхөөрдөх нь сэтгэл санааны хүчирхийллийн нэг хэлбэр. Энэ нь зөв үү? Буруу юу? Жишээлбэл: Шонтоохой, Улаанаа		+
3.7	Хүүхдийн хажууд +18 хэсэгтэй, агуулгатай кино, жүжиг, клип үзэх нь хүчирхийлэл мөн үү?	Тийм	Үгүй
3.8	Хүүхдийн дэргэд +18 агуулгатай онигоо, аливаа хэлц, хошигнол ярих нь зөв үү? Буруу юу?		+
3.9	Хүүхдийг бэлгийн хүчирхийлэлтэй жүжиг, клип, кинонд тоглуулах нь хүчирхийлэл мөн үү?	Тийм	Үгүй
3.10	Хүүхдийг хичээлгэхийн тулд бусад хүүхэдтэй харьцуулж шахаж, шаардах нь хүчирхийлэл мөн үү?	Тийм	Үгүй
3.11	Хүүхэд өөрөө хүсээгүй боловч түүний ирээдүйн төлөө дургүй секц, дугуйланд явуулах нь зөв үү, буруу юу?		+
3.12	Хүүхдийг даалгавраа хийж чадахгүй байх үед нь тэнэг, мангар гэж зэмлэхгүй байх нь чухал. Энэ нь зөв үү, буруу юу?	+	
3.13	Хүүхэд өвдсөн тохиолдолд эмчид үзүүлэхгүйгээр өөрсдөө мэдээд эм өгөх нь зөв үү, буруу юу?		+

3.14	Эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдэд хэрэгтэй бүх зүйлийг нь бэлдэж өгдөг хэдий ч завгүй учраас хүүхэдтэйгээ ярилцаж, хамт байж чадахгүй байхыг хүчирхийлэл гэж үзнэ. Энэ нь зөв үү? буруу юу?	+	
3.15	Хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь ганцааранг нь цоожилж орхиж болно. Зөв үү? Буруу юу?		+
3.16	Гэр бүл цуцлахад хүүхдээ авч үлдсэн эх эсвэл эцэг нь хувийн бардам зан гарган хүүхдийн тэтгэвэр авахгүй гэх, тэтгэврийн хойноос хөөцөлдөхгүй байх нь үл хайхрах хүчирхийлэл мөн. Энэ нь зөв үү? Буруу юу?	Тийм	Үгүй
3.17	Хүүхдийн өөрийнх нь сонирхол гээд үдшийн загвар өмсөх арга хэмжээнд ажиллуулах нь зөв үү буруу юу?		+
3.18	Хүүхдийн хувийн орон зайг хүндэтгэж байна гээд, цахим орчинд танихгүй хүмүүстэй дотно харилцахыг хүүхдийн нууцад тооцож анхаарахгүй байх нь зөв үү? Буруу юу?		+

4 ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ХАНДЛАГА

Одоо танд хэд хэдэн бодомж уншиж өгнө. Та эдгээр бодомжтой хэр санал нийлж байгаагаа 0-10 оноогоор яг дүн тавьж байгаа юм шиг хэлээрэй. 0 гэдэг нь огт санал нийлэхгүй байна, 10 гэдэг нь маш их санал нийлж байна гэсэн үг юм. [Бодомжуудыг сэлгэж асууна. Ингэснээрээ яг энэ дарааллын дагуу асуугдахгүй гэсэн үг юм]

Бие махбодын хүчирхийлэл												
4.1	Бид нар ч гэсэн аав ээждээ зодуулж өссөн тэглээ гээд буруудаж байгаа юм байхгүй байна гэдэгтэй хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
4.2	Бие махбодын шийтгэлийг уурандаа санамсаргүй үйлддэг гэдэгтэй та хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
4.3	Хүүхдэд хааяа нэг алганы амт үзүүлэх нь тэдний хүмүүжилд сайнаар нөлөөлнө гэдэгтэй хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
Бэлгийн хүчирхийлэл												
4.4	Хүүхдийн хажууд +18 кино үзэх нь хүчирхийлэл гэдэгтэй та хэр санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
4.5	Одоогийн охид өмсөж буй хувцас болон хийж буй үйлдлээсээ болоод бэлгийн хүчирхийлэлд өртдөг гэдэгтэй хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
4.6	Хүүхдийг хүсээгүй байхад биед нь хүрэх, үнсэх нь хүчирхийлэл гэдэгтэй хэр санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
Сэтгэл санааны хүчирхийлэл												
4.7	Хүүхдийн саналыг асууж, хамтын шийдэл гаргахгүйгээр түүний ирээдүйн төлөө дургүй секц, дугуйланд явуулах нь хүчирхийлэл гэдэгтэй хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
4.8	Буруу зүйл хийсэн хүүхдийг загнахаас өөр аргагүй байдаг гэдэгтэй хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10

4.9	Уйлж байгаа хүүхдээ болиулахын тулд “Би явлаа шүү”, “Ганцааранг нь үлдээнэ” гэж сүрдүүлж байж дуугүй болгодог гэдэгтэй хэр санал нийлэх үү?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
Үл хайхрах хүчирхийлэл												
4.10	Гэртээ хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэх нь байх л зүйл гэдэгтэй хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
4.11	Хүүхэд хөнгөн өвдсөн тохиолдолд эмчид үзүүлэхгүйгээр өөрсдөө мэдээд эм өгч болно гэдэгтэй хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
4.12	Хүүхэд харах хүн байдаггүй учраас хүүхдүүдээ гэрт нь түгжээд ажилдаа явахаас өөр аргагүй байдаг гэдэгтэй хэр санал нийлэх вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10

5 ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ДАДАЛ

Та сүүлийн нэг жилийн хугацаанд дараах үйлдлүүдийг гаргаж байсан уу? Хэрвээ тийм бол давтамжийг нарийвчлан асууна уу? [Гэр бүлд нь 0-18 насны хүүхэд амьдардаг оролцогчдоос асууна. Мөн бодомжуудыг сэлгэж асууна. Ингэснээрээ яг энэ дарааллын дагуу асуугдахгүй гэсэн үг юм]

№	Давтамж	1-2 удаа	3-5 удаа	6-10 удаа	>10 удаа	Өнгөрсөн жил үгүй	Хэзээ ч үгүй	Хариулах боломжгүй
Бие махбодын хүчирхийлэл								
5.1	Хүүхдийг өшиглөсөн.							
5.2	Хүүхдийн дух руу нясалсан							
5.3	Хүүхдийн толгой руу цохисон.							
5.4	Хүүхдийн чихийг мушгисан.							
5.5	Хүүхдийг чимхсэн.							
5.6	Хүүхдийг саваа, шүүр, шаахай, таяг, бүс гэх мэтээр цохисон.							
5.7	Хүүхдийг гарыг нь өргүүлж эсвэл юм өргүүлж зогсоосон.							
Сэтгэл санааны хүчирхийлэл								
5.8	Гэр бүлдээ байгаа хүүхдийг дүлий, залхуу зэргээр нэрлэж хочилсон.							
5.9	Хэлсэн зүйл чинь нэг чихээр нь ороод нөгөө чихээр нь гардаг гэхчлэн хүүхдийг загнасан							
5.10	Хүүхдийг бүтэлгүй, унхиагүй, өөдтэй хүн болохгүй гэхчлэн харааж загнасан.							
5.11	Бусдын буруутай үйлдэлд Хүүхдийг буруутгасан.							
5.12	Хүүхдийг бусдын өмнө эвгүй байдалд оруулсан.							

5.13	Хүүхдийг орхиж явна эсвэл гэрээсээ хөөнө гэж сүрдүүлсэн.											
5.14	Хүүхдийг бусадтай харьцуулсан.											
Үл хайхрах хүчирхийлэл												
5.15	Хүүхдийн хоол ундыг анхаараагүй											
5.16	Хүүхдийн хажууд архи, тамхи хэрэглэсэн.											
5.17	Хүүхдийг өвдсөн үед нь асрахгүй орхиж байсан.											
5.18	Хүүхэд томчуудын хараа хяналтгүй байдлаас болж бэртсэн.											
5.19	Хүүхдэд улиралд тохиромжгүй хувцас өмсгөсөн.											
5.20	Хүүхдийг гэрт нь цоожилж орхисон.											
5.21	Хүүхдээ цахим орчинд хэнтэй нөхөрлөж байгааг анхаараагүй											

6 ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖЛИЙН ТАЛААРХ НАСАНД ХҮРЭГЧДИЙН ХАНДЛАГА

Одоо танд хэд хэдэн өгүүлбэр уншиж өгнө. Та эдгээртэй хэр санал нийлж байгаагаа 0-10 оноогоор яг дүн тавьж байгаа юм шиг хэлээрэй. 0 гэдэг нь огт санал нийлэхгүй байна, 10 гэдэг нь маш их санал нийлж байна гэсэн утгатай.

Хүүхдээсээ зохисгүй зүйл хүлээх												
6.1	Хүүхдийг дуулгавартай, эцэг эхийнхээ үгийг дагадаг болгож хүмүүжүүлэх хэрэгтэй гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
6.2	Хүүхдэд нүүр өгвөл улам давардаг гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
6.3	Хүүхдүүд хэн ч байсан хамаагүй томчуудын үгэнд ордог, дуулгавартай байх ёстой гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
6.4	Одоогийн хүүхдүүд бүх юм нь бэлэн, жаргалтай өсөж байна гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
Хүүхдийнхээ оронд өөрийгөө тавьж ойлгох чадвар сул байх												
6.5	Эрэгтэй хүүхэд уйлах нь сул доройн шинж гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
6.6	Хүүхдийг үргэлж магтах нь түүний өөртөө итгэх итгэлийг бэхжүүлэх сайн арга гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
6.7	Хүүхэд анхаарал татахын тулд л уйлдаг гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
6.8	Эцэг эх нь хүүхдүүдээ ярилцахыг дэмжвэл тэдний гомдлыг л сонсоно гэсэн үг гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
Хүүхдэдээ үүргээ шилжүүлэх												

6.9	Хүүхдүүд гэртээ эмх цэгцтэй, томоотой байвал эцэг эх нь тайван байна гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
6.10	Айлын том хүүхдүүд дүү нараа асрах ёстой гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
6.11	Хүүхдүүд эцэг эхийн хэрэгцээг бодолцож байх ёстой гэдэгтэй хэр зэрэг санал нийлж байна вэ?	0	1	2	3	4	5	6	7	8	9	10
